

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2016 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**Бодлого, төлөвлөлтийн газар:*****Нэг. Салбарын бодлого, төлөвлөлтийн хүрээнд:***

“Улаанбаатар дулааны III цахилгаан станц”-ын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар, “Чойбалсангийн цахилгаан станц”-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар тус тус өргөтгөх тооцоо судалгааг хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллалаа.

Төвийн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний системийн эх үүсвэрийн дутагдлыг арилгах, эрчим хүчний хангамжийг найдваржуулах зорилгоор Улаанбаатар дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэх талаар холбогдох материал, танилцуулга, тогтоолын төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, “Эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 57 дугаар тогтоол гарсан.

Улаанбаатар дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулан, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шийдвэрийг Засгийн газраас өгч, 2016 оны 180 дугаар тогтоолыг гаргасан.

Дээрхи станцуудын өргөтгөлийн бэлтгэл ажлуудыг хангах, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 119 тушаалаар байгуулан ажиллаж байна.

Үйлдвэрлэсэн дулаан, цахилгааныг дамжуулах сүлжээний өргөтгөлүүдийн тооцоо судалгаануудыг хийсэн.

“Дарханы дулааны цахилгаан станцын 35 МВт-ын өргөтгөлийн төсөл”-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Эрчим хүчний сайдын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 16 дугаар тушаалаар Төслийн удирдах хороо, Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 18 дугаар тушаалаар Тендерийн үнэлгээний хороог тус тус байгуулсан.

Тендерийн үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкинд хүргүүлэн тендер зарлах тухай “үл татгалзах” захиаг авч тендерийг 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зарлан 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тендерийн материалыг хүлээн авсан. Үнэлгээ хийгдэж байна.

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын 35 МВт-ын өргөтгөлийн төсөл”-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 17 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан. Тендерийн үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан БНХАУ-Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу ирүүлсэн хураангуй жагсаалтад тусгагдсан 3 компанид урилга хүргүүлж, 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тендерийн материалыг хүлээн авсан. Үнэлгээний хороо ирүүлсэн материалуудыг судлан үнэлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгчтэй гэрээний хэлэлцээр хийхээр ажиллаж байна.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт баригдаж буй 10 МВт-ын нарны станцыг ашиглалтад хүлээн авч, Сонгинохайрхан дүүргийн нутагт баригдаж буй 10 МВт-ын нарны станцын барилга угсралтын ажилд хяналт тавьж, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 50 МВт хүчин чадалтай салхин цахилгаан станцын санхүүгийн хаалтын гэрээ хийж, барилгын ажил эхлэх шавийг тавьлаа.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Японы Шигэмицу Шожи болон Шарп компанийн хөрөнгө оруулалтаар 10 МВт-ын нарны станцыг “Солар повер интернейшнл” компани барьж, 2016 оны 12 дугаар сард ашиглалтад орууллалаа.

Сонгинохайрхан дүүргийн нутагт баригдаж буй “Мон наран” ХХК-ийн 10 МВт-ын нарны станцын эхний ээлжийн 2 МВт-ын станцыг Японы “Фарм дү” компани хөрөнгө оруулж барилга угсралтын ажил хийгдэж байна. Хоёрдугаар шат буюу ногооны хүлэмж бүхий нарны станц төсөл нь 2017 онд угсралт нь хийгдэж 2018 онд ашиглалтанд орохоор төлөвлөж байна.

Европын сэргээн босголт хөгжлийн банк, Япон Улсын Жайка байгууллага, Монгол Улсын Ньюком ХХК, Япон Улсын “Эс Би Энержи” ХХК-иудын 128 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 50 МВт хүчин чадалтай салхин цахилгаан станц байгуулах санхүүжилтийн хаалтын гэрээнд 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурж, төслийн барилга угсралтын ажил эхлэх нөхцлийг бүрдүүлсэн. Төслийн ажлыг эхлүүлэх шавь тавих ёслолыг 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хийсэн. Барилга угсралтын ажил 30 хувьтай байна.

Монгол Улсад том чадлын усан цахилгаан станц барих зорилтын хүрээнд Эгийн голын 315 МВт-ын усан цахилгаан станцыг барихаар төлөвлөн шаардлагатай ТЭЗҮ, судалгаануудыг хийх ажлыг эхлүүлээд байна.

Эгийн голын усан цахилгаан станцыг барихад шаардлагатай урьдчилсан тооцоо, судалгаануудыг хийж байгаа бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдөр болсон Орос-Монголын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засгийн болон шинэжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны 20 дугаар худалдаанаар энэхүү төслийн талаар ярилцаж, цаашид усны аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах, Байгаль нуурын биологийн зүйлийн чиглэлээр хараат бус гадаадын компаниудаар судалгааг хийлгэх, энэхүү судалгааны багт ОХУ, Монголын судлаач эрдэмтдийг оролцуулах талаар харилцан ярилцсан бөгөөд цаашид ОХУ-ын зарим нэр бүхий компаниудтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах, Монгол Улсын нутаг дэвсгэрт барих усны барилга байгууламжийн иж бүрэн төсөл дээр хамтарсан ажлын хэсэг байгуулахаар тохиролцсон.

Эгийн голын усан цахилгаан станцыг барьснаар Монгол улсын эрчим хүчний системийн бие даасан байдлыг хангаж, эрчим хүчний чадлын бүтцийг өөрчлөн сайжруулж, тогтвортой ажиллагааг дээшлүүлэх, эрчим хүчний нөөцтэй болж, оргил ачаалал, горим тохируулгыг хийх техникийн боломж бүрдэх юм.

Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих төслийг БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх хэлэлцээрийг үргэлжлүүлж, санхүүжилтийг шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.

Төслийг БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх өмнөх хэлэлцээрүүдийг яаралтай үргэлжлүүлэх болон төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг БНСУ-ын талаар гүйцэтгүүлэх хүсэлтийг уламжилж, хамтран ажиллах тухай 2016.09.12-ны а/2293, 2016.09.16-ны 2/2349 тоот албан бичгүүдийг Сангийн яаманд хүргүүлэв.

БНСУ-ын “Экспорт-Импорт” банкны газрын дарга Пак Юу Соны 2016 оны 11 дүгээр сард манай улсад албан томилолтоор ирж, төслийн товч техник эдийн засгийн үндэслэлтэй танилцаж, техникийн экспертүүдийг ирүүлэхээр харилцан тохиролцсон.

Төсөл хэрэгжих 8 аймгийн төвд баригдах дулааны станц, дулааны шугам сүлжээний Техник, эдийн засгийн үндэслэлийг англи хэл дээрхи орчуулгыг Сангийн яамаар дамжуулан БНСУ-ын талд хүргүүлсэн.

Эрчим хүчний нүүрс олборлогч Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудыг санхүүгийн хүндрэлээс гаргах, өвлийн бэлтгэлийг хангах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудлыг шийдвэрлүүлэх.

Эрчим хүчний нүүрс олборлогч Багануур, Шивээ-Овоогийн уурхайн өнөөгийн байдалтай газар дээр нь очиж танилцан уурхайн найдвартай ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, цаашид авах арга хэмжээний тухай саналыг боловсруулан 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 338 дугаар тогтоолын биелэлтийг хангаж ажиллахаар шийдвэрлүүлсэн. Тус тогтоолын хүрээнд “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийн найдвартай ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор Сангийн яамтай хамтран төсвийн зээлийг олгоод байна. Одоо “Багануур” ХК 250.0 мян.тн, “Шивээ-Овоо” ХК 564.0 мян.тн тус тус авахад бэлэн нүүрстэй байна.

Эрчим хүчний нэгдсэн систем үүсгэгч цахилгаан дамжуулах сүлжээнүүдийг барих, өргөтгөх зорилтын хүрээнд Улаанбаатар-Мандалговь, Оюутолгой-Цагаансуварга, Багануур-Чойр, Хөшөөт-Алтайн цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Чойр дэд станцыг өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр холбогдох шийдвэрүүд гарлаа.

Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих төслийг БНХАУ-ын Экспорт-Импорт банкны нэг тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Ерөнхий хэлэлцээрийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 120 дугаар тушаалаар байгуулж, сонгон шалгаруулалтыг зохих хууль, журмын дагуу явуулж “ТВЕА” компанийг шалгаруулсан ба барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсэг ажиллаж, 7 дугаар сарын 5-ны өдөр гэрээ байгуулсан болно.

Тус төслийн байгаль орчны ерөнхий үнэлгээг хийж төслийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт ирүүлсэн тул Сангийн яаманд байгаль орчны ерөнхий үнэлгээг зохих журмын дагуу БНХАУ-ын Экспорт, импортын банкинд хүргүүлэх тухай 2016.10.07-ны өдрийн В/2552 тоот албан бичиг хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 87 дугаар тогтоолын дагуу Оюутолгой-Цагаансуваргийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц төслийн ажлыг “Барих-шилжүүлэх” нөхцлөөр “МАК” компанитай “Шууд гэрээ” байгуулах концессын гэрээний

төслийг бэлтгэж, 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн.

Оуютолгой-Цагаансуваргийн 220 кВ-ын 2 хэлхээт 159.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих техникийн нөхцөл, зургийн даалгаврыг өгсөн бөгөөд зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэн улсын экспертизээр батлуулж, эрчим хүчний салбарт олон жил барилга угсралтын ажил гүйцэтгэж буй туршлагатай дараахь компаниудаар гүйцэтгүүлж байна.

Үүнд:

1. “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-иар 42.9 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил
2. “Эрчмийн Ундраа” ХХК-иар 35.9 км шугам, 220/22 кВ-ын 2*75 МВА чадалтай дэд станцын барилга угсралтын ажил
3. “Илч Хангай” ХХК-иар 48.3 км урттай шугамын барилга угсралтын ажил
4. “Багануур Энерги” ХХК-иар 32.3 км урттай шугамын угсралтын ажлуудыг тус тус гүйцэтгүүлж байна.

Өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил 45%-тай үргэлжилж байна.

Багануур-Чойр, Хөшөөт-Алтайн цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Чойр дэд станцыг өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар 07-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулан, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шийдвэрийг Засгийн газраас өгч, 2016 оны 180 дугаар тогтоолыг гаргасан.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний төлбөрийг чөлөөлөх шийдвэрийг гаргаж, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хүрээнд:

Эрчим хүчний нүүрс олборлогч Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн найдвартай ажиллагааг хангах, олборлолтыг хэвийн явуулахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч, холбогдох шийдвэрийг гаргуулсан.

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Багануурын хүрэн нүүрсний уурхайн өргөтгөлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулан төслийг УУЯ-ны /хуучин нэрээр/ Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Эрчим хүчний яам, “Эрдэнэс-Монгол” ХХК болон “Багануур” ХК-д хүлээлгэн өгсөн.

“Багануур ХК” болон “Шивээ-Овоо” ХК-иудын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний хуралдаанаар хэлэлцүүлэн тус 2 уурхайд 2016 онд 20.0 тэрбум төгрөгийн төсвийн зээл олгохоор шийдвэрлүүлэн, Сангийн яам, Эрчим хүчний яам, уурхай хооронд хамтарсан гэрээ байгуулан ажилласан.

“Багануур ХК”-нд 16.8 тэрбум төгрөг, “Шивээ-Овоо” ХК-нд 3.2 тэрбум төгрөгийн төсвийн зээл тус тус олгогдсоноор 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдан, уурхай дээрх авахад бэлэн нүүрсний нөөц 260.0–400.0 мян.тн-д хүрч, эрчим хүчний түлшний хангамжийг бүрдүүлэн дулааны станц, цахилгаан станцуудын гадна талбай дээрх нүүрсний нөөц 15-17 хоногт хүрчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 45 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрхи уурхайнуудын тулгамдсан асуудлаар “Эрдэнэс-Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захиралтай уулзаж санал солилцон, дизель түлш нийлүүлэгч компаниуд болон нүүрсний уурхайнуудын хооронд үүссэн өр, авлагыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулав.

Түлш, эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

Түлш, эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 компаний дүнгээр 2016-2017 оны өвлийн бэлтгэл хангахад үндсэн болон туслах тоноглолын их засварт 50,807.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтад 22,977.7 сая төгрөг, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 25,197.1 сая төгрөг, нийт 98,982.2 сая төгрөгийн засвар шинэчлэлийн ажил хийхээр төлөвлөсөн байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын өвлийн бэлтгэл хангах ажлын хүрээнд их засварын ажлаар 680, хөрөнгө оруулалтын ажлаар 489, техникийн зохион байгуулалтын арга хэмжээгээр 368, нийтдээ 1537 нэр төрлийн ажил хийжээ.

Нийслэлийн захын гэр хорооллын Сонгинохайрхан 22, 24, 26, 28, 30, 31, Баянзүрх 21, 27, Хан-Уул 12, 14, Сүхбаатар 14, 16, 17, 20, Чингэлтэй 17, 19 дүгээр хорооны нийт 22 байршилд гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай 1562 айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангалаа.

Эрчим хүчний сайдын 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 11 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан Нийслэлийн гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл, өрхийн цахилгаан хангамжийн дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо болон “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-тай хамтран Эрчим хүчний компаниудын нөөц бололцоонд тулгуурлан 2 тэрбум төгрөгийн санхүүжилтын асуудлыг шийдвэрлэн 2016 оны 09 дүгээр сарын 05-аас 10 дугаар сарын 03-ны хооронд барилга угсралтын ажлыг бүрэн хийж гүйцэтгээд байна.

Тус барилга угсралтын ажлыг нийт 36 багц болгон хувааж Эрчим хүчний барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудаар сар хүрэхгүй хугацаанд гүйцэтгэх ажлыг зохион байгуулан, ажлын гүйцэтгэлд тус яамны БХЗГ-ын мэргэжилтэнүүд, “УБЦТС” ТӨХК-ийн инженер техникийн ажилтнуудтай хамтран байнгын хяналт тавин ажиллан 2016.10.03-09-ны өдрийн хороонд ашиглалтад хүлээн авах комисс ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн барилга угсралтын ажилд хяналт тавьж, техникийн болон улсын комиссоор хүлээн авлаа.

- Дорноговь аймгийн Цагаан суварга-Мандахын 22 кВ-ын ЦДАШ, дэд станц.
- Хэнтий аймгийн Багануур-Цэнхэрмандалын 35 кВ-ын цахилгаандамжууланагаарыншугам, дэдстанц.
- Эрчим хүчний төвлөрсөн системд холбох /Говь-Алтай аймгийн Бугат сум, Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сум/.
- Дархан хотын 110/6 кВ-ын "Давхар" дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/.
- ДЦС-2-ийн зуухны шинэчлэл /Улаанбаатар/.
- Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/.
- Амгалан дэд станцаас кабель шугам татаж ХТП208-ын дэргэд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих /Улаанбаатар/.
- Дархан хотын 110/6 кВ-ын "Бурхант" дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/.

- Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах/Улаанбаатар/

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар:

Нэг. Эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:

Дулааны цахилгаан станц, дулааны станц, дулааны шугам сүлжээнүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар шинээр болон он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, барилга угсралтын ажил дууссан объектод ашиглалтад оруулах техникийн комиссыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, улсын комиссыг Эрчим хүчний сайдын тушаалаар тус тус томилон ажиллуулж, ашиглалтад оруулах, хүлээн авах ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

Амгалан дулааны станцыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2016.03.15-21-ний өдрүүдэд ажиллан, дутуу ажил, комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэв. Дутуу ажил, үүрэг даалгаварын жагсаалт, хурлын тэмдэглэлүүдийг гаргасан бөгөөд комиссын гишүүдээс нийт 98 нэр төрлийн үүрэг даалгавар өгөгдсөн. Гэрээ болон зурагт тусгагдаагүй, барилга угсралтын явцад нэмэлтээр хийгдсэн 20 нэр төрлийн ажлын талаар Амгалан дулааны станцын ашиглалтын өмнөх захиргаа, СМЕС компани, MSC-ийн техник хяналтын багийг оролцуулсан хуралдаан зохион байгуулж, шийдвэрлэсэн. Мөн дутуу ажил, үүрэг даалгаварыг 6-р сард багтаан гүйцэтгэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахаар ЭХХТ, төслийн нэгж, гүйцэтгэгч компаниудын төлөөлөлд үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаварын хүрээнд станцын хими ус бэлтгэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилтай холбогдуулан газар дээр нь танилцан, технологийн шаардлагад нийцүүлэн, эсрэг осмосын тоног төхөөрөмжийг буулгахгүйгээр техникийн шийдэл гарган угсралтын ажлыг гүйцэтгэх тухай 2016.05.03-ны өдрийн 4/1303 албан тоотыг “Амгалан ДС” ХХК-д хүргүүлсэн. Үүрэг даалгаварын биелэлт, гүйцэтгэлийн талаар ажлын хэсгийн хүрээнд хэд хэдэн удаа хэлэлцэж, ус хангамж, дулааны шугам сүлжээ, хими ус цэвэрлэгээний дутуу ажлуудыг түргэвчлэн, яаралтай дуусгах, анхаарч ажиллах талаар холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар чиглэл өгч ажилласан. Мөн газар дээр нь удаа дараа хяналт тавин ажиллаж, 2016.11.17-ны өдөр улсын комисс эцсийн байдлаар хуралдан байнгын ашиглалтад хүлээн авсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК-ийн зуух№2-ын шинэчлэлийн ажлыг ашиглалтад оруулах улсын комиссыг 2016.03.11-ний өдөр ажиллуулан, байнгын ашиглалтад хүлээн авсан.

ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн ДЦС-4-ийн турбины конденсаторын хоолойг ажиллагааны явцад цэвэрлэх систем, эргэлтийн усны шүүлтүүр суурилуулах ажлыг ашиглалтад оруулах улсын комиссыг 2016.05.02-ны өдөр ажиллуулан, байнгын ашиглалтад хүлээн авсан.

Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 2013/6 багц, Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр Батлан хамгаалахын сургууль орчмын гэр хороолол дахин төлөвлөлтийн 2 ширхэг ус дулаан дамжуулах төв, Ф80/300 мм-ийн 2010 метр дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажлыг

ашиглалтад оруулах улсын комиссыг 2016.12.15-ны өдөр ажиллуулан, байнгын ашиглалтад хүлээн авсан.

Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 2Ф700 мм-ийн голчтой 4 км дулааны шугамын барилга угсралтын ажилд хяналт тавин дуусгуулж техникийн комиссыг ажиллуулан, Эрчим хүчний сайдын 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 23 дугаар тушаалаар улсын комиссыг томилон гүйцэтгэгч “Хасу-Мегаватт” ХХК-д үүрэг, даалгавар өгч ажилласан. Уг шугамын нягтын шахалт, угаалтын хөтөлбөрийг баталж сүлжээнд залгасан, хэвийн ажиллаж байна.

Япон улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих бүтээн байгуулалтын хүрээнд баригдаж буй Дулааны станц, дулааны шугам сүлжээний барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссыг 2016.12.12-ны өдрийн 125 дугаар тушаалаар томилон, комиссыг 2016.12.13-15-ны өдрүүдэд ажиллуулсан. Техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах” төслийн хүрээнд баригдаж буй дулааны станц, шугам сүлжээний техникийн комиссыг 2015.11.24-26-ны өдрүүдэд ажилласан бөгөөд комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Үүрэг даалгаварын хүрээнд орон нутгийн зүгээс зохион байгуулах, станц, шугам сүлжээг ажиллагаанд залгах, ДС-д хэрэглээ холбох, хэрэглэгчийн шугам сүлжээг шинэлэх ажлыг хийх тухай 2016.01.26-ны өдрийн 4/304 албан тоотыг Дорноговь аймгийн ЗД, Замын-Үүд сумын ЗД, Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар хотын дулааны 12а магистраль шугам, насос станцын барилга угсралтын явцад байнгын хяналт тавин ажиллаж байна. ЭХХТ, гүйцэтгэгч “Альянс тех” ХХК, зургийн автортой хамтран уг ажлын дуусгах тодотгосон төлөвлөгөө, бусад зохион байгуулалтын ажлуудыг хийж хэрэгжүүлэх талаар хуралдсан. Уг ажил удаашралтай байгаа бөгөөд шалтгаан нь Оргил худалдааны төвийн худалдаа үйлчилгээнд нөхөн төлбөр, зам талбай сэргээх зардлын баталгааг “Сээкл” ХХК нь гүйцэтгэгчээс шаардсан байна. Тус компанид нөхөн сэргээх ажилд төлөвлөсөн зардлын хүрээнд ажлыг хийнэ, харин худалдаа үйлчилгээний нөхөн төлбөр, бусад баталгаанд хөрөнгө гаргах боломжгүй, тухайн ажлыг саад учруулахгүй, ажлыг гүйцэтгүүлэх тухай албан мэдэгдлийг хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 118 дугаар тогтоол “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй “Ирээдүй цогцолбор” хорооллын дулаан 4100 м гол шугам, 6ш ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлын график, төлөвлөгөөг шинэчлэн гаргуулж хяналтад авсан. Уг ажлыг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгах график гаргасан. Ажлын явцыг эрчимжүүлэх тухай 2016.05.05-ны өдрийн 4/1331 албан тоотыг ЭХХТ, “Мегаватт” ХХК-д хүргүүлсэн. Дулаан дамжуулах төв, шугам сүлжээний угсралтыг ЭХХТ, “УБДС” ТӨХК-тай хамтран газар дээр нь шалган холбогдох чиглэлээр, мөн яамны ХШҮДАГ-тай хамтран ажлыг эрчимжүүлэх шаардлагыг удаа дараа гүйцэтгэгч компанид өгсөн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Булган аймгийн төвд баригдаж буй дулааны станцын барилга угсралтын ажилтай 2016.05.23-26-ны өдрүүдэд газар дээр нь танилцан холбогдох үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмж өгч ажиллаа. Гүйцэтгэгчээр “Энержи плас” ХХК ажиллаж байгаа бөгөөд дулааны станцын барилга угсралтын ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Туслах тоноглолуудын угсралт, барилга битүүлэх, засах, гадна зам талбай тохижилтын ажил хийгдэж байна.

“ДЦС-4”-өөс У-18 хүртэл 4,2 км Ф800 мм-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажилд хяналт тавин ажиллаж байна. Гүйцэтгэл 78%-тай байна.

Баянголын амны дулааны шугам сүлжээний шинэчлэлийн ажилд хяналт тавин ажиллаж байна. Уг ажлын явцад гарсан хүндэрлүүдийг газар дээр нь үзэж “Улаанбаатар дулааны сүлжээ” “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн холбогдох төлөөллүүдийг оролцуулан хурал зохион байгуулж үүрэг даалгавар, албан тоот өгч ажилласан.

Цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээ, дэд станцуудад улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар шинээр болон он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, барилга угсралтын ажил дууссан объектод ашиглалтад оруулах техникийн комиссыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, Улсын комиссыг Эрчим хүчний сайдын тушаалаар тус тус томилон ажиллуулж, ашиглалтад оруулах, хүлээн авах ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

Улаанбаатар хотын захын гэр хорооллын хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийн цахилгаан эрчим хүчний хангамжийг найваржуулах, шинээр газар олголт хийгдсэн 1562 айл өрхийг эрчим хүчээр хангах ажлыг 2016 оны 09 дүгээр сараас 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор нийт 40 орчим байршилд 2 тэрбум төгрөгийн барилга угсралтыг ажлыг хийж гүйцэтгэн ашиглагч “УБЦТС” ТӨХК-нд хүлээлгэн өгсөн.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумыг төвлөрсөн цахилгаан эрчим хүчний системд холбох Цагаан суварга-Хатанбулаг сумын 35кВ-ын 120км ЦДАШ, 22/35 кВ болон 35/10 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажил дуусч, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний 06 дугаар тушаалаар техникийн комисс, Эрчим хүчний сайдын 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 56 дугаар тушаалаар Улсын комисс ажилласан бөгөөд 09/2016 акт гарч ашиглалтад хүлээн авсан.

Дорноговь аймгийн Мандах сумыг төвлөрсөн цахилгаан эрчим хүчний системд холбох Цагаан суварга- Мандах сумын 22 кВ-ын 60.6 км ЦДАШ, 22/0.4 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажил дуусч эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 дугаар сарын 11-ний 122 дугаар тушаалаар техникийн комисс, Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангуулахаар холбогдох үүрэг даалгавар өгсөн.

Эрчим хүчний сайдын 2015 оны багцад тусгагдсан “Багануур-Цэнхэрмандал” сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг дуусч, эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 172 тушаалаар техникийн комиссыг томилон ажиллуулсан, 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 172/10/2016 тоот техникийн комисс, Эрчим хүчний сайдын 2016 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 45 тоот тушаал, Эрчим хүчний сайдын 2016 оны 08 дугаар сарын 25-ны 14/2016 тушаалаар Улсын комиссын ажиллан ашиглалтад хүлээн авсан.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Сүхбаатар аймгийн Баруун-Урт – Асгат – Эрдэнэцагаан сумын 35 кВ-н ЦДАШ, дэд станцын БУА-д хяналт тавин ажиллаж, угсралтын ажлыг яаралтай дуусгах, ажиллаж буй бригадын тоог нэмэгдүүлэх, холбогдох үүрэг даалгавар чиглэл өгч ажилласан. Гүйцэтгэл 95%-тай байна. Тус шугамын барилга угсралтын ажлыг 2016 оны 12 дугаар сарын 27-29-ны хооронд техникийн комисс ажилласан.

Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Улаанбаатар хотын “Их тойрог” 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын 220/110/35 кВ-ын “Улаанбаатар” дэд станцаас “14-р хороолол” дэд станц хүртэлх 110 кВ-ын 7.2 км 2 хэлхээт ЦДАШ-ын барилга байгууламжийн угсралтын ажил дууссантай холбогдуулан ашиглалтад оруулах техникийн комиссын 183 тоот тушаал гаргасан.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Улаанбаатар хотын “Их тойрог” 110кВ-ын 97 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10кВ-ын 2х40МВА дэд станц/Улаанбаатар/ төслийн хүрээнд хийгдсэн Улаанбаатар хотын их тойрогийн “Зайсан” 110/35/10кВ-ын 2х40МВА хүчин чадалтай дэд станцаас “14 дүгээр хороолол” дэд станц хүртэлх 110 кВ-ын хоёр хэлхээт 2 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил дууссан тул ашиглалтад хүлээн авах улсын комиссын тушаал гаргасан.

Монгол улсын Засгийн газар, Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулсан хөнгөлттэй зээл /МОН-Р8, МОН-Р12/-ийн хөрөнгөөр санхүүжиж буй Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын цахилгаан хангамжийн 10 кВ-ын хуваарилах байгууламж, шугам, 10/0.4кВ-ын дэд станцын барилга байгууламжийн угсралтын ажил дууссантай холбогдуулан ашиглалтад оруулах техникийн комиссыг ажиллуулав.

Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 85 дугаар тушаалаар Эрчим хүчний салбарыг зах зээлийн зарчмаар ажиллах, эдийн засгийн бие даасан байдлыг бүрдүүлэх, хэмнэлт, үр өгөөжийг дээшлүүлэх үйлдвэрлэлийн аюулгүй найдвартай ажиллагааг хангуулан ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс салбарын үйлдвэр, компаниудын 2017 оны бизнес төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүтээгдэхүүний үнийн өсөлтөд бодит нөлөө үзүүлэх зардал, орлогын болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж хянан хүлээн авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн тушаал гаргасан.

Үүний дагуу 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 08-ны өдрийн хооронд Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын 2017 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлах хурлыг зохион байгуулан төслийг хянан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн.

Хөвсгөл аймгийн төвд баригдсан Дулааны станц, дулааны шугам сүлжээг улсын комиссоор хүлээн авсантай холбогдуулан ашиглалтын өмнөх захиргааг татан буулгасан. Аймгийн хүсэлтийн дагуу төрийн өмчит компани байгуулах тухай танилцуулга, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын 2016.04.11-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 2016 оны 206 дугаар тогтоол гаргуулсан.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт Ховд гол дээр усан цахилгаан станц баригдах төслийн талбай дээр тус ажлыг хийж гүйцэтгэх санал ирүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Yooshin Engineering компанийн төлөөлөл, Монгол Улсад Бүгд Найрамдах Солонгос Улсаас суух элчин сайд У Сонг холбогдох хүмүүстэй танилцах ажлыг зохион байгуулсан. Энэ үеэр Ховд аймгийн удирлагуудын хүсэлтээр өвлийн бэлтгэл хангах, цахилгаан хангамжийг сайжруулах чиглэлээр уулзалт зохион байгуулсан.

Монгол Улсын их хурлын гишүүн Я.Санжмятаваас Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Төсвийн тухай” хуулийн 17.1.10 дэх зүйлд заасан “Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт”-ийн ажлыг 2014-2016 онд хэрэгжүүлэхээр нийт 17 тэрбум төгрөгийг төлөвлөн хэрэгжүүлж байгааг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Рашаант баг, Их-Уул сумын Хуягт багуудыг эрчим хүчээр хангах ажлыг яаралтай дуусгах албан тоот ирүүлсэн. Уг ажлын эрх Завхан аймгийн Засаг дарга Ж.Жамъяантивд шилжсэний дагуу орон нутгаас тендер зарлан, гүйцэтгэж байгаа ажлын чанар гүйцэтгэлд анхаарч

яаралтай дуусгах арга хэмжээ авч ажиллах тухай 2016 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн в/1396 тоот албан бичиг хүргүүлсэн.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дараах 4 ажлын техникийн комисс, 6 улсын комиссыг тус тус ажиллуулсан. Үүнд:

Мөнхийн баян гал ХХК-ийн хөрөнгө оруулалтаар “Энержи Стар” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 110/35/10 кВ-ын “Налайх” дэд стацын өргөтгөл, 110 кВ-ын “7-р зөрлөг-Баганхангай” цахилгаан дамжуулах агаарын шугам, тус шугамын дундаас 7-р зөрлөг дэд станц хүртэлх 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Багахангай дүүрэг, Өндөр толгойд шинээр 110/35/10 кВ-ийн 16МВа хүчин чадалтай дэд станц, 110/10 кВ-ын Цементийн үйлдвэрийн шинэ дэд станцын барилга угсралтын ажлуудын өмчлөл, хөрөнгийн талаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Мөнхийн баян гал ХХК, “Энержи Стар” ХХК-уудын хамтран хурал хийж, ашиглалтыг эрчим хүчний хуулийн дагуу дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэн өгөх шийдвэр гаргасан. Хөрөнгө оруулагч “Мөнхийн баян гал” ХХК-ийн гаргасан хөрөнгө оруулалтыг буцааж улсаас авах талаар холбогдох эрх бүхий газарт тавьж шийдвэрлүүлэхээр болсон.

“БЭРЭН ГРУПП” ХХК-нд Монгол улсын төсөв, БНХАУ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр Барилга, хот байгуулалтын яамнаас хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төслийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй орон сууцны хорооллуудын гадна цахилгаан хангамжийн 4 ком хуваарилах байгууламж, 14 ком хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн гүйцэтгэгч компани чанарын шаардлага хангахуйц түвшинд хийж гүйцэтгээгүй ажлыг Барилга хот байгуулалтын яам болон БХБЯ-ны “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төслийн нэгжид хандаж асуудлыг шийдвэрлүүлэх тухай 2016 оны 06 дугаар сарын 09-ний в/1725 албан тоот хүргүүлсэн.

Аж үйлдвэрийн яамнаас ирүүлсэн “Замын-Үүд-Эрээний хил дамнасан чөлөөт бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлтэй танилцаж санал хүргүүлсэн.

Улсын их хурлын гишүүн Ш.Түвдэндоржоос ирүүлсэн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 12 байршилд баригдах орон сууцны хорооллыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралтын ажлын талаархи танилцуулгыг бэлдэж 2016.06.21 өдрийн а/1848 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шинээр баригдах өргөтгөлийг цахилгаан эрчим хүчээр хангах схемийг шийдлийг гарган, Концессын жагсаалтад нэмэлт оруулах тухай хүсэлтийг 2016 оны 05 дугаар 25-ны өдрийн а/1571 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрт ирүүлсэн хүсэлтийн дагуу схемийн шийдэл гарган, зураг, төсвийг бэлэн болгож байх тухай 2016 оны 05 дугаар 25-ны өдрийн а/1572 тоот албан бичиг хүргүүлсэн.

Монгол улсын 2013 оны төсвийн хөрөнгө оруулалтаар “Төвийн эрчим хүчний тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл” төслийн хүрээнд хийгдсэн ажлын хөрөнгийн өмчлөлийн талаар “ДҮТ” ХХК болон “ЦДҮС” ТӨХК-тай хийсэн хурлын тэмдэглэл хөтөлсөн.

Ховд аймгийн Мянгад сумын нутагт шинээр баригдах 10 МВт-ын нарны цахилгаан станцын Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-тай байгуулах бүтээгдэхүүн худалдах, худалдан авах тухай гэрээний төсөлд өгөх санал боловсруулсан.

Улаанбаатар-Мандалговийн ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээний хэлцэл хийж, гэрээг байгуулсан. Түлхүүр гардуулах гэрээний төслийг боловсруулан, ажлын хэсгийг хуралдуулан ажилаа.

110 кВ-ын “Улаанбаатар-7-р хороолол-Радио телевиз” цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын “7-р хороолол” дэд станц, 110/35/10 кВ-ын “Радио телевиз” дэд станцын барилга угсралтын ажил дуусч, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 235 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан хүчдэлд залгасан. 110/35/10 кВ-ын “Баянгол” /Найрамдал/ дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн барилга угсралтын ажил дууссан тул Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 258 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан хүчдэлд залгасан. Эрчим хүчний сайдын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 57 дугаар тушаалаар улсын комисс томилсон.

110 кВ-ын “Улаанбаатар-7-р хороолол-Радио телевиз” цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ-ын “7-р хороолол” дэд станц, 110/35/10 кВ-ын “Радио телевиз” дэд станцын барилга угсралтын ажил дуусч, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 235 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан хүчдэлд залгасан. 110/35/10 кВ-ын “Баянгол” /Найрамдал/ дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн барилга угсралтын ажил дууссан тул Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 258 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан хүчдэлд залгасан. Эрчим хүчний сайдын 2016 оны 11 дүгээр сарын 01-ний 58 дугаар тушаалаар улсын комисс томилсон.

110 кВ-ын “Улаанбаатар-14-р хороолол” цахилгаан дамжуулах агаарын шугамын 220 кВ-ын “Улаанбаатар” дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн барилга угсралтын ажил хийгдэж дууссан тул Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 256 тоот тушаал техникийн комисс томилсон. Гүйцэтгэгч компанийн хариуцлагагүй улмаас ажлаа дуусаагүй, 3 тулгуур босгох ажил дутуу байсан бөгөөд тулгуур босгох утас татах ажлыг гүйцэтгэгч Аркади ХХК, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай хамтран АСЕМ-ийн хурлаас өмнө 110 кВ-ын “Зайсан”, “14-р хороолол” дэд станцуудыг хүчдэлд залган, төрийн тусгай хамгаалалттай “Их тэнгэрийн цогцолбор”-ын цахилгаан хангамжийг найдваржуулах талаар үүрэг даалгавар өгөн ажилласан. Барилга угсралтын ажилд Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 183 тоот тушаалаар техникийн комисс томилсон. Техникийн комисс ажиллаж, цахилгаан дамжуулах агаарын шугамыг хүчдэлд залгасан.

110кВ-ын “Улаанбаатар-14-р хороолол” ЦДАШ-ын 220кВ-ын “Улаанбаатар” дэд станцын 110кВ-ын ИХБ-ийн өргөтгөлийн барилга угсралтын ажил хийгдэж дууссан тул Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 256 тоот тушаал техникийн комисс томилсон. 110/35/10кВ-ын “Зайсан” дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байгаа бөгөөд 2016 оны 12 дугаар сард хүчдэлд залгахаар төлөвлөн ажиллаж байна.

Гүйцэтгэгч “Алтай трест” ХХК 110/35/10 кВ-ын “Яармагийн гүүр” дэд станцын барилга угсралтын ажлыг дууссан тул эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 259 тоот тушаалаар техникийн комисс ажиллаж, Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангуулахаар холбогдох үүрэг даалгавар өгсөн. 110 кВ-ын “Сонгино-Зайсан” цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу Хүүшийн зорь, Зайсангийн амны хэсэг

газрын маргаантай, 220 кВ-ын “Сонгино” дэд станцын барилга угсралтын ажил дуусаагүй улмаас хүчдэлд залгаж, ашиглалтад оруулах боломжгүй байна.

110 кВ-ын 2.5 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай дэд станцын барилга угсралтын ажил дууссан тул Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 308 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан, Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангуулахаар холбогдох үүрэг даалгавруудыг өгч ажилласан.

110/35/10кВ-ын “Шинэ яармаг” дэд станцын барилга угсралтын ажил дууссан тул Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 192 тоот тушаалаар техникийн комисс томилон ажиллуулан, Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангуулахаар холбогдох үүрэг даалгавар өгсөн.

110 кВ-ын “Сонгино-Зайсан” цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу Хүүшийн зоорь, Зайсангийн амны хэсэг газрын маргаантай, 220 кВ-ын “Сонгино” дэд станцын барилга угсралтын ажил дуусаагүй улмаас хүчдэлд залгаж, ашиглалтад оруулах боломжгүй байна.

“Багануур-Цэнхэрмандал” сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг дуусч, эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 172 тушаалаар техникийн томилсон. Техникийн комисс ажиллаж, 2016 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 172/10/2016 тоот техникийн комиссын акт гарч хүчдэлд залгасан. Эрчим хүчний сайдын 2016 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 45 тоот тушаалаар улсын комисс томилсон. Улсын комисс ажиллаж, 2016 оны 8 дугаар сарын 25-ны 14/2016 тоот улсын комиссын акт гарч ашиглалтад хүлээн авсан.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагаан сумын 35 кВ-н ЦДАШ, дэд станцын БУА-д хяналт тавин ажиллаж байна. Барилга угсралтын ажил дуусаагүй. Гүйцэтгэл 80%-тай байна. Тус шугамын барилга угсралтын ажлыг 2016 оны 12 дугаар сард техникийн комисс ажиллахаар төлөвлөөд байна.

Багц.9-ийн гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Б-Софт” ХХК-д 37/2014 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдөр олгосон. 2014 оны 10 дугаар сард БУА дуусч техникийн комисс ажиллуулах бэлтгэл хангасан. ТНБД-ын 2014.07.30-ны өдрийн 185 дугаар тушаалаар техникийн комиссийг томилон ажиллуулж объектыг байнгын хүчдэлд залгасан. Эрчим хүчний сайдын 201.10.07-ны өдрийн 140 дугаар тушаалаар улсын комиссыг томилон ажиллуулан объектыг ашиглалтад хүлээж авсан тухай 06/2016 акт гарсан.

Багц-1: Гүйцэтгэгчээр “Аркади” ХХК шалгарч гэрээ байгуулсан. БУА дуусч ТНБД-ын 2015.07.30-ны өдрийн 186 дугаар тушаалаар техникийн комиссийг томилон ажилуулсан. Эрчим хүчний сайдын 2015.09.29-ны өдрийн 28 дугаар тушаалаар улсын комиссыг томилон улсын комисс ажиллаж, хөрөнгийн асуудал тодорхойгүй улмаас улсын комиссын акт баталгаажаагүй байна.

Багц-2: Гүйцэтгэгчээр “Эрчим” ХХК шалгарч гэрээ байгуулсан БУА дуусч ТНБД-ын 2017.07.30-ны өдрийн 186 дугаар тушаалаар техникийн комиссийг томилон ажилуулсан. Эрчим хүчний сайдын 2015.10.16-ны өдрийн 144 дүгээр тушаалаар улсын комиссыг томилон улсын комисс ажиллаж объектыг ашиглалтад хүлээж авсан тухай 47/2015 акт гарсан.

Багц 10, 11: Гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Ханлиг элч” ХХК-д 52/2014 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдөр олгосон. Барилга угсралтын ажил дуусч ТНБД-ын 2015.11.18-ны өдрийн 282, 283 дугаар тушаалуудаар техникийн комиссийг

томилон ажилуулан Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангуулахаар холбогдох үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын биелэлт хангуулан ажиллаж байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын ерөнхий инженерүүдийн зөвлөлгөөнийг 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулан, “Төвийн бүсийн эрчим хүчний системийн 2016 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”, “Алтай-Улиастайн эрчим хүчний системийн 2016 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”, “Баруун бүсийн эрчим хүчний системийн 2016 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”, “Дорнод бүсийн эрчим хүчний системийн 2016 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”, “Өмнөд бүсийн эрчим хүчний системийн 2016 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”-г тус тус хэлэлцүүлэн, батлуулж, мөрдөлтөд хяналт тавин ажилласан. 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн зөвлөлгөөнөөр “Төвийн бүсийн эрчим хүчний системийн 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа”, “Алтай-Улиастайн эрчим хүчний системийн 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа”, “Баруун бүсийн эрчим хүчний системийн 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа”, “Дорнод бүсийн эрчим хүчний системийн 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа”, “Өмнөд бүсийн эрчим хүчний системийн 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа”-г тус тус хэлэлцүүлэн, эрчим хүчний дэд сайдаар батлуулан, мөрдөлтөд хяналт тавин ажиллаж байна. Хэрэглэгчдийн дулааны ачаалал буурч “Амгалан ДС”-ын 1 зуухны ачаалал нь хүчин чадлынхаа 50 хувьд хүрэхгүй болсон, технологийн боломжгүй байдлаар шалтгаалан тус станцыг 2016.04.01-ний өдрөөс зогсоох, үүнтэй холбогдуулан ачаалал шижлүүлэх, схем бэлдэх, горимын зохицуулалт хийх талаар “ДҮТ” ХХК, “Амгалан ДС” ХХК, “УБДС” ТӨХК, “ДЦС-4” ТӨХК-иудыг оролцуулан хуралдаан зохион байгуулж үүрэг даалгавар, горимын зохицуулалт хийх тухай 2016.03.22-ны өдрийн 4/839 албан тоотоор компаниудад хүргүүлсэн.

ДҮТ-ийн эрчим хүчний системийн үйл ажиллагааны мэдээллийн системээр дамжуулан ДЦС-ууд, мөн төвлөрсөн дулаан хангамжтай аймгуудын төвийн ДС-уудын диспетчертэй холбогдон үйлдвэр компаниудын шуурхай үйл ажиллагаанд өдөр дутам хяналт тавин ажиллаж байна.

Хэрэглэгчдийн дулааны ачаалал буурч “Амгалан ДС”-ын 1 зуухны ачаалал нь хүчин чадлынхаа 50 хувьд хүрэхгүй болсон, технологийн боломжгүй байдлаар шалтгаалан тус станцыг 2016.04.01-ний өдрөөс зогсоох, үүнтэй холбогдуулан ачаалал шижлүүлэх, схем бэлдэх, горимын зохицуулалт хийх талаар “ДҮТ” ХХК, “Амгалан ДС” ХХК, “УБДС” ТӨХК, “ДЦС-4” ТӨХК-иудыг оролцуулан хуралдаан зохион байгуулж үүрэг даалгавар, горимын зохицуулалт хийх тухай 2016.03.22-ны өдрийн 4/839 албан тоотоор компаниудад хүргүүлсэн. Сар шинийн баяр, Үндэсний их баяр наадам, Ази Европын дээд хэмжээний 11 дүгээр уулзалтын өдрүүдэд эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, тухайн өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийг томиллох тухай Эрчим хүчний сайдын тушаалыг боловсруулан батлуулсан. Мөн баяр, ёслолын үед жижүүрийн хуваарийн дагуу үйлдвэр компаниудын шуурхай үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. ДЦС-уудын 2016.10.15-2016.12.06-ны өдрийн хооронд гарсан үндсэн тоноглол болох зуух, турбины гэмтэл, зогсолтын судалгаа, тоог гарган, гэмтлийн шалтгааныг ангилан, танилцуулга, мэдээлэл бэлтгэсэн.

Хоёр. Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын найдвартай ажиллагааг хангуулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах чиглэлээр:

Эрчим хүчний үйлдвэр, компаниудын 2015-2016 оны өвлийн ачааллын үеийн ДЦС, ДС-ууд болон дамжуулах сүлжээний горим ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, үйл ажиллагааг болон хоногийн тасралт, саатлын талаарх мэдээллийг яамны удирдлагад танилцуулан ажилласан.

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай ажиллагааг хангах, 2016-2017 оны өвлийн их ачааллыг хүндрэлгүй давах, өвлийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгуулах, ажлын явцад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах, мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Эрчим хүчний сайдын 2016 оны 07 дугаар тушаалаар томилон ажиллуулж, үйлдвэр компаниудын их засвар, техникийн зохион байгуулалтын арга хэмжээний ажил, хөрөнгө оруулалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 компанийн дүнгээр 2016-2017 оны өвлийн бэлтгэл хангахад үндсэн болон туслах тоноглолын их засварт 50807,4 сая төгрөгийн 680, хөрөнгө оруулалтад 22977,7 сая төгрөгийн 489, техникийн зохион байгуулалтын арга хэмжээний ажилд 25197,1 сая төгрөгийн 368, нийтдээ 98982,2 сая төгрөгийн 1537 нэр төрлийн ажил хийхээр төлөвлөсөн байна.

1. Мөн эрчим хүчний салбарын 2016-2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дулаан хангамжийн чиглэлээр хийгдэх 45,8 тэрбум төгрөгийн 11 ажлыг тусгав.

Үйлдвэр компаниудын их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ны гүйцэтгэл 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өвлийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 100 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 97 хувьтай байна.

Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг 6 дугаар сарын 01-ний байдлаар гарган Засгийн газрын 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн тус хуралдаанд 2017 онд эрчим хүчний салбарт шаардагдах татаасын хэмжээ, зарим шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээний талаар танилцуулж Засгийн газрын тогтоол гарсан.

Эрчим хүчний үйлдвэр, компаниуд өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд зайлшгүй хийх шаардлагатай ажлууд хөрөнгө мөнгөний дутагдлаас үүдэн саатаж буйд анхаарлаа хандуулж “Нэг худалдан авагчийн зах зээл”-д үйл ажиллагаа явуулж буй компаниудын өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийн зохицуулалтыг хийх талаар Эрчим хүчний зохицуулах хороонд зөвлөмжийг хүргүүлсэн.

Эрчим хүчний үйлдвэр, компаний удирдлагуудын өргөтгөсөн шуурхай зөвлөлгөөнийг 2016 онд 9 удаа зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Эрчим хүчний салбарын 2016 оны удирдах ажилтны зөвлөлгөөнийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.

Эрчим хүчний нэгдсэн сүлжээ, эх үүсвэр, цахилгаан, дулааны шугам сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаанд нөлөөлсөн аварри, нэгдүгээр зэргийн саатал, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Эрчим хүчний сайдын 2016 оны 05 дугаар тушаалаар томилон ажиллуулж байна.

Амгалан дулааны станцын зуух№1-ийн утаа сорогчид 2016.01.17-ний өдөр гарсан аварри, саатлыг газар дээр нь очиж судлан, аваррийн разбор хийн хуралдан, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Мөн аварри, саатлын акт, дүгнэлтийг гаргаж, уг асуудлаар хуралдаан зохион байгуулан саатлыг богино хугацаанд арилгах, ажлын хариуцлага дээшлүүлж ажиллах талаар үүрэг даалгавар өгч, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Амгалан дулааны станц” ХХК-д 2016.02.03-ны өдрийн 4/395 тоот албан бичиг хүргүүлэв.

“Амгалангийн дулааны станц” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх-д Амгалангийн дулааны станцын цахилгаан хангамжийн 110/10 кВ-ын “Амгалан” дэд станцын өргөтгөл, 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 2х20 МВА хүчин чадалтай трансформатор бүхий дэд станцыг Эрчим хүчний тухай хуулийн дагуу барилга угсралтын ажлын үндсэн хөрөнгө, ашиглалтын үйл ажиллагааг “ЦДҮС” ТӨХК-ийн мэдэлд шилжүүлэх талбаар 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн в/1735 тоот албан даалгавар хүргүүлсэн.

Дулааны цахилгаан станцуудад Нүүрсний уурхай, станц хоорондын 2016 онд нүүрс худалдах, худалдан авах гэрээ, 2015 оны нүүрс худалдах, худалдан авах гэрээний биелэлт, мөн уурхай, станц, төмөр зам хоорондын 2015 оны жилийн эцсийн байдлаар хаалт хийсэн өр, авлагын мэдээг тус тус гаргуулан хяналтад авсан.

Төвийн дулааны станцуудын хоногийн нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх талар 4/427 албан тоотыг ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, Амгалан ДС ХХК, Багануур ХК-уудад хүргүүлсэн.

Багануур, Шивээ-Овоогийн уурхайн өргөтгөл шинэчлэлийн ажлын талаар Эрчим хүчний сайд дээр хуралдсан хурлын тэмдэглэлийг гарган, хурлаас гарсан шийдвэрийн хамт Багануур ХК, Шивээ-Овоо ХК-ийн 2016-2020 онд хэрэгжүүлэх төсөл, техникийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын талаарх хурлыг 2016.02.03-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хуралд Эрчим хүчний сайд, яамны удирдлага, уурхайн төлөөлөл, “Эрдэнэс МГЛ” ХХК-иудын төлөөлөл оролцсон. Уг хурлаас гарсан тэмдэглэл, шийдвэрийг гаргаж Эрдэнэс МГЛ, Багануур, Шивээ-Овоогийн уурхайн дарга нарт хүргүүлэв.

Багануур, Шивээ-Овоогийн уурхай болон шатахуун нийлүүлэгч компаниудын хооронд үүссэн 2015 оны жилийн эцсийн өр авлагыг “Эрдэнэс таван толгой” ХК-аас Улсын төсөвт илүү төлсөн татварт суутган тооцож, шатахуун нийлүүлэгчдийн шатахууны импортын гааль, онцгой болон НӨАТ-ын улсын төсөвт төлөх татварт суутган тооцон хаалт хийн уурхайн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан, яамдаас саналыг авч нэгтгэсэн. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах тухай 2016 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн а/980 албан тоотыг хүргүүлсэн. Асуудлыг Засгийн газрын 2016.04.11-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч хойшлогдсон.

Засвар үйлчилгээтэй холбоотойгоор хийж байгаа таслалт, хязгаарлалтын талаар 2016 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 4/1308 тоот албан бичгээр цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ компаниудад хүргүүлсэн. 2016 оны 5 дугаар сард дамжуулах, түгээх сүлжээ компаниудад хийгдэх захиалгат ажлуудыг нэгтгэсэн бөгөөд хүйтэн, цас бороо шуургатай өдөр таслалтыг хийхгүй байх мөн ажил хийх хугацааг 2-3 цагаар багасгаж ажиллах талаар үүрэг даалгавар өгсөн. Өдөр бүр захиалгат таслалт, хязгаарлалтын талаар мэдээг өдөр бүр авч танилцуулан ажиллаж байна.

Дөргөний усан цахилгаан станцын G-1 турбингенераторын их засварын ажилтай газар дээр танилцаж, ажлын гүйцэтгэл, хугацаанд нь дуусгах талаар үүрэг даалгавар өгөн ажилласан.

Гурав. Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудыг нэгдсэн удирдлагаар хангах, ашиглалтын түвшинг дээшлүүлэх, үр ашигтай горим төлөвлөлт, зохицуулалт хийх ажлыг зохион байгуулах, зохицуулах чиглэлээр:

Эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, өвлийн бэлтгэл ажил, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас өгөх үнэлгээг гарган ХШҮДАГ-т хүргүүлсэн.

Эрчим хүчний салбарын 2016 оны үйлдвэрлэл хэрэглээний төлөвлөгөөг ДҮТ ХХК-тай хамтран ТЭХС, ББЭХС, АУЭХС, ДБЭХС, ӨБЭХС тус бүрээр боловсруулан хянаж, батлан мөрдөж байна.

Эрчим хүчний салбарын 2015 оны үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөгөөний биелэлтийн нэгдсэн дүнг гарган 2016 оны 3 дугаар сард удирдлагуудад танилцуулсан.

Мөн тайлант хугацаанд үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөгөөний биелэлт, эрчим хүчний өр, авлага, борлуулалтын орлого төвлөрүүлэлтийн талаар нэг удаа хуралдсан. Энэхүү хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд 2016 онд импортлох, экспортлох цахилгаан эрчим хүчний тооцоог ДҮТ ХХК, ЭХЗХ-той хамтран гарган хянаж, Эрчим хүчний сайдын 2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 06 дугаар тушаалаар батлуулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Эрчим хүчний салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах ажлын хүрээнд нийт 25 компанийн 2016 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилтот түвшинг хянан Эрчим хүчний сайдын тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Эрчим хүчний үйлдвэр, компаниуд хөрөнгийн дутагдлыг нөхөх үүднээс авч буй богино хугацаат зээлийг олгохдоо Эрчим хүчний яамны Зээлийн хороогоор хэлэлцүүлэх, Зээлийн хорооны бүрэлдэхүүнийг томилох сайдын тушаалын боловсруулан батлуулсан.

Төрийн өмчийн хороо татан буугдсантай холбогдуулан зарим чиг үүрэг эрчим хүчний яаманд шилжин ирсний дагуу Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын удирдамж өгөх ажил хуваарилагдсан. Энэхүү ажлын хүрээнд эхний хагас жилд нийтдээ 78 хурлын удирдамж боловсруулан хүргүүлсэн.

Эрчим хүчний салбарын 2016 оны Зуны бага ачааллын горимыг 2016 оны 5 дугаар сарын 9-ны ерөнхий инженерүүдээр хэлэлцүүлэн, төрийн нарийн бичгийн даргаар батлуулан “ДҮТ” ХХК-нд хүргүүлсэн.

Алтай Улиастайн эрчим хүчний системийн горим ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Монгол Улсын төсвөөс олгодог дизель станцын түлшний татаасыг холбогдох тооцоо судалгааг гарган, нийт 3 тэрбум төгрөгийн түлш шаардлагатай байгаа саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 50% бууруулан батлагдсан. Үүнээс үүдэн эх үүсвэрийн чадлыг дутагдалд орж, горим ажиллагаа доголдож, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хязгаарлах нөхцөл байдал үүссэн. 2015-2016 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа мөрдөх хугацаанд нийт батлагдсан дизель түлшний татаасыг Говь-Алтай аймагт 60%-г, Завхан аймагт 90%-г зарцуулсан. Цаашид 2016-2017 оны өвлийн их ачааллын горим ажиллагаанд хүндрэлтэй байдлыг харгалзан дараахь зохицуулалтыг хийсэн. Үүнд:

1. 110/35/10 кВ-ын “Улиастай” дэд станцыг ЦДҮС ТӨХК-ийн техникийн шинэчлэлээр буусан трансформатор, бусад туслах тоноглолуудыг балансаас балансад шилжүүлэх замаар өргөтгөх
2. Их ачааллын горим ажиллагаанд шаардлагатай дизель түлшний татаасыг аймаг, орон нутгийн удирдлага, Улсын онцгой комисст уламжилан, шийдвэрлүүлэх
3. Тайширын УЦС-ын усны түвшинг харгалзан, 2 машины горимоор ажиллах боломжийг судлан шийдвэрлэх, төлөвлөгөөт их засварыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

4. Эх үүсвэрийн дутагдалтай байдлыг харгалзан, Баруун бүсийн эрчим хүчний системээс авч буй чадлыг нэмэгдүүлэх горимын тооцоо, схемыг гарган, шаардлагатай зардлыг урьдчилсан байдлаар тооцоон танилцуулсан. Санхүүжилт, хөрөнгө мөнгөний дутагдалтай байгаа тул шийдвэрлэх боломжгүй байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтат сав, шугам хоолой, ЦТП-ны ТЭЗҮ зураг төсөл, угсралт, засвар туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт гаргах комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж, Эрчим хүчний сайдын “Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, нэмэлт ажлын төрөл олгох тухай” 2016 оны 16, 64, 84 тоот тушаалууд гаргасан.

1. ТЭЗҮ, зураг төслийн чиглэлээр

А. Шинээр	17
Б. Сунгахаар	17

2. Угсралт, засвар, туршилт тохируулгын чиглэлээр

А. Шинээр	126
Б. Сунгахаар	215

Нийт 375 аж ахуйн нэгж компаниудад тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулсан.

Эрчим хүчний яамнаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалт, түүнд тавигдах нөхцөл шаардлага, өргөдлийн маягтыг эрчим хүчний яамны www.energy.gov.mn сайтад байрлуулан ажиллаж байна.

Мөн Эрчим хүчний сайдын “Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, нэмэлт ажлын төрөл олгох тухай” 2016 оны 16, 64, 84 тоот тушаалуудыг эрчим хүчний яамны www.energy.gov.mn сайтад тухай бүр байрлуулан, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын мэдээллийг нээлттэй байхаар зохион байгуулан ажиллаж байна.

Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух, даралтат сав, шугам хоолой, ЦТП-ны ТЭЗҮ зураг төсөл, угсралт, засвар туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөл авахаар, хугацааг сунгах, нэмэлт ажлын төрөл авахаар хүсэлт гаргасан компаниудын материалуудыг тусгай зөвшөөрөл олгох урьдчилсан дүгнэлт гаргах комиссын хурлаар хэлэлцүүлэн, тус хурлаас шалгах компаниудын нэрсийн дагуу ирүүлсэн өргөдлийн материалуудыг газар дээр нь шалган, гарсан зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.

Цахилгаан техникийн нөхцөл олгох комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж, нийт 403,9 МВт чадал хүссэн 126 хүсэлт ирүүлсэн бөгөөд техникийн нөхцөл авах байршлуудын газар дээр ажлын хэсгийн гишүүдийн хамтаар очиж үзэж судалж 110 техникийн нөхцөл олгоод байна.

Хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжинд холбох техникийн нөхцөл олгох ажлыг зохион байгуулан, хэрэглэгчдийн дулаан эрчим хүчээр хангах ажлын хэсгийн хурлыг нийт 5 удаа зохион байгуулж 164 иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийг хурлаар авч хэлэлцэн 29 иргэн аж ахуй нэгж байгууллагад **68.45Гкал/ц**-н ачаалал бүхий төвлөрсөн дулаан хангамжид холбогдох техникийн нөхцөл олгож, орон нутагт 10Гкал/ц-н ачаалал олгож, 33 байгууллагад **101.79 Гкал/ц**-н сунгалт хийж, 97 байгууллагад төвлөрсөн дулаанд холбох боломжгүй хариуг албан тоотоор хүргүүлсэн.

ЭХЯ-ны ТНБД-ын 2016 оны 03 сарын 01-ний өдрийн 56 тоот тушаалаар Дулааны техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчилэн баталсан.

Амгалан дулааны станцын горимын асуудлаар “ДҮТ” ХК, “ДЦС-4” ТӨХК, “УБДС” ТӨХК, Амгалан дулааны станцын холбогдох төлөөллийг оролцуулан хуралдаан зохион байгуулж шийдвэрийг албан бичгээр хүргүүлэхээр албан тоотыг хүргүүлсэн. Станцын ус хангамжийн шугамын ажил болон сүлжээний нэмэлт усыг хотын сүлжээнээс тусгаарлах ажилд хяналт тавин ажиллаа. Станын нэмэлт усыг ДЦС-3, ДЦС-4-ийн сүлжээнээс тусгаарлан ажиллуулав. Амгалан дулааны станцыг 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зогсоож буйтай холбогдуулан хэрэглэгчдийн хотын сүлжээнээс хангах, сэлгэл залгалт, горим үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав.

Буянт-Ухаа 2, Шинэ Яармаг хороолол, Цайз захын ойролцоох хэрэглэгчдийн дулааны эрчим хүчээр хэрхэн хангах талаар “УБДС” ХК-тай хэлэлцэн, чиглэл зөвлөмж өгсөн. Зөвлөмж чиглэлийн дагуу “УБДС” ХК тооцоо, судалгаа боловсруулан тайланг хэлэлцэхээр ажиллаж байна.

ТОСК-ын хүрээнд баригдах Буянт-Ухаа 2 орон сууцны хорооллын нэмэлт дулааны ачааллыг хэрхэн хангах талаар “УБДС” ХК, ТОСК-тай хамтран зөвлөлдөж, 17 Гкал/ц-ийн ачааллыг нэмж хангахаар шийдвэрлэсэн бөгөөд гаргасан техникийн шийдлийн дагуу зураг төслийг боловсруулахыг ТОСК-д үүрэг өгсөн.

Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 2016 оны сонгуулийн үеэр эрчим хүчний үйлдвэр, компаниуд өндөржүүлсэн бэлэн байдалд 6 дугаар сарын 28-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 182 дугаар тушаалын хариуцлагатай жижүүрээр ажиллаж, эрчим хүчний эх үүсвэрүүд, цахилгаан дамжуулах түгээх сүлжээ компаниудын үйл ажиллагаанд хяналт тавин, гаргасан саатал, тасралтуудыг түргэн шуурхай устгах, санал өгөх үйл ажиллагааг саатуулахгүй байхад онцгой анхаарч ажилласан. Эрчим хүчний үйлдвэр компаниудын сонгуулийн үеэр ажилласан тайланг нэгтэж танилцуулсан.

220, 110 кВ-ын “Их тойрог” цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын 110/35/10 кВ-ын “Радио телевиз” дэд станцаас 110/35/10 кВ-ын “Найрамдал” дэд станц хүртэлх 110 кВ-ын ЦДАШ-ын аянга хамгаалах тросс татах ажлыг хийх үеэр авах таслалтын талаар “УБЦТС”, “ЦДҮС” ТӨХК-уудтай хамтарсан хурал зохион байгуулсан ба гүйцэтгэгч “Аркади” ХХК-ийг ажилд оруулах бэлтгэл ажлыг хангуулан. 220, 110 кВ-ын “Их тойрог” цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын талаар “ДҮТ”ХХК, “ЦДҮС” ТӨХК, ЭХХТөв, “Алтай Трест” ХХК, “Аркади” ХХК-тай хурал зохион байгуулсан.

Дөрөв. Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангуулах ажлын хүрээнд:

Бодлогын хэрэгжилттэй холбогдуулан хийсэн ажлын талаар:

УИХ-ын 2015 оны 12-р сарын 18-ны өдрийн хурлаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулан Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөхөөр тугасан. Дээрхи хуулийн дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийн жагсаалтын төслийг боловсруулан Засгийн газрын 2016 оны 198 тогтоолоор батлуулсан.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форумыг Монголын салхины эрчим хүчний ассоциатай хамтран 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан.

Шинээр орох сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн судалгааг гаргаж, эрчим хүчний тарифт хэрхэн нөлөө үзүүлэх талаар судалгааг гаргасан.

Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослон ажиллах дизель станцын түлшний тооцоог хийж газрын даргад танилцуулсан.

“ДҮТ” ХХК-ийн “Клин энерги ази” ХХК-тай байгуулах “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний шууд гэрээ”, “Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд диспетчерийн зохицуулалт хийх тухай гэрээний шууд гэрээ”-ний төслийг хянаж, Эрчим хүчний сайдын гарын үсэг зурах зөвшөөрөл олгосон тушаал гаргасан.

Тайширын УЦС-ын “0” зогсолтын үеийн АУЭХС-ийн горим ажиллагаанд хяналт тавин, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчний хязгаарлалтыг аль болох хийхгүй байхад анхаарч, хүчдлийн горим хүндэрсэн үед 1-2 дизель станц ажиллуулах шийдвэр гарган, 2016 оны 9 сарын 02-07-ны өдрүүдэд төлөвлөгдсөн их засварын ажлыг хийж дуусган, хэвийн ажиллагаанд оруулсан.

Баясгаланбаатар нь 2016 оны 9 дүгээр сарын 09-нөөс 15-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн Алтай сумын 300 кВт-ын нарны цахилгаан станцад албан томилолтоор ажиллалаа. Говь-Алтай аймгийн 2016 оны төсөвт 170.0 сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Алтай сумын 300 кВт-ын нарны цахилгаан станцын их засварт зарцуулахаар тусгасан байсан. Говь-Алтай аймгийн удирдлагуудтай уулзаж 170.0 сая төгрөгийн их засварын ажлыг “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгэхээр тохиролцсон. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь гэмтэлтэй 2 инвертерээс 1 инвертерийн хэвийн ажиллагаанд оруулж, 2 В-ийн 2500 А*ц-ийн 70 ширхэг цэнэг хураагууруудыг шинээр сольсон.

“Эвридей ферм” ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлж байгаа 2.3 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын нарны зай, ЦДАШ, дэд станцын барилга угсралтын бүрэн дууссан. Инвертер тээвэрлэлтэд явж байгаа.

Япон улсын Sharp компанийн хөрөнгө оруулалтаар “Solar power international” ХХК-ийн хэрэгжүүлсэн Дархан хотод 10 МВт-ын нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусч 2016 оны 11 дүгээр сарын 5-наас 7-ны өдрүүдэд техникийн комисс ажилласан.

Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар:

1.Бодлогын чиглэлээр:

“Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Багануурын хүрэн нүүрсний уурхайн өргөтгөлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулан, төслийг УУЯ-ны /хуучин нэрээр/ Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж Эрчим хүчний яам, “Эрдэнэс-Монгол” ХХК болон “Багануур” ХК-д хүлээлгэн өгсөн.

“Багануур ХК” болон “Шивээ-Овоо” ХК-иудын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний хуралдаанаар хэлэлцүүлэн тус 2 уурхайд 20.0 тэрбум төгрөгийн төсвийн зээл олгохоор шийдвэрлүүлсэн.

Эрчим Хүчний Зохицуулах Хороонд нүүрсний үнэ тарифыг нэмэгдүүлэх талаар санал, танилцуулгыг хийснээр нүүрсний үнэ тариф тодорхой хувиар нэмэгдсэн.

“Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн 2017-2018 оны уулын ажлын төлөвлөгөө батлуулахтай холбогдуулан ДЦС-уудын 2017 оны нүүрсний хэрэглээний судалгааг үндэслэн дулааны станц, дулааны цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээний захиалгад холбогдох зохицуулалт хийсэн.

“Эрчим хүчний тухай” хуульд метан хийн асуудал хамрагдсантай холбогдуулан энэ салбарыг хөгжүүлэх зорилтыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дулааны 3 дугаар цахилгаан станцын 250 МВт-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-ын өргөлтгөлийн төслийн бэлтгэл ажлыг хангах, ажлын даалгавар, техникийн бичиг баримт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж нүүрсний хангамжийн талаар санал боловсруулан танилцуулсан.

Монгол улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 113 дугаар захирамжаар байгуулагдсан “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах” төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна.

2.Бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Эрчим хүчний нүүрсний чиглэлээр:

Эрчим хүчний сайдын 2016 оны 42 дугаар тушаалаар газрын дарга Н.Болдхүү-ээр ахлуулсан “Багануур”ХК, “Шивээ-Овоо”ХК-ын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, үйл ажиллагааг тогтворжуулах, авахад бэлэн нүүрсний нөөцийг бүрдүүлэх, уурхайнуудын төсвийн зээлийн зарцуулалтад хяналт тавьж, ажиллах үүрэг бүхийажлын хэсэг байгуулагдан Багануур, Шивээ-Овоогийн уурхайд томилолтоор ажиллан 2 уурхайн 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажил, үйл ажиллагааны мэдээлэл, нүүрсний нөөц бүрдүүлэлт, уурхайнуудын төсвийн зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд анхааран ажилласан бөгөөд холбогдох мэдээллээр удирдлагуудыг ханган, өдөр тутмын үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна.

“Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-д төсвийн зээл олгогдсоноор санхүүгийн чадавхи сайжирч, 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдан, уурхай дээрх авахад бэлэн нүүрсний нөөц 260.0 – 400.0 мян.тн-д хүрч эрчим хүчний түлшний хангамжийг бүрдүүлэн дулааны станц, цахилгаан станцуудын гаднах нүүрсний нөөц 12 дугаар сарын 25-ны байдлаар 15-17 хоногт хүрсэн.

“ДЦС-2”, “ДЦС-3”, “ДЦС-4”, “Дарханы ДЦС” ТӨХК болон “Амгалан ДС” ХХК-иудын 2017 онд шаардагдах нүүрсний хэмжээг станцуудын саналыг үндэслэн нэгтгэж шаардлагатай зохицуулалтыг хийн “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын 2017 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн.

Хүйтний эрч эрс нэмэгдэж, ачаалал ихсэж байгаатай холбогдуулан авахад бэлэн нүүрсний нөөцийг 200.0 мянган тонноос бууруулахгүй байхаар тооцож зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүргийг нүүрсний уурхайнуудад өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Амгалангийн дулааны станцад нийлүүлэгдэж байгаа нүүрс хүйтний эрч нэмэгдсэнээс вагоны хананд наалдан хөлдөж вагон буулгалтанд үүсэн хүндрэлийг арилгах зорилгоор чийглэг багатай, зуухны горимд тохирсон нүүрсээр хангах ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна.

Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч, Ерөнхий сайдын уулзалтад танилцуулга бэлтгэв.

Засгийн газрын 2016 оны 338 дугаар тогтоолын биелэлтийг хангах зорилгоор дараах гол ажлуудийг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 338-р тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн асуудлаар “Эрдэнэс-Монгол” ХХК-ийн удирдлагуудтай уулзаж санал солилцон дизель түлш нийлүүлэгч компаниуд болон нүүрсний уурхайнуудын хооронд үүссэн өр, авлагыг төсвийн зээлийн хүрээнд 5,2 тэрбум төгрөгөөр бууруулсан.
- “Шивээ-Овоо” ХК, “ДЦС-4” ТӨХК-ийн хооронд үүссэн хуримтлагдсан өрийг бууруулах асуудлаар дээрх 2 аж ахуйн нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан.
- “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн нүүрсний үнийг нэмэгдүүлэх тухай саналыг уурхайнуудаас авч ЭХЗХ-нд санал тавьж шийдвэрлүүлсэн.
- Засгийн газрын 2016 оны 338 дугаар тогтоолын 5 дах зүйлийн биелэлтийг хангах ажлыг эрчимжүүлэх талаар албан бичгийг “Эрдэнэс-Монгол” ХХК-д хүргүүлэв.

Монгол Улсын Эрчим хүчний яам болон БНХАУ-ын Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн хооронд эрчим хүчний экспортын төслийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгааг хамтран боловсруулах гэрээ байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан Эрдэнэс Шивээ-Энержи төслийн нэгжтэй холбогдож төслийн ажлын явц, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд болон нүүрсний нөөцийн талаарх мэдээллийг гаргуулж авсан.

Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралд Багануур, Шивээ-Овоогийн уурхайн үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээллийг бэлтгэн оруулсан.

“Амгалан ДС” ХХК-ийн 2016-2017 оны халаалтын улирлын нүүрсний хэрэглээ, нүүрсний хангалтын талаар “АмгаланДС” ХХК, “Шивээ-Овоо” ХК, “Багануур” ХК-иудын төлөөллийг оролцуулан ярилцаж ДҮТ-өөс өгөгдсөн горимын дагуу нүүрс татан авалт, нийлүүлэлтийн хуваарийг тохиров.

“ДЦС-2”, “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК, “Амгалан ДС” ХХК-ийн үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажил, нүүрсний чанар, нөөц бүрдүүлэлт, вагон хангамжийн талаар станцуудын талбай дээр биечлэн танилцаж холбогдох мэдээллүүдийг нэгтгэн танилцуулав.

Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын гүйцэтгэлийг Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулахтай холбогдуулан “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн найдвартай ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлт, тулгамдаж буй асуудлуудын талаарх мэдээллийг бэлтгэж яамны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэгт хүргүүлэв.

Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэлийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Багануур” ХК-д өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн дуусгах, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, биелэлтийн мэдээ, тайланг тухай бүр мэдээлэх, ДЦС, хэрэглэгчдэд нүүрсийг хугацаанд нь графикайн дагуу нийлүүлэх, төсвөөс олгогдсон зээлийг зориулалтын дагуу зарцуулж гэрээнд тусгагдсан нөхцлөөр зээлийг эргэн төлөлтөд анхаарч ажиллахыг зөвлөмж болгон албан бичиг хүргүүлэн, хяналт тавин ажилласан.

“Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаанд ус шүүрүүлэлтийн ажил хоцрогдолтой, өвөлжилтийн бэлтгэл ажил бүрэн биелээгүй, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажил чанар муутай, ажлын явц удаашралтай, гүйцэтгэлийн мэдээ, үзүүлэлт зөрүүтэй байгаагийн зэрэгцээ ДЦС-уудад нийлүүлэх нүүрс уурхайн тоног төхөөрөмжийн эвдрэл саатлаас шалтгаалан тасалдаж байгаа нь станцуудын аюулгүйн нөөц багасахад нөлөөлж байгаа тул Шивээ-Овоогийн уурхайн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай албан бичиг хүргүүлэн, хяналт тавин ажилласан.

Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн найдвартай байдлыг хангах зорилгоор “УБТЗ” ХНН-ийн дарга удирдлагуудтай ажлын уулзалт хийж дулааны станц, дулааны цахилгаан станцуудад нүүрсний 20 хоногийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай вагон хангамжийг нэмэгдүүлэх саналыг танилцуулан хэлэлцэж, хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн. Мөн сар бүр зохион байгуулагддаг УБТЗ, нүүрсний уурхайнууд, дулааны станц, дулааны цахилгаан станцуудын хооронд зохион байгуулагддаг зөвлөлдөх уулзалтад оролцон, хамтран ажиллаж байна.

Амгалангийн дулааны станцад нүүрс нийлүүлэх, хоногийн нөөц нэмэгдүүлэх асуудлаар “ТЭЗҮ” ХХК, “Амгалан ДС” ХХК, ТБХЗГ-ын 3 талт уулзалт хийж “ТЭЗҮ” ХХК-д вагон хангамжийн хуваарь, нөхцлийг танилцуулан “УБТЗ” ХНН, “Амгалан ДС” ХХК-тай “Гурвалсан гэрээ” байгуулж ажиллах үүрэг, даалгавар өгснөөр “ТЭЗҮ” ХХК Амгалангийн ДС-д өдрийн 16 вагоноор нүүрс нийлүүлж байна.

Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд Төвийн бүсийн эрчим хүчний системийн дулааны станц, дулааны цахилгаан станцуудад шаардагдах нүүрсний хэмжээ, саналыг авч нэгтгэн Багануур, Шивээ-Овоогийн уурхайн уулын ажлын төлөвлөлт, нүүрс нийлүүлэх саналтай уялдуулж 2017 оны 1 дүгээр сард тээвэрлэх нүүрс, вагон захиалгын хуваарийн зохицуулалтыг хийж холбогдох байгууллагуудад техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавин ажиллаж байна.

Эрчим хүчний сайдын ДЦСтанцуудын нүүрсний нөөцийг 20 хоног болгох үүрэг чиглэлийн дагуу Багануур, Шивээ-Овоо, Шарын голын уурхайн вагон хангамж, нүүрс ачилт, дулааны станц, дулааны цахилгаан станцуудад нийлүүлсэн нүүрсний хоногийн мэдээг авч хяналт тавин ажиллав.

Монгол улсын “Засгийн газрын 100 хоног”-ын төлөвлөгөөнд тусгагдсан эрчим хүчний нүүрс олборлогч Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын биелэлтийг гарган ЭХЯ-ны тайланд нэгтгэн оруулсан.

Хийн чиглэлээр:

УИХ-ын Агаарын бохирдлыг бууруулах дэд хорооноос ирүүлсэн албан бичгийн хүрээнд метан хий ашиглах, түүний дэд бүтцийг хөгжүүлэх тухай төлөвлөгөөний саналыг боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулав.

Метан хийг ашиглах болон байгалийн хийн хангамжийн салбарыг хөгжүүлэх талаар танилцуулгыг бэлтгэсэн.

“Метан хийн хамтын ажиллагаа” байгууллагаас боловсруулсан Багануурын нүүрсний уурхайгаас хаягдаж буй метан хийг ашиглан 5 МВт-ын цахилгаан станц байгуулах ТЭЗҮ-д үндэслэн, төсөлтэй холбоотой танилцуулгыг бэлтгэв.

Монгол улсад занарын судалгааны чиглэлээр хийгдсэн ЭБЭХ-ний сайд, ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2012 оны хамтарсан тушаалаар байгуулагдсан “Шатдаг занар” үндэсний хөтөлбөрийн тайлан, Япон улсын Хөгжлийн банкны захиалгаар боловсруулсан “АНУ-ын занарын хувьсгал Японы эдийн засагт нөлөөлөх нь” судалгааны тайлан, 2014 онд Дэлхийн банкны санхүүжилттэй хийгдсэн “Монгол улсын уламжлалт бус газрын тос, хийн нөөцийг ашиглах боломж, бодлогын талаар зөвлөх үйлчилгээ”-ний тайлан зэрэг материалуудтай танилцан судалгаа хийв.

Монгол улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 113 дугаар захирамжаар байгуулагдсан “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах” төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.

Стандартчилал, хэмжилзүйн газрын техникийн хорооны хурлаар “Хийн хангамжийн сүлжээ, нэр томьёо, тодорхойлолт”, “Хийн хангамжийн сүлжээ хийн ерөнхий шаардлага”, “Хийн хангамжийн сүлжээ, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглах хийн техникийн шаардлага” зэрэг стандартыг хэлэлцүүлэв.

Герман-Монголын хамтын ажиллагааны хорооны уулзалт зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан ХБНГУ-тай хамтран хэрэгжүүлж буй төслүүдтэй танилцах уулзалтад оролцов. Тус уулзалтад Германы Туссен групптэй манай яамны хамтран хэрэгжүүлж буй нүүрснээс нийлэг байгалийн хий гаргах үйлдвэрийн явцын талаар танилцуулан, санал солилцов.

Агаарын бохирдлын асуудлын чиглэлээр:

Япон улсын хамтын ажиллагааны байгууллагын хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн ажлын явцын тайлангийн хуралд оролцож, тус төслийн нэгжээс боловсруулсан агаарын бохирдлыг бууруулах асуудалтай холбоотой зөвлөмж, гарын авлагуудыг авч хамтран ажиллахаар тохиролцов.

ЭХЯ болон БОАЖЯам хооронд Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан ойлголцолын санамж бичиг зурахаар тохиролцсоны дагуу харилцан ойлголцолын санамж бичгийн төслийг бэлтгэн, БОАЖЯ-д хүргүүлсэн.

“УБЦТС” ТӨХК-ийн Борлуулалтын бодлого зохицуулалтын хэлтсээс Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн шөнийн хэрэглээнд олгох тарифын хөнгөлөлтөнд хамрагдах хэрэглэгчдийн тоог 2016 оны 10 дугаар сарын байдлаар гаргуулан авч уг хөнгөлөлтөнд нийт хамрагдах айл өрхийн судалгааг БОАЖЯ-д хүргүүлэв.

2017 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх танилцуулгыг бэлтгэж Ерөнхий сайдаар ахлуулсан “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд танилцуулав.

УИХ-ийн Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны “Нийслэл хот, томоохон суурин газрын агаарын бохирдлын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хуралд Эрчим Хүчний Яам, “ЦДҮС” ТӨХК, “УБЦТС” ТӨХК-ийн төлөөлөл оролцож “Гэр хорооллын сургууль

орчмын барилгуудыг дулаалах, дулаан хангамжийн нэгдсэн системд шилжүүлж, нүүрс зарцуулалтыг багасгах” тухай, “Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдвэрлэхтэй холбоотойгоор цахилгаан дамжуулах шугамын нэвтрүүлэх чадварыг сайжруулж, өргөтгөх” тухай танилцуулга хийв.

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Бүгдэд тогтвортой эрчим хүч” төслийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр орон нутагт “Сайжруулсан зуух”, “Бага оврын нарны цахилгаан үүсгүүр” хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, ажиллаж байна.

Улаанбаатар хот болон аймгийн төв, суурин газарт байх нам даралтны зуухны газруудын үйл ажиллагааг дэмжих, цахилгааны хөнгөлөлтөд хамруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хийгдэж байгаа судалгаанд зориулж, 2015 оны байдлаар нийслэлд ажиллаж буй халаалтын нам даралтын зуухны газруудын талаарх тооцоо судалгааг Нийслэлийн хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газраас авав.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/101 дугаар тушаалаар байгуулагдаж буй “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсэгт ахлах мэргэжилтэн Ж.Батбилэг, мэргэжилтэн С.Ариунболд нар ажиллаж байна.

АББҮХорооны 2016 оны анхдугаар хурлын шийдвэрээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд гэр хорооллын айл өрхийн цахилгааны шөнийн тарифыг тэглэх талаар БОАЖЯ-аас 3,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсний дагуу АББҮХорооны нарийн бичгийн дарга бөгөөд БОАЖЯамны ХБОБНУГ-ын даргатай уулзалт хийж тус хөрөнгийг ЭХЯам руу шууд хуваарилуулан, агаарын бохирдлыг бууруулах чиглэлд зарцуулахаар зохицуулалт хийх талаар санал солилцож, ойлголцолд хүрсэн. Мөн тус асуудлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын гол эх үүсвэр болох гэр хороолол, халаалтын зуухнуудын сайжруулсан түлшний асуудлыг шийдвэрлэх зорилгоор “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн байгуулсан хагас коксон шахмал түлшний цогцолбор үйлдвэрийг ажиллуулах чиглэлээр санал болгосон төслүүдийг яамны удирдлагуудад танилцуулав.

Албан уулзалт, хурал, семинар:

- Амгалан дулааны станцын нүүрсний нөөц, түлш дамжуулах хэсэгт гарч буй хүндрэлтэй асуудлыг газар дээр нь очин судлаж, 2016-2017 оны халаалтын улиралд шаардлагатай байгаа нүүрсний хэмжээг тодруулж, нүүрс нийлүүлж буй уурхайнуудтай нүүрс нийлүүлэх гэрээг хугацаа алдахгүй байгуулах талаар дулааны станц дээр уулзалт хийв.
- ШУТИС-ийн харьяа Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургуулиас 2016 оны 11-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Шатах ашигт малтмалын хими боловсруулалт ба экологийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд “Хийн салбарыг хөгжүүлэх хууль эрх зүй, технологи, экологийн асуудлууд” сэдэвт илтгэлээр оролцож, санал солилцов.
- Эрчим хүчний яамны сайд, БНХАУ-ын хийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Shenzhen Qianhai Dayuan Hongtuo Investment” ХХК-ийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтанд оролцож, хамтран ажиллах чиглэлээр санал солилцов.
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг Монгол улсад хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоог хангах зөвлөлдөх уулзалт, семинарт оролцов.

- Хийн хангамжийн сүлжээ, дэд бүтцийн төлөвлөлт, зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг БНХАУ-ын Харбин хотын хийн зураг төслийн компанитай уулзалт хийж, санал солилцов.
- Герман-Монголын хамтын ажиллагааны хорооны уулзалт зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан ХБНГУ-тай хамтран хэрэгжүүлж буй төслүүдтэй танилцах уулзалтад оролцов.
- БОАЖЯ болон “Clean Air Asia” Олон улсын байгууллагын “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” боловсруулах асуудлаар 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулсан хурал, хэлэлцүүлэгт оролцсон.
- Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Эрчим хүчний салбарын хяналтын ажилтны зөвлөгөөн”-д оролцов.
- Барилга, хот байгуулалтын яамнаас 2016 оны 11-р сарын 25-нд зохион байгуулсан “Цэвэрлэх байгууламжийн технологийн шийдэл, цаашдын чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэг, Германы хамтын ажиллагааны байгууллагын “Эрчим хүчний алдагдлыг бууруулах” төслийн ажлын дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн хуралд оролцов.

Дотоод ажлын талаар:

- Сайдын Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Булган аймгаар хийх томилолтын хүрээнд тус 4н аймгийн цахилгаан дулааны эх үүсвэрийн хангамжийн асуудлаар танилцуулга мэдээ бэлтгэсэн.
- “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын Гол” ХК-ийн уурхайн хүчин чадал, тоног төхөөрөмжийн өнөөгийн байдал, уурхайн өргөтгөлд шаардагдах нэмэлт техник тоног төхөөрөмж, уурхайн хөрөнгө оруулалтын товч танилцуулгыг Англи, Монгол хэлээр бэлтгэв.
- Нүүрсний уурхайнуудаас Дулааны цахилгаан станцуудад 2016 онд гэрээний дагуу нийлүүлсэн нүүрсний төлбөр, өр авлагын талаар мэдээлэл авч, нэгтгэв.
- Метан хий хангамжийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд шаардагдах норм, дүрмийн жагсаалтыг гаргаж, гадаад хэлнээс орчуулах, боловсруулах ажлыг хийсэн.
- “Түлш, эрчим хүчний салбарын 2017 оны их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-нд “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын гол” ХК-ийн төлөвлөгөөний үзүүлэлтийг нэгтгэж БТГ-т хүргүүлсэн.
- Эрчим хүчний сайдын 2016 оны 24 тоот “Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах” тухай тушаалд заасан төлөвлөгөөний дагуу ТБХЗГ-т хамаарах ажлын биелэлтийг гарган хуулийн хэлтэст хүргүүлсэн.
- Эрчим хүчний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөв.
- Эрчим хүчний сайдын Шивээ-Овоо төслийн талаар БНХАУ-ын “Стэйт Грэйд” ТӨХК-тай хийсэн уулзалтанд оролцож, тэмдэглэлийг ГХАХ-тэй хамтарч бэлдэв.
- “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн уурхайн техник ашиглалт болон дизель түлшний мэдээг авч нэгтгэн, хяналт тавин ажилласан.
- Чойр 220/110/35/6 КВт дэд станцын 220/110КВт хуваарилах байгууламжийн өргөтгөл шинэчлэлтийн ажлын зургийн даалгавар орчуулав.
- Эрчим хүчний яамны 2016 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисст газрын мэргэжилтэн Э.Жаргалмаа томилогдон ажилласан.
- ТБХЗГ-ын албан хаагчдын 2016 оны үр дүнгийн гэрээний биелэлт, тайланг жилийн эцсийн байдлаар гаргуулж, дүгнүүлэн ТЗУГ-т хүргүүлэв.
- Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт, ЭХЯ-ны 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган ТЗУГ-т хүргүүлэв.

- Ирэх оны 1-2-р улиралд гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг гаргаж Газрын даргад танилцуулав.
- ТБХЗГ-ын үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж ТЗУГ-т хүргүүлэв.
- ТБХЗГ-ын төрийн албан хаагчдын сар бүрийн ажлын цагийн балансыг тухай бүр гаргаж ТЗУГ-т хүргүүлсэн.
- ТБХЗГ-ын 7 хоног бүрийн ажлын тайланг ХШҮДАГ-т, сар бүрийн тайланг ТЗУГ-т гарган өгсөн.
- 2016 оны 12 дугаар сарын 28-ны байдлаар тус газарт нийт 170 албан бичиг ирсэнээс өргөдөл 2 ирсэн ба тус өргөдлүүдийг шийдвэрлэхээр судалж байна.Хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй.Дотоод газруудаас нийт 79 бичиг ирснийг тухай бүрт хяналтад аван, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллав.

Гадаад томилолт:

- БНХАУ-ын Бээжин хотод 2016 оны 10 дугаар сарын 13-15-ны хооронд “Нэг Бүс-Нэг Зам” чуулга уулзалтад газрын дарга Н.Болдхүү томилогдон ажиллав.
- “Сингапурын Эрчим Хүчний 7 хоног” арга хэмжээнд газрын дарга томилолтоор ажиллав.
- Япон улсын Яокохама хотод 12 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 10-ны хооронд Монгол улсын Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд зохиогдсон сургалтад ЭХНХХэлтсийн дарга Д.Даваасүрэн оролцов.

Дотоод томилолт:

- “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, үйл ажиллагааг тогтворжуулах, авахад бэлэн нүүрсний нөөцийг бүрдүүлэх, уурхайнуудын төсвийн зээлийн зарцуулалтад хяналт тавьж, ажиллах үүрэг бүхий байнгын Ажлын хэсэг байгуулагдан Шивээ-овоо, Багануурын уурхайнуудад албан томилолтоор ажиллав.
- Эрчим хүчний сайдын “Багануур”ХК, Багануурын ДС, Налайхын ДС-ын өвөлжилтийн бэлтгэл ажилтай газар дээр нь биечлэн танилцах ажлыг зохион байгуулж, томилолтоор ажиллав.
- Эрчим хүчний салбарын үйлдвэр, уурхай, компаниудын үйл ажиллагаатай танилцах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах зорилготой Дорнод, Хэнтий, Говьсүмбэр аймгууд болон Багануур дүүрэгт ажиллаж буй дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт ТБХЗГ-ын дарга Н.Болдхүү, ахлах мэргэжилтэн Э.Энх-Очир нар томилолтоор ажиллав.
- Эрчим хүчний нүүрс олборлогч “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаатай танилцахаар ТБХЗГ-ын дарга Н.Болдхүү, ХШҮДАГ-ын дарга Б.Сандуйжав, сайдын зөвлөх Б.Баярбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр томилолтоор ажиллав.
- Эрчим хүчний нүүрс олборлогч “Шарын Гол” ХК-ийн өнөөгийн байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай газар дээр очиж танилцан, томилолтоор ажиллав.
- Багануур дулааны станц ТӨХК-ийн 4, 9 дүгээр зуухнуудын ул ширмийг өөрчлөн хагас кокс үйлдвэрлэхээр тохируулга хийсэн талаар ЭХЯ-ны өргөтгөсөн шуурхайд хэлэлцэгдсэний дагуу тус үйлдвэрийн байдлыг газар дээр нь үзэж сайдад танилцуулахаар Санхүүгийн хэлтсийн дарга Б.Баясгалан, ТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Э.Энх-Очир, ХШҮДАГ-ын мэргэжилтэн Г.Мөнхцоодол, ТБХЗГ-ын мэргэжилтэн С.Ариунболд нар тус үйлдвэрт томилолтоор ажиллав.
- Шивээ-Овоогийн уурхайн өнөөгийн байдал, техникийн бэлэн байдал, авахад бэлэн нүүрсний нөөц, алхагч экскаваторуудын засвар үйлчилгээний байдал зэргийг газар дээр нь очиж танилцав.

Албан бичиг:

- Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн найдвартай тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор “Багануур” ХК-д олгосон төсвийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хоцорч байгаагийн зэрэгцээ гэрээнд заасан хугацаанд төлбөрийг бүрэн барагдуулах боломжгүй байдал үүсээд байгаа. Иймд Багануурын уурхайгаас дулааны цахилгаан станцуудад нийлүүлж байгаа нүүрсний төлбөрийн шилжүүлгийг 2016 оны 12 дугаар сар дуустал түр хугацаагаар зогсоон хуримтлуулж, төсвийн зээлийг эргэн төлөх, төрийн санд нэгтгэн төвлөрүүлэхэд анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах чиглэлийг “ДЦС-2” ТӨХК, “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-4” ТӨХК-д б/3269 тоот албан бичгээр хүргүүлэв.
- Эрчим хүчний нүүрсний уурхайнууд болон шинээр баригдах эрчим хүчний эх үүсвэрүүдийн нүүрсний нөөцийн асуудал нь эрчим хүчний сайдын эрхлэх ажлын хүрээнд хамрагдах болсонтой холбогдуулан Шивээ-Овоогийн нүүрсний ордод тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа Шивээ-Овоо ХК-ийн 901А, Эрдэнэс Монгол компанийн 13311А, 13312А, 13313А, Шинэшивээ ХХК-ийн 2019А, 2020А, 2021А, 2023А, 2024А, 8829Х, 8830Х талбайнуудын нүүрсний геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийн талаарх мэдээлэл хүссэн албан тоотыг АМГТГ-ын дарга н.Баатарцогтод явуулсан.
- Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд Төвийн бүсийн эрчим хүчний системийн дулааны станц, дулааны цахилгаан станцуудад шаардагдах нүүрсний хэмжээ, саналыг авч нэгтгэн Багануур, Шивээ-Овоогийн уурхайн уулын ажлын төлөвлөлт, нүүрс нийлүүлэх саналтай уялдуулж 2017 оны 1 дүгээр сард тээвэрлэх нүүрс, вагон захиалгын хуваарийн зохицуулалтыг хийн “УБТЗ” ХНН, “ДЦС-2” ТӨХК, “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-4” ТӨХК, “Дарханы ДЦС” ТӨХК, “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК, “Амгалан ДС” ХХК-иудад 4/3431 тоот албан бичгээр хүргүүлэв.
- 2016-2017 оны халаалтын улиралд “Амгалан ДС” ХХК-ийн нүүрс татан авалт, нийлүүлэлтийн хуваарийг гаргаж, тус компанид албан тоотоор хүргүүлэв.
- “Монголын Алт (МАК)” ХХК-ийн хүсэлттэй танилцан, хариуг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 10 дугаар сарын 27-ны в/2743 тоот албан бичгээр хүргүүлэв.
- Эрчим хүчний салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажил, найдвартай ажиллагааг хангах хүрээнд ДЦС-уудын нүүрсний нөөцтэй газар дээр нь очиж танилцсаны улмаар “ДЦС-3” ТӨХК-д нүүрсний нөөцийг ахиулж, зохих хэмжээнд хүргэх талаар 4/2660 тоот албан бичгээр мэдэгдэв.
- “Шарын Гол” ХК-иас Эрчим хүчний сайд болон ТБХЗГ-т ирүүлсэн салбарын өр, авлага, нүүрсний үнийг нэмэгдүүлэх, улсын нөөцийн шатахуун түлшний асуудлаар дэмжлэг хүссэн тухай албан бичигт холбогдох хариуг “Шарын Гол” ХК-д б/2660 тоот албан бичгээр хүргүүлэв.
- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2015 оны 03 дугаар тогтоолын биелэлтийг гаргуулахаар ЭХХТөвд 4/2699 албан тоот хүргүүлэв.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулж буй “Монгол орны 2015-2016 оны Байгаль орчны төлөв байдлын тайлан”-д усан цахилгаан станцууд, дулааны цахилгаан станцууд болон дулааны станцын үйлдвэрлэсэн цахилгаан, дулааны эрчим хүч, ашигласан усны хэмжээг тусгуулах мэдээллийг ирүүлэх тухай албан тоотыг эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд 4/3114, 4/3115 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Хүйтний эрч эрс нэмэгдэж, ачаалал ихсэж байгаатай холбогдуулан төв суурин газар, аймаг орон нутгийн дулааны станц, халаалтын зуухнуудын гадна талбайд нүүрсний нөөцийг 20 хоногоос доошгүй байхаар тооцож бүрдүүлэх чиглэлийг нүүрсний уурхайнуудад а/3075 тоот албан бичгээр хүргүүлэв.

- “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 2016-2020 оны техник болон технологийн шинэчлэлийн нэгдсэн төлөвлөгөө”-нд орон нутгийн түлшний хангамжийг бүрдүүлж байгаа нүүрсний уурхайнуудаас саналыг авах, мэдээлэл ирүүлэх тухай 2016.11.30-ны 4/3091 тоот албан бичгийг 25 компани, аж ахуйн нэгжид хүргүүлэв.
- “УБТЗ” ХНН-ийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, вагон хангалтыг нэмэгдүүлэх асуудлаар харилцан тохиролцоонд хүрснээр 2016 оны 12 дугаар сарын вагон захиалга, хангалтад орсон нэмэлт өөрчлөлт, шинэчлэгдсэн хуваарийг ДЦС-ууд болон уурхайнуудад 4/3111 тоот албан бичгээр хүргүүлэв.
- БОАЖЯ-аас ирүүлсэн “Агаарын бохирдолын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дах хэсэгт “Агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авах журам” боловсруулах ажлын хэсэгт ЭХНХХэлтэсийн дарга Д.Даваасүрэн, ТБХЗГ-ын мэргэжилтэн С.Ариунболд, БХЗГ-ын мэргэжилтэн Б.Баттөмөр нарын нэрийг оруулахаар в/2855 тоот албан бичиг хүргүүлэв.
- Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Амгалангийн дулааны станцын ойролцоох аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхийг дулаан хангамжийн нэгдсэн системд шилжүүлэхтэй холбоотойгоор гарах тооцоо, судалгаа, төсөвт өртөг зэргийг тооцуулахаар УБДС ТӨХК-д в/2976 тоот албан бичиг хүргүүлэв.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газарт “ДЦС-4” ТӨХК, “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-2” ТӨХК болон “Амгалан ДС” ХХК-ийн 2016 оны нүүрсний хэрэглээ, нийслэл хотод нүүрс нийлүүлдэг уурхайнуудын 2016 оны нүүрс олборлох төлөвлөгөө зэрэг мэдээллийг бэлтгэж хүргүүлэв.
- Гэр хорооллын айл өрхийн халаалтыг цахилгаан халаагуураар шийдвэрлэхтэй холбоотойгоор дамжуулах сүлжээг өргөтгөх тооцоо, судалгаа болон шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг нарийвчлан гаргуулахаар “ЦДҮС” ТӨХК-д в/3031 тоот албан бичиг хүргүүлэв.
- Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Бүгдэд тогтвортой эрчим хүч” төслийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр орон нутагт “Сайжруулсан зуух”, “Бага оврын нарны цахилгаан үүсгүүр” хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын хүрээнд “Малчдын эрчим хүчний хангамжийг сайжруулах” төслийн хураангуйг боловсруулж, НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч Рашел Кейтэд шинэ жилийн мэндчилгээ болон “Буман нарны гэрэл” төслийн 2-р үе шатыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай бичгийн төслийг боловсруулсан.
- Сайдын Азийн хөгжлийн банкны төлөөлөгчтэй уулзах уулзалтанд холбогдуулан тус банкны хүрээнд хэрэгжүүлж болох түлшний чиглэлийн төслүүдийн саналыг боловсруулж, удирдлагад танилцуулан, гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлэв.
- Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших Монголын Алт /МАК/ ХХК-ийн Адуунчулууны уурхайн нүүрсний чанар ДЦС-ын технологийн шаардлагыг хангах эсэх асуудлыг Эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх хүсэлтэд хариу санал бэлтгэж удирдлагад танилцуулан, Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэв.
- БОАЖЯ-аас боловсруулж буй “Монгол орны 2015-2016 оны Байгаль орчны төлөв байдлын тайлан”-д тусгагдах усан цахилгаан станцууд, дулааны цахилгаан станцууд болон дулааны

станцын үйлдвэрлэсэн цахилгаан, дулааны эрчим хүч, ашигласан усны хэмжээг салбарын үйлдвэр компаниудаас авч нэгтгэн БОАЖЯ-нд в/3166 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар:

Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас эрчим хүчний салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад чиглэсэн дотоод хяналт шалгалт, аудит, техник хяналтыг хэрэгжүүлэх, статистик мэдээллийн сан бүрдүүлэх, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх гол зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд 2016 онд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Нэг Хяналт-шинжилгээний ажлын хүрээнд:

Хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах үйл явц нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын хүрээнд хийгддэг. 2016 онд тус газраас хийсэн гол гол хяналт-шинжилгээний ажлуудыг багцалбал:

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан **Үндэсний хөгжлийн цогц бодлого**-д тусгагдсан эрчим хүчний салбарын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийн 2015 оны тайлан, статистик тоо, мэдээллийг боловсруулж, удирдлагад танилцуулан 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн в/344 тоот албан бичгээр ЗГХЭГ, Сангийн яаманд тус тус хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2015 оны жилийн эцсийн хэрэгжилт, 2016 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөв. Хяналт-шинжилгээний дүнг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хуралдааны тэмдэглэлийн хамт 2015 оны жилийн эцсийн тайланг 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн а/339 тоот албан бичгээр, 2016 оны эхний хагас жилийн тайланг 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн а/1973 тоот албан бичгээр тус тус ЗГХЭГ-т хүргүүлэв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

- УИХ-ын 2014 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, сайдын зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, тайланг 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн в/333 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв.
- УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2016 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн в/1971 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв.

Холбогдох эрх зүйн актын хяналт-шинжилгээ: Эрчим хүчний яамны хяналтад байгаа Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж болон хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурлын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий

сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 2015 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн в/125 тоот албан бичгээр, 2016 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, хяналтаас хасуулах саналыг хамт 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн а/1972 тоот албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэл, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийг тухай бүр **Засгийн газрын хяналт-шинжилгээний нэгдсэн систем** /www.unelgee.gov.mn/-байршуулж, баталгаажуулан ажиллав.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах үйл ажиллагаа: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 266 дугаар захирамжаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-д заасан эрчим хүчний салбарын мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан ҮАБЗ-ийг мэдээллээр хангах журмын дагуу холбогдох мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулан 2016.01.08-ны өдрийн в/55, 2016.04.06-ны өдрийн в/1022, 2016.07.05-ны өдрийн в/1957, 2016.10.05-ны өдрийн в/2536 тоот албан бичгээр ҮАБЗ-ийн Ажлын албанд тус тус хүргүүлэв.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ: Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээний нийтлэг журам”-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2015 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг /157 хуудас/ боловсруулж, удирдлагуудад танилцуулан ЗГХЭГ-т 2016-03-30-ны өдрийн а/949 тоот албан бичгээр хүргүүлэв.

Засгийн газрын 2015 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 4.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрчим хүчний салбарын захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд ХШҮ хийж, санал дүгнэлтийг боловсруулан удирдлагад танилцуулж, 2016.06.10-ны өдрийн в/1730 тоот албан бичгээр Хууль зүйн яаманд хүргүүлэв.

Эрчим хүчний яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан дүгнэлтийг яамны удирдлагад 2016 оны 07 дугаар сарын 25-нд танилцуулав.

Эрчим хүчний сайд болон аймгуудын Засаг дарга нарын хооронд 2015 онд байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж тайлан, зөвлөмж боловсруулан удирдлагуудад танилцуулж, тайланг ТЗУГ-т шилжүүлэв.

Эрчим хүчний сайд болон “Эрчим хүчний хөгжлийн төв”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын захирал, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн захирал хооронд 2015 онд байгуулсан гэрээний биелэлтэд ХШҮ хийж, тайланг боловсруулан удирдлагуудад танилцуулан, ТЗУГ-т шилжүүлэв.

Эрчим хүчний салбарын чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ, хэлцэл, санамж бичгүүд тэдгээрийн хэрэгжилт, явцын байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан дүгнэлтийг сайд, дэд сайд, ТНБД-д тус тус танилцуулсан.

Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд 2015 оны жилийн эцэс, 2016 оны эхний 8 сарын байдлаар хяналт-шинжилгээ хийж, тайлан дүгнэлтийг удирдлагад танилцуулав.

Эрчим хүчний сайдын 2016 оны 65 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “ДЦС-3” ТӨХК-ийн их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлаар 2015, 2016 онуудад төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, тэдгээрийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг хийж гүйцэтгэв. Ажлын хэсэг тайлан, дүгнэлтийг боловсруулж, ТНБД-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлэн болгосон.

Эрчим хүчний салбарын ТӨХК-иудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 2016 оны эхний 8 сарын байдлаарх биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн компани тус бүрт авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төслийг боловсруулан удирдлагад танилцуулж, 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн а/2709 тоот албан бичгээр ХШҮ-нд хамрагдсан 21 компанийн гүйцэтгэх захирал нарт хүргүүлэв. ХШҮ-ний тайланг дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, сайдын зөвлөх нарт тус тус өгч мэдээллээр хангав.

Эрчим хүчний яамны удирдлагуудын 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн шуурхай зөвлөлгөөнөөс дэд сайдын өгсөн үүрэг, даалгаврын дагуу салбарын ШУТЗ-өөр дэмжигдсэн ТЭЗҮ, олгогдсон тусгай зөвшөөрлүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагуудад танилцуулав.

Яамны удирдлагын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүргийн дагуу Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр үйлдвэрлэсэн ЦЭХХАГ-нүүдэд ХШҮ хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралд танилцуулав. Эрчим хүчний сайдын 2016.10.25-ны өдрийн 53 дугаар тушаалаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг батлуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас эрчим хүчний салбарт 2016 оны 04 дүгээр сар, 2016 оны 11 дүгээр саруудад хийгдсэн үзлэг, шалгалтын ажлыг салбарын үйлдвэр, компаниудад зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, холбогдох тайлан мэдээг тухай бүр гарган өгч, шалгалтын ажлын хэсгийг мэдээ мэдээллээр хангаж ажиллав.

Хоёр. Техник хяналтын хүрээнд:

Салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй ажиллагаа, техник, технологийн үйл ажиллагаанд хийдэг ээлжит үзлэгийн удирдамж, үзлэгт хамруулах байгууллагуудыг өмнөх оны үзлэгийн эрсдэлийн түвшинд үндэслэн тогтоож Эрчим хүчний сайдын 2016 оны 67 дугаар тушаалаар, ажлын хэсгийн хуваарь, бүрэлдэхүүн, төсвийг ТНБД-ын 2016 оны 108 дугаар тушаалаар тус тус батлуулсан бөгөөд “ББЭХС” ТӨХК болон түүний Ховд, Баян-Өлгий аймаг дах салбар, “Ховдын ЦТС” ХХК, “Увс ЦТС” ХХК, Баян-Өлгий аймгийн ЦШСГ, “Эрчим” ХК, Ховд, Увс аймаг дах шинэ дулааны станцын үйл ажиллагаанд 2016 оны 4 дүгээр сарын 27-оос 5 дугаар сарын 08-ны өдрүүдэд, “ЭБЦТС” ТӨХК-ийн Хархорин, Архангай салбар, “АУЭХС” ТӨХК-ийн Завхан салбарын үйл ажиллагаанд 2016 оны 7 дугаар сарын 18-аас 7 дугаар сарын 27-ны өдрүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн үйл ажиллагаа, мэдлэгийн түвшин тогтоох шалгалт гэсэн гурван үндсэн чиглэлд хийж, өмнөх жилүүдэд хийсэн үзлэгтэй харьцуулан тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөөгөөр ханган, ажлын байран дээр архи дан согтуурсан “ББЭХС” ТӨХК-ийн 1 ажилтанд компанийн захирлын тушаалаар арга хэмжээ авахуулж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу МХЕГ-аас баталсан хяналтын хуудсаар гүйцэтгэлээ. Үзлэгийн мөрөөр “ЭБЦТС” ТӨХК, “АУЭХС” ТӨХК-уудад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллав.

Эрчим хүчний сайдын тушаалаар БУА нь дууссан төсөл арга хэмжээний ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комисст ажиллав.

Түлш эрчим хүчний сайдын 2007.06.19-ний өдрийн 53 дугаар тушаалаар баталсан “Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш болон тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам”-ийг хянаж нэмэлт, өөрчлөлт хийх санал бэлтгэж, “Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдваржилтын зэрэглэл тогтоох журам”-ын төслийг шинэчлэн боловсруулсан.

“Нэгдсэн сүлжээний дүрэм”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ШУТЗ-ийн 2016.01.28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг уг дүрмийн дагуу “ДҮТ” ХХК-аас яамны ШУТЗ-д дахин оруулж хэлэлцүүлэхээр “ДҮТ” ХХК-д 2016.02.23-ны өдрийн в/569 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөлтэй танилцаж Монгол Улсын Засгийн газрын “Эрчим хүчний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 315 дугаар тогтоолоор эрчим хүчний нөөц тэжээлийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэхээр зааж хэрэгжих шатандаа байгаа тул төлөвлөгөөний 2.13-т “Газар хөдлөлтийн гамшгийн үед эрчим хүчний хангамжийг нэн тэргүүнд сэргээн босгох шаардлагатай дулааны станц, эмнэлэг, ус сувгийн газар, бохирын станц, гал команд, удирдлагын байр, холбоо, төв телевиз, нисэх буудал гэх мэт нэгдүгээр зэргийн хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель станц/-тэй болох” гэснийг хасах, Газар хөдлөлтийн гамшгийн үед гэмтсэн дулааны болон бохирын шугам хоолойг сэргээн засварлахад шугамын сувгаас ус зайлуулах насосыг улсын нөөцөд байлгах шаардлагатай байгаа тул төлөвлөгөөний 2.15-д заасныг хариуцах байгууллагыг “ОБЕГ, БХБЯ, ЭХЯ” гэж өөрчлөх эсвэл “Дулааны шугамд гарсан гэмтлийг сэргээн засварлах үед шугамын сувгаас ус зайлуулах өндөр хүчин чадал бүхий насос авах” гэж өөрчлөх, төлөвлөгөөний нэгдүгээр хэсгийн 1.16-д “Эрчим хүчний хэрэглэгчийн зэрэглэл тогтоох журам”-ын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах” /2016 он/ гэж нэмэх саналыг ТЗУГ-т өгсөн.

Эрчим хүчний салбарын хяналтын ажилтнуудын зөвлөлгөөнийг 2016 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-тай хамтран зохион байгуулж 35 байгууллагын 104 ИТА, ажилтан хамрагдсан. Зөвлөлгөөнөөс зөвлөмж гарган салбарын үйлдвэр, компаниудад хүргүүлэв.

“Эрчим хүчний барилга байгууламж, түүнд тавигдах шаардлага” сэдэвт зөвлөлгөөнийг 2016.04.08-ны өдөр зохион байгуулж, тус зөвлөлгөөнд МХЕГ, ОБЕГ, салбарын болон зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий 53 аж ахуйн нэгж, байгууллагын 101 ИТА, эксперт, удирдах ажилтнууд хамрагдав.

Салбарын үйлдвэр, компаниудад, тухайлбал “ББЭХС” ХК-ийн ХАБЭА-н инженер Д.Оюунцэцэг, “АУЭХС” ХК-ийн ХАБЭА-н инженер Д.Бадамханд, БЗӨБЦТС ХК-ийн ХАБЭА-н инженер Д.Ганцэцэг, “ЭБЦТС” ХК-ийн Хяналтын хэлтсийн дарга Б.Ганчулуун, “УБЦТС” ХК-ийн ХААХ-ийн дарга Н.Баярсайхан, ХАБЭА-н инженер Т.Дашдаваа, “Хөвсгөл ЭХ” ХХК-ийн ХАБЭА-н инженер н.Батлхагва нарт ажлын байрны эрсдэлийг үнэлэх арга, аргачлалын талаар болон “УБЦТС” ХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу хаалттай дэд станцад техникийн аудитыг хэрхэн гүйцэтгэх талаар аргачлал боловсруулж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан.

Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хэрхэн гүйцэтгэдэг талаарх мэдээллийг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвөөс, шуурхай ажиллагааны ажилтны ангилалын талаарх мэдээллийг “УБЦТС” ТӨХК-иас тус тус авч “БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХАБЭА-н инженер н.Нямтуяа, “ЭБЦТС” ТӨХК-ийн ХАБЭА-н инженер н.Энхзул нарыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангалаа.

“ЦДҮС” ТӨХК-ийн Багануур зүүн өмнөд бүсийн салбарын хүсэлтээр тус салбарын шуурхай ажиллагааны 24 ИТА-д шинээр болон шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт орсон хууль, дүрэм, журмын талаар танилцуулга хийж, “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ” сэдвээр 3 цагийн хичээл, “ЦДҮС” ТӨХК-ийн хүсэлтээр 2016.02.19-ний өдөр тус компанийн 50 гаруй ИТА нарт эрчим хүчний аюулгүй байдал, нарядын систем, аюулгүй ажиллагааны хууль, дүрмийн талаар 4 цагийн хичээл, ЭХХТ-ийн Захиалагч, техникийн хяналтын хэлтсийн инженерүүдэд аюулгүй ажиллагааны 20 цагийн хичээл, “ДБЭХС” ТӨХК-ийн Сүхбаатар салбараас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу 2016.03.28-ны өдөр тус салбарын 36 ИТА-д “Эрчим хүчний аюулгүй байдал”, “Технологийн зөрчил, түүнийг ангилан бүртгэх нь”, “Нарядын систем”, “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ”, “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм” зэрэг сэдвээр 8 цагийн хичээл тус тус заасан.

“ЦДҮС” ТӨХК-ийн Хангайн бүсийн салбарын ХАБЭА-н инженер н.Тунгалаг, “ЭБЦТС” ТӨХК-ийн хяналтын инженер н.Энхзул нарт “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн ажлын байр бэлтгэх, ажилд оруулахтай холбогдуулан мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгсөн.

Салбарын үйлдвэр, компаниудын хэмжээнд гарсан аваари, тасралт, саатлын мэдээг цахим хэлбэрээр авч хамтарч ажиллах талаар албан тоотыг хүргүүлж, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн мэдээллийн технологи холбооны албаны инженертэй хамтран салбарын үйлдвэр компаниудаас цахим хэлбэрээр технологийн зөрчлийн мэдээллийг авч байх программыг бэлэн болгож www.energy.mn сайтад байршуулж цахим хэлбэрээр авч байна.

Нэгдсэн сүлжээнд аваари саатал гарах үед үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шуурхай устгах дадлага чадварыг дээшлүүлэх, гарсан аварийн үед алдаа дутагдал гаргуулахгүй байх зорилгоор 2016 оны зуны бага ачааллын үеийн Аваари эсэргүүцэх дасгалыг Ил хуваарилах байгууламж 4-ийн 110 кВ-ын I систем шин талд гарсан богино залгааны үед ДЗШ хамгаалалт буруу ажилласны улмаас нэгдсэн сүлжээ хэд хэдэн хэсэгт хуваагдах, ДЦС-уудад гарах хүндрэлтэй нөхцлийг сонгох” сэдвээр 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 11 цагийн хэрэглээг үндэслэсэн нөхцөлөөр хийхэд хяналтаар “ДҮТ” ХХК-тай хамтран ажиллаж, хяналт тавин ажиллав.

Гурав Дотоод аудитын хүрээнд:

Эрчим хүчний Сайдын 2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 09 дүгээр тушаалаар баталсан дотоод аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“Дулааны хоёрдугаар цахилгаан станц-2” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтийн байдалд 2016 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 18-ыг хүртэлх хугацаанд аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн зөвлөмж гарган “ДЦС-2” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэв.

Эрчим хүчний сайдын 2016 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 25 дугаар тушаалаар батлуулсан дотоод аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн, аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн батлуулж, зөвлөмжийг тус компанид хүргүүлэв.

Эрчим хүчний Сайдын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 62 дугаар тушаалаар баталсан дотоод аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“ДЦС-3” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд гүйцэтгэж, аудитын тайланг Эрчим хүчний Сайд бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх аудитын хороогоор хэлэлцүүлэн, зөвлөмжийг тус компанид хүргүүлж ажиллав.

Эрчим хүчний Сайдын 2016 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 68 дугаар тушаалаар баталсан дотоод аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“Налайхын дулааны станц” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг АОУСтандарт, Сангийн сайдын 116 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудит явуулах заавар”-ын дагуу 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн тайланг боловсруулан, аудитын тайланг Эрчим хүчний сайд бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх аудитын хороогоор хэлэлцүүлэн, зөвлөмжийг тус компанид хүргүүлж ажиллав.

Эрчим хүчний Сайдын 2016 оны 06 дүгээр сарын 03-ны өдрийн 88 дугаар тушаалаар баталсан дотоод аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг АОУСтандарт, Сангийн сайдын 116 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудит явуулах заавар”-ын дагуу 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн тайланг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх аудитын хороогоор хэлэлцүүлэн, зөвлөмжийг тус компанид хүргүүлж ажиллав.

Эрчим хүчний сайдын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тушаалаар баталсан аудит гүйцэтгэх удирдамжийн дагуу **“Дулаан шарын гол” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэж Аудитын хорооны гишүүдэд танилцуулан, зөвлөмжийг хүргүүлж ажиллав.

Эрчим хүчний сайдын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 74 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу **“Багануур Зүүн өмнөд бүсийн ЦТС” ТӨХК**-ийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг 2016.11.14-2016.12.02-ны хооронд хийж гүйцэтгэв. Тайланг Аудитын хорооны гишүүдэд танилцуулав.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг салбарын үйлдвэр, компаниудаас гаргуулан авч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Төрийн нарийн бичгийн 2016 оны 03 дугаар сарын 81 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу **“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ**, **“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ**-уудын бүтэц, зохион байгуулалт, байгууллагын дүрмийн хэрэгжилт болон норм, норматив боловсруулах сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалтыг хийж тайлан дүгнэлтийг ТНБД-д танилцуулсан. “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай Эрчим хүчний сайдын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 80 дугаар тушаал гарган батлуулж, мөрдүүлэн ажиллаж байна.

Сангийн яамнаас ирүүлсэн зааврын дагуу 2016 оны эхний хагас жилд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн тоо, мэдээ болон аудитын бичмэл тайланг нэгтгэн газрын даргаар батлуулан цахимаар болон албан тоотор Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт хүргүүлэв.

Дөрөв: Статистик мэдээ, мэдээллийн хүрээнд:

Эрчим хүчний салбарын борлуулалтын болон үйлдвэрлэлтийн мэдээг сар бүрийн эхний 5 хоногт багтаан салбарын үйлдвэр, компаниудаас авч нэгтгэн, боловсруулж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлж ажиллав. 2016 онд нийт 11 удаагийн мэдээг хүргүүлж ажиллалаа. Борлуулалтын орлого 2016 оны эхний 11 сарын өссөн дүнгээр **655,8** тэрбум төгрөг гарч, төлөвлөгөөнөөс **2,89** хувь, өнгөрсөн оны мөн үеэс **13,91** хувиар өссөн байна. 2016 оны эхний 11 сарын өссөн дүнгээр нийт **4416,1** сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөнөөс **1.75** хувь, өнгөрсөн оны мөн үеэс **3,04** хувиар өссөн байна. Мөн нийт **6622,1** мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөнөөс **4,6** хувь, өнгөрсөн оны мөн үеэс **4,13** хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлт болон борлуулалтын мэдээг сар бүр салбарын үйлдвэр компаниудаас авч нэгтгэн боловсруулж, тухай бүр нь яамны цахим хуудсанд байршуулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллав.

Эрчим хүчний үндэсний баланс гаргах үйл ажиллагааны хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд баг гарган ажиллаж байна. Эрчим хүчний үндэсний баланс тооцоолох аргачлалыг боловсронгуй болгох, эрчим хүчний данс буй болгох чиглэлээр Үндэсний Статистикийн Хорооны төслийн зөвлөхүүдийн хүрээнд зохион байгуулсан хамтарсан 3 удаагийн семинарт баланс тооцоолох ажилтнуудыг оролцуулав. Эрчим хүчний үндэсний баланс тооцоолоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэр олж авах газруудыг тодотгон Үндэсний Статистикийн Хорооноос холбогдох маягтууд, түүнийг гаргах аргачлал бэлэн болж баталгаажигдсан. Мэдээлэл цуглуулах, түүвэр судалгаа хийх ажил эхлэлийн шатанд үргэлжилж байна. 2017 онд үргэлжлэн хийгдэхээр төлөвлөгдөөд байна.

Тав. Дотоод ажлын хүрээнд:

- Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилан сар бүрийн ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, тайланг ТЗУГ-т хүргүүлж ажиллав.
- ХШҮДАГ-ын мэргэжилтнүүд Төрийн албан хаагчийн 2016 оны үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан газрын даргаар батлуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийг 2016 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж, газрын даргаар үнэлүүлэн ТЗУГ-т хүргүүлэв.
- Газрын бүх төрийн албан хаагчид Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж, эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд нь тайлагнасан.
- 2016 онд Эрчим хүчний яамны 7 хоногийн ажлын тайланг нийт 54 удаа нэгтгэн боловсруулж, эмхэтгэл хэвлэн яамны удирдлага болон шуурхай хуралдаанд оролцдог харьяа байгууллагуудын удирдлагад хүргүүлж, цаг үеийн мэдээллээр хангаж ажилласан.
- 2016 оны 12 сарын байдлаар тус газарт нийт 452 албан бичиг, өргөдөл ирснийг бүртгэн хяналтад авч, тухай бүр газрын даргад танилцуулан, цохогдсон албан хаагчдад шилжүүлэн ажилласан. 2016.12.25-ны өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн бичиг байхгүй, нийт 5 өргөдлийн 3-ыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг өгсөн, 2 өргөдлийг шийдвэрлэхээр судалж

байна. Яамны газруудаас тус газарт нийт 141 саналын бичиг ирснийг тухай бүр хариуг өгч ажиллав.

- ЗГХЭГ, олон улсын байгууллага, яам болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан ХШҮ, дотоод аудит, статистик мэдээлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, гамшгийн чиглэлээрх сургалт, семинарт газрын төрийн албан хаагчид хамрагдав.

Төрийн захиргааны удирдлагын газар:

Нэг. Хүний нөөц, сургалтын чиг үүргийн хүрээнд:

2016 онд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг гаргаж холбогдох тайлангийн хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн яамны албан хаагчдын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг цаасан хэлбэрээр авч цахимаар баталгаажуулсан.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.4 дэх заалтууд, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх журам”-ын 13-т заасны дагуу тус яамны төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний 2016 оны тайланг Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программд /ХНУМСП/ бүрэн тусгаж, хавсралтаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

“Эрчим хүчний салбарын хамтын 2015-2016 оны хамтын /тариф/-ын хэлэлцээр” байгуулах төрийн захиргааны төв байгууллагыг төлөөлөх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг Эрчим хүчний сайдын тушаалаар баталгаажуулж, тушаалыг холбогдох эздэд нь хүргүүлсэн.

ЭХХТ-тэй хамтарч салбарын ахмадуудаа хүлээн авах Сар шинийн ажлыг зохион байгуулж, яамны удирдлагуудыг оролцуулсан.

ЭХИС дээр явагдсан төсөвчний анхан шатны сургалтанд хамрагдсан 20 хүнд батламжилсан гэрчилгээ олгох Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулж баталгаажуулсан.

Яамны албан хаагчдын 2016 оны ээлжийн амралтын хуваарийг батлуулах саналыг холбогдох газруудаас авч Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар бүх албан хаагчдын ээлжийн амралтыг биеээр эдлүүлсэн.

Яамны дэргэдэх ТАСЗ-өөс "2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г ТАСЗ-эвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан./Хавсралт/ төлөвлөгөөний биелэлт 100%-тай гарсан.

2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж 02 дугаар тогтоолоор 4 төрийн албан хаагчид зэрэг дэв шинээр олгох, 22 төрийн албан хаагчид зэрэг дэв нэмүүлэх, нийт 26 төрийн албан хаагчийн шийдвэрлүүлж, сайдын тушаалаар баталгаажуулсан.

2016 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж 01 дүгээр тогтоолоор 2 төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн.

4 төрийн албан хаагчийг мэргэжилтнээс ахлах мэргэжилтэн болгох асуудлыг хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулсан.

2016 онд салбар зөвлөлийн хуралдааныг Засгийн газрын бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор эхний хагас жилд 2 удаа зохион байгуулж нийт 9 асуудлыг хэлэлцэж салбар зөвлөлийн 4 тогтоол гаргасан байна. Хуралдааны тэмдэглэлийг тухай бүр албажуулан ажилласан.

Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдэх хүрээнд гадаад, дотоодын тэтгэлэгт сургалтад хамруулж байна. 2 төрийн албан хаагчтай гадаадад магистрын сургалтад сурах гэрээ байгуулан сургалтад хамруулаад байна. АНУ-д 1 төрийн албан хаагч, БНСУ-д 1 төрийн албан хаагч, Удирдлагын академийн магистрын сургалтад 1 төрийн албан хаагчийг суралцуулахаар гэрээ байгуулж сургалтад хамруулаад байна.

Эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүнийг сайдын тушаалаар шинэчлэн батлуулж, Зудаагийн сургалтыг ЭХИС дээр зохион байгуулж, ТнБД-ын тушаалаар зөвлөх инженер, мэргэшсэн инженерийн зэрэг, мэргэшсэн инженерийн зэрэг сунгах, төсөвчний анхан шатны зэргийг олгуулах ажлыг зохион байгуулж байна.

Хөдөлмөрийн дотоод журамд зааснаар төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй гэр, хашаа байшинд амьдарч байгаа 6 хүнд түлээ, нүүрсний хөнгөлөлтөнд 840,000 төгрөгийн мөнгөн тусламж олгосон байна. Төрийн 4 албан хаагчид өвчний улмаас гадаад болон дотоод эмчилгээ хийлгэх зардалд зориулж 5,5 сая төгрөгийн буцалтгүй тусламжүүлсэн.

Ар гэрт нь гачигдал тохиолдсон 5 төрийн албан хаагчид нийт 1.250.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар олгосон.

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан 15 төрийн албан хаагчид 4120000 төгрөгийн, эрчим хүчний Тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнагдсан 15 хүнд 4120000, яамны “Жуух бичиг” шагнагдсан 7 албан хаагчид 1.750.000 төгрөгийг шагналд дагалдуулж олгосон.

Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 16 төрийн албан хаагчид 50, 55 насны ойгоор нь хүндэтгэл үзүүлж 2.441.000 төгрөгийн үнэ бүхий зүйлээр шагнасан.

Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагчтай байгуулах 2016 оны үр дүнгийн гэрээг боловсруулан байгуулах, мөн Төрийн нарийн бичгийн дарга, 5 газрын дарга нартай, газрын даргаас мэргэжилтэнтэй 2016 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг нэгтгэн зохион байгуулж, нийт яамны хэмжээнд 68 төрийн жинхэнэ албан хаагчид 2016 онд үр дүнгийн гэрээ байгуулсан байна. Мөн салбарын ТӨААТҮГ-ын захирлын үр дүнгийн гэрээг сайдтай байгуулах ажлыг тус тус зохион байгуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар бүх газар, хэлтсүүдийн албан хаагчдаас авч нэгтгэн дүгнүүлэх ажлыг зохион байгуулсан ба үүнээс А үнэлгээг-49, В үнэлгээг-45 албан хаагч авсан байна. Үр дүнгийн гэрээний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 12

дугаар сарын 16-ны өдрийн 152 дугаар тушаалаар яамны бүх албан хаагчдад мөнгөн урамшуулал олгогдсон.

Тус яамтай холбоотой байгаа 2016 онд Улсын Их хурлын тогтоол-0, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэл зөвлөмж-0, Засгийн газрын тогтоол-46, хуралдааны тэмдэглэл-41, ЕС-ын захирамж-26, Ерөнхийлөгчийн зарлиг-1 ирсэн байна. Эдгээрийг цаг тухай бүрд нь яамны удирдлага, газрын дарга нарт цаг танилцуулж шаардлагатай тогтоол шийдвэрийг хувиан тараах ажлыг тогтмол хийж байна.

Засгийн газрын үнэлгээ.мн-д тус яамтай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилтийг эхний хасаг жилийн байдлаар гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн

Улсын Их хурал, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын 2016 оны төлөвлөгөөг 01 дүгээр сард ТНБД-аар баталгаажуулан ЗГХЭГ-т албан тоотоор хүргүүлсэн. Төлөвлөгөөнд нийт 13 асуудал батласан бөгөөд 2016 онд хэлэлцэх асуудлыг төлөвлөгөөний дагуу ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.

Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2016 оны төлөвлөгөөнд 13 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөснөөс 1 асуудал хугацаа хойшилж 14 асуудал хэлэлцэж шийдвэр гарч төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай байна.Эдгээрийн хэрэгжилтэнд хяналтанд тавьж байгаа бөгөөд заалт тус бүрээр хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн.

2016 оны 9 дүгээр сарын 01-ний байдлаар шинээр томилогдсон удирдах албан тушаалтныг ТАЗ-өөс дүгнэлт гаргуулж томилох ажлыг зохион байгуулсан.Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ТЗУГ, БТГ-ын дарга нарыг томилох тухай ТНБД-ын тушаалыг боловсруулж албажуулсан.

Эрчим хүчний салбарын ажиллагсдыг Засгийн газрын шагнал “Эрчим хүчний тэргүүний ажилтан”, “Яамны жуух бичиг”-аар шагнаж урамшуулах Эрчим хүчний сайдын сайдын тушаалаар 2016 оны 12 дугаар сарын байдлаар нийт 5 шагналын тушаалыг боловсруулан батлуулсан. /№08, №58, №65, №73, №100, №06, №28/. 2016 оны 12 дугаар сарын байдлаар нийт шагнагдсан хүмүүс судалгааг гаргасан. Үүнд:

“ЭХТА”-аар 632

“Жуух бичиг”-ээр 297

Дотоод зохион байгуулалтын ажлын чиг үүргийн хүрээнд:

Эрчим хүчний яамны 2016 оны бүх саруудын үйл ажиллагааны тайлан мэдээг сар бүрийн 05-ны дотор албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Даваа гараг бүрийн шуурхайг зохион байгуулж тэмдэглэл хөтлөн, хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох газруудад хүргүүлж биелэлтийг нь гарган, Баасан гарагт Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар 32 удаа хуралдсан ба нийт **416** үүрэг даалгавар өгөгдсөнөөс бүрэн биелэсэн **385** хэрэгжих шатандаа буюу байнгын хяналтанд **31**, огт хэрэгжээгүй үүрэг даалгавар байхгүй. Нийт биелэлт **92,5 %**.

Дээд газраас эрчим хүчний салбарын талаар гарч хэрэгжүүлэхээр ирүүлсэн тогтоол, шийдвэрүүдийг удирдлагад танилцуулж холбогдох газарт хэвлэн тарааж цаг хугацаанд нь танилцуулах ажлыг тогтмол хийж байна. ЭХЯ-ны хяналтад буй Эрх зүйн актын хэрэгжилтийг 2016 оны эхний хагас жилийн байдлаар биелэлтийг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. Жилийн байдлаар Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурал, Засгийн газрын нийт 113 шийдвэрийн 175 заалт 90,7 хувийн биелэлттэй урьдчилсан байдлаар гараад байна.

Мөн газар, хэлтсүүдийн 7 хоногийн ажлын мэдээ тайланг нэгтгэж удирдлагуудад танилцуулж, ажлын цагийн ирц тасралтыг хурууны хээгээр бүртгэх системд оруулсны дагуу ажилтан нэг бүр дээр цаг ашиглалтанд хяналт тавьж цагийн балансыг баталгаажуулан гаргаж, СХОГ-т хүргүүлэн үндсэн цалинг олгуулсан.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас эрчим хүчний салбарын үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг хяналтанд авч хэрэгжүүлж ажилласан. Өргөдөл гомдлын тайлан мэдээг I,II, III улирал байдлаар гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн болно. 2016 онд нийт **281** өргөдөл ирсэнээс хуулийн хугацаанд **245** өргөдлийг шийдвэрлэж харьяа байгууллагад **102** иргэний өргөдлийг шилжүүлсэн, **95** иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, **36** өргөдөл хугацаа болоогүй байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн биелэлт **87,5%** хэрэгжилттэй байна.

Яамны хурлын зааланд зохион байгуулагдах хурал, семинар, уулзалтыг газар болон харьяа холбогдох байгууллагаас ирүүлсэн хурлын удирдамжийг үндэслэн зохион байгуулан ажиллаж байна. Мэдээллийн танхимд газруудаас ирүүлсэн хурлын удирдамж, төлөвлөгөөний захиалгыг авч бүртгэн хуваарийн дагуу нийт 2016 оны эхний хагас жилийн байдлаар 265 хурлыг хурлын зааланд хуваарийн дагуу оруулсан.

Яамны удирдлагуудын гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийх уулзалтыг яамны хүндэтгэлийн өрөөнд хуваарийн дагуу хурал, уулзалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Одоогоор нийт 77 үйл ажиллагаа тус өрөөнд зохион байгуулагдсан.

Эрчим хүчний яамнаас 2016 онд харьяа байгууллага иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан явуулж байна.

Эрчим хүчний салбарт Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2016 оны жилийн эцсийн биелэлтийг боловсруулж Жендерийн Үндэсний хороонд хүргүүлсэн.

Эрчим хүчний яамны нийт ажиллагсдын дунд зохион байгуулах чөлөөт цагийг идэвхитэй өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд газруудаас саналыг авч төлөвлөгөөг гарган Төрий нарийн бичгийн даргаар батлуулсан.

2016 оны 03 сарын 06-ны өдөр яамны эмэгтэй албан хаагчдад ОУ-ын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн арга хэмжээг хурлын зааланд зохион байгуулсан.

Эрчим хүчний сайдтай Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар болон ЭХЭЗХ, ЭХХТ, СЭХҮТ-ийн дарга нар үр дүнгийн гэрээнд гарын үсэг зурах ажлуудыг зохин байгуулсан.

ОУ-ын “Эх, үрсийн баярын өдөр”-ийг тохиолдуулан Эрчим хүчний яамны нийт албан хаагчид болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн ажилтнуудын 0-16 нас хүртэлх хүүхдийн судалгааг гаргаж, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулж батлуулан, хүүхдийн бэлгийг судалгааны дагуу олгосон.

Салбарын шагналд зориулан 400ш “Эрчим хүчний тэргүүний ажилтан” гэрчилгээ, 200ш “Жуух бичиг”-ийг тус тус захиалж, хүлээн авсан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гаргасан зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын мэдээг салбарын үйлдвэр компаниудаас аван 2336 тоот албан бичгээр Хүний эрхийн үндэсний комиссд хүргүүлсэн.

“Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 2016 оны биелэлтийг Хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн.

2016 оны эрчим хүчний салбарын шилдгүүдийг шалгаруулах ажлыг байгууллагуудаас ирүүлсэн материалуудтай танилцаж дууссан бөгөөд комисс хуралдаж тус бүр оноог гаргаж, нэгтгэн шийдвэрээ гаргасан.

Мэдээллийн харилцаа, цахим сүлжээний чиг үүргийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын өргөдөл гомдол санал хүсэлт хүлээн авах 11-11 төвөөр дамжин 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл Эрчим хүчний яаманд нийт 123 өргөдөл гомдол ирсэн байна. Эдгээрийн 115 өргөдөл, гомдолд хариу өгч хаасан бөгөөд 8 өргөдөл гомдолд хариу өгч шийдвэрлэх шатандаа явж байна. Эдгээр өргөдлийн дийлэнх нь ЭХЗХ-ны шийдвэрээр айлуудын цахилгаан дулааны төлбөр дээр Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөр нэмж авч байгаа, мөн аж ахуйн нэгж дээр цахилгааны төлбөрийг чадлын тарифаар бодож авч байгааг эсэргүүцсэн гомдол ирүүлсэн байна. Мөн цахилгаан түгээх сүлжээний хэрэглэгчдээс цахилгааны төлбөр, тасралт, таслалтын талаар гаргаж ирүүлсэн гомдол дийлэнх хувийг эзэлж байна.

Яамны цахим хуудасны тасралтгүй найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Газар хэлтсүүдээс ирүүлсэн мэдээ мэдээллүүдийг яамны цахим хуудасны холбогдох булангуудад байршуулж байна. Үүнд яамны тухай буланд – 10, шилэн данс буланд – 52, тусгай зөвшөөрөл буланд -8, мэдээ мэдээлэл буланд -27, ил тод байдал буланд - 35, хууль тогтоомж буланд - 22, төсөл хөтөлбөр, хэлэлцүүлэг, статистик буланд -12 нийт 166 мэдээ мэдээллийг байршуулсан байна. Яамны цахим хуудасны хэвийн найдвартай ажиллагааг тухай бүр ханган ажиллаж байна. МТШХХГ-аас “Шилэн дансны тухай” хууль, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль болон “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS6285:2011 стандарт” зэрэг цахим хуудсанд тавигдах шаардлагын хэрэгжилтэд шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 87 оноо

авахаас манай яамны цахим хуудас 72 оноо авч 16 яамны цахим хуудаснаас 2 дугаар байранд орсон. Яамны цахим хуудсанд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу 4 дэд цэс бүхий “Ил тод байдал” гэсэн үндсэн цэс байршуулж холбогдох мэдээ мэдээллүүдийг газар хэлтсүүдээс авч байршуулсан.

Яамны ажилтнуудын компьютер, техник хэрэгслийн гэмтлийг засварлах, ашиглалтын талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа байнга үзүүлэн ажиллаж байна. 7 хоногт ойролцоогоор 25-30 дуудлага барагдуулан ажиллаж байна.

Яамны домайн хаяг, цахим шуудан байршиж буй хостын хэмжээ дүүрсэнтэй холбогдуулан хостын хэмжээг нэмэгдүүлэхээр Үндэсний дата төвд албан бичиг хүргүүлж хостын хэмжээг 40Gb болгон нэмэгдүүлж авсан.

Яамны компьютеруудад суулгасан вирусийн эсрэг програм хангамжийн лицензийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан лицензийг сунгуулан авахаар Совтлайн-Амар ХХК-тай гэрээ байгуулан програм хангамжийн лицензийг худалдан авсан. Яамны бүх компьютеруудад лицензийг сунгаж хэвийн ажиллагаанд оруулсан.

Яамны бүх ажилтан албан хаагчдад яамны energy.gov.mn-тэй домайн хаяг бүхий электрон шууданг нээж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Одоогоор нийт 96 цахим шуудангийн хаяг ашиглагдаж байна. Мөн ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын цахим хаягуудыг хаасан.

Яамны бүх ажилтан албан хаагчдыг хурууны хээгээр цаг бүртгэдэг системд оруулан цаг бүртгэлийн бүртгэлийг явуулж байна. Шинээр ажилд орсон ажилтнуудын хурууны хээг тухай бүр цаг бүртгэлийн системд оруулж байна. Мөн сар бүр цаг бүртгэлийн системээс тайланг гаргаж газрын дарга нарт хүргүүлэн ажилласан.

Яамны компьютер техник тоног төхөөрөмжүүдийн ажлын шаардлага хангахгүй байгаа болон шинээр ажилд орсон албан хаагчдад шаардлагатай байсан нийт 5 компьютер, 2 принтерийг яамны удирдлагуудад танилцуулж шийдвэрлүүлсэн.

Интернет болон дотоод сүлжээ, төрийн холбоо, IPTv чиглэлээр

Яамны компьютеруудын дотоод болон интернетийн сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Тасралт гарсан тухай бүр гэмтлийг засварлан шаардлагатай тохиолдолд сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажлуудыг хийж байна. Мөн серверийн өрөөний тоног төхөөрөмжүүд, сервер компьютеруудын болон хөргөлтийн систем, нэвтрэх систем, дохиоллын систем зэргийнхэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хийдэг “Хариуцлага, хяналт, хэрэгжилт” сэдэвт видео хурлын үеийн техникийн болон сүлжээний бэлэн байдлыг хангаж ажилласан. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3 удаа хуралдсан.

Төрийн холбооны утасны хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд утас шинээр суурилуулах, гэмтэлтэй хэсгийг засварлах ажлыг тухай бүр хийж гүйцэтгэж байна. Төрийн холбооны утсанд ярианы хязгаарлалт тогтоолгох тухай албан тоотыг Кибер аюулгүй байдлын газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулж ярианы кодыг шинэчлэн тараасан. Мөн Эрчим хүчний салбарын

утасны жагсаалт бүхий ном ДҮТ ХХК-аас хэвлэгдэн гарах гэж байгаатай холбогдуулан өөрийн яамны утасны жагсаалтуудыг шинэчлэн гаргаж файл хэлбэрээр хүргүүлсэн. Эрчим хүчний яамны бүтэц бүрэлдэхүүн өөрчлөн байгуулагдсан дагуу өрөөнүүдийн утасны сүлжээнд өөрчлөлт хийж, утасны жагсаалтуудыг шинэчлэн гаргаж бүх өрөөнүүдэд хувилж тараасан.

IPTV телевизийн сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна. Одоогоор тус яаманд нийт 10 IPTV ашиглагдаж байна.

Яамны албан хаагчдийн дунд мэдээлэл солилцох, файл дамжуулах зорилгоор зөвхөн яамны компьютеруудын дотоод сүлжээнд ажиллах spark messenger програмыг бүх компьютеруудад суулгаж яамны бүх албан хаагчид дотоод мэссэнжирээр холбогдон файл дамжуулах, мэдээ мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн.

Хяналтын камерын системийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Гадна талбайг харж байсан 2 камерын тог бууруулагч шатаж ажиллагаагүй болсныг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн сайдын туслахын өрөөний камерын бичигч төхөөрөмжийн хатуу дискийг сольж засварласан.

Яамны ажилтан албан хаагчдын өрөө солигдон сууж байгаатай холбогдуулан төрийн холбооны болон яамны дотоод гадаад сүлжээний холболтуудыг хийж хэвийн ажиллагаанд оруулж байна.

Яамны хурлын танхимийн чанга яригчийн систем аппаратур, техник тоног төхөөрөмж тасралтгүй найдвартай үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Хурлын зааланд шинээр 2 утасгүй микрофон нэмж холбон тохируулга хийж ажилд оруулсан. Хурлын заалны чанга яригчийн системийг шинэчлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг “Тотал музик” ХХК, “Глобал электроникс” ХХК-ны инженерүүдтэй уулзалт хийж холбогдох төхөөрөмжүүдийн төсвийг гаргуулан авч ЭХХТ-д хүргүүлсэн.

Хэвлэл мэдээллийн чиглэлээр

АСЕМ-ын Сэргээгдэх эрчим хүчний хурлын үеэр яамны бүх удирдлагуудаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага өгүүлсэн.

ЭХЯ-ны www.energy.gov.mn. Засгийн газрын www.zasag.mn веб сайтын админ хийж, тогтмол шинэ мэдээллээр хангаж 120 орчим фото мэдээлэл, 40 гаруй видео мэдээлэл байршуулсан.

Төвийн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний системийн эх үүсвэрийн дутагдлыг арилгах, эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор Улаанбаатар дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар тус тус нэмэгдүүлэх төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, “Эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 57 дугаар тогтоол гарсан.

Мөн Эрчим хүчний нүүрс олборлогч Багануур, Шивээ-Овоогийн уурхайн найдвартай ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, цаашид авах арга хэмжээний тухай Засгийн газрын

338 дугаар тогтоол гарсан. Эдгээр тогтоол шийдвэртэй холбоотой мэдээллийг ТВ, сонин, сайтын сувгаар олон нийтэд мэдээлэв. Түүнчлэн Засгийн газраас Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг баталсантай холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ тухай мэдээллийг цацсан.

Эрчим хүчний сайдын 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 11 тоот тушаалаар Нийслэлийн гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл, өрхийн цахилгаан хангамжийн дэд бүтцийг бий болгох тушаал гарч, 1562 өрх айлыг цахилгаан эрчим хүчинд холбосон. Энэ тухай мэдээллийг олон нийтэд хүргэв.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгааны шөнийн бага ачааллыг нэмэгдүүлэх зорилгоор тус сүлжээнд холбогдсон хоёр тарифт тоолууртай гэр хорооллын айл өрхөд борлуулах эрчим хүчний үнийн 50 хувийн хөнгөлөлтийг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож байна. Энэ тогтоолтой холбоотой мэдээллийг олон нийтэд хүргэв.

Эрчим хүчний сайд П.Ганхүү БНХАУ-ын Эрчим хүчний салбарынхантай уулзаж, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар Бээжин хотноо уулзалт зохион байгуулсан. Мөн бизнес эрхлэгч болон эрдэмтдийн багтай уулзсан талаарх мэдээллийг цацсан болно. Мөн ЭХЯ-ны 7 хоногийн шуурхай болон өвөлжилттэй холбоотой мэдээллийг цаг тутам төвийн хэвлэлээр цацаж, олон нийтэд хүргэв.

Иргэдэд үйлчилдэг байгууллага, албан тушаалтан, ажилтны овог нэр, хариуцсан ажлын чиг үүрэг /тусгай зөвшөөрөл, лиценз, тэтгэвэр, халамж, татвар/ ажиллах цаг, уг ажилтай холбоотой хууль тогтоомж, журам дүрмийн талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй яамны цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байрлуулан ажиллаж байна.

Эрчим хүчний салбарт 3-4 томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ” ярилцлага, Засгийн газрын 100 хоногт ЭХЯ-наас хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл болон “Эрчим хүч” сэтгүүлийн мэдээ мэдээлэл, Сайдын зурвас үг зэргийг бэлтгэн ТВ, сонин, сайтын сувгаар олон нийтэд мэдээлэв.

Салбарын үйл ажиллагааг сурталчлах хэвлэл мэдээллийн ажилтнуудын нэрс хаягийг эмхэтгэн файл үүсгэн харилцаж байна.

Яамны удирдлагуудын хэвлэлд өгөх ярилцлагын асуултыг боловсруулах, хэлэх үгийн эхийг боловсруулах, хэвлэлд гаргах ярилцлага, хэлсэн үгийг олон нийтэд түгээх ажлыг тухай бүр зохион байгуулсан. Яамны веб сайт, Засгийн газрын веб сайтуудад холбогдох мэдээ мэдээллийг тогтмол тавьж байгаа бөгөөд яамны мэдээллийн 3 самбарыг тогтмол шинэчилж байна.

Бичиг хэргийн чиглэлээр

Эрчим хүчний яамны хэмжээнд төрийн дээд байгууллага болон үйлдвэр, ААН, компаниудаас ирсэн **5609**, шагналын **276**, тусгай зөвшөөрлийн **215** албан бичиг, явуулсан албан бичиг **3201**, гадаадад **192**, шуудангаар **4567**, факсаар **110** хуудсыг **1600** газарт /давхардсан тоогоор/, сайдын тушаал **213**, төрийн нарийн бичгийн даргын тушаал **337**, өргөдөл, гомдол, санал хүсэлт **272** ирсэн байна.

Гадаадын болон дотоодын байгууллагуудаас ирсэн бичиг болон өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цаг хугацаанд нь бүртгэн удирдлагаас өгсөн заалт, чиглэл болон өгсөн үүрэг даалгаврыг Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, хүсэлтийн хайлтын программд бүртгэн шивж оруулах, хариутай албан бичгүүдийг хяналтад авч хугацааг тавин холбогдох газар, хэлтсийн хариуцсан мэргэжилтнүүдэд гарын үсгээр хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг хийлээ. **98** хүнд **782** хуудас материалыг хуулбар үнэн дардасыг холбогдох материалыг үндэслэн баталгаажуулав. Яамны байгууллагын архивт нийт **5535** гаруй хадгаламжийн нэгж стандартын дагуу хадгалагдан ажлын хэрэгцээнд ашиглагдаж байгаа бөгөөд ажилтан, албан хаагчдад ажлын шугамаар **1115** хуудас албан бичиг, тушаал хуулбарлан олгосон. Мөн яамны мэргэжилтнүүд, архив, бичиг хэргийн ажилтнуудад өдөр тутам мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан. 2015 он, 2016 оны эхний хагас жилийн баримт бичгийг бүртгэлээр хүлээн авч **658** боть хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт татан авалт хийлээ.

Өдөр бүр хариу өгөгдсөн өргөдөл, хүсэлт, хариутай бичгийн хяналтын картыг бүртгэлийн программ дээр нэг бүрчлэн хааж, газар, хэлтсийн бичиг хэрэг хариуцсан мэргэжилтнүүдэд мэдээлж удирдлагад танилцуулж, тайлан мэдээг 14 хоног, сар, улирал, эхний хагас жилээр гаргаж өгч хаалт хийсэн байна. /сүлжээ болон хуудсаар/

Нууц **35** ш албан бичгийг яамны удирдлага болон нууц хариуцсан ажилтанд танилцуулан төслийг хэвлэмэл хуудсан дээр гарган баталгаажуулан ГХЯ, ТЕГ-т биечлэн хүргэсэн. Мөн яамны хэвлэмэл хуудас /А4-4000, А5-3000ш, Сайд, ТНБД-ын тушаал-1500ш/, яамны дугуй /А4-2000, А5-3000ш/ захиалан ажлын хэрэгцээнд ашиглаж байна. 2016 оны I, II, III, IV улирлын хэвлэл захиалгын төсөв батлуулах, нэгтгэн захиалах ажлыг гүйцэтгэлээ.

Гадны байгууллагуудаас болон яамны удирдлага, мэргэжилтнүүдээс утсаар болон биечлэн лавласан албан бичгийн явцын тухай мэдээллийг шүүж хаана, хэнд танилцагдаж байгаа болон холбогдох газар, хэлтэс, мэргэжилтний талаарх мэдээллийг шуурхай хүргэн ажилласан.

Тус яамны харьяа татан буугдсан үйлдвэр, ААН, газарт ажиллаж байсан 13 хүнд Хөдөлмөрийн дэвтэр, НДД-ийг нь үндэслэн тодорхойлолт гаргах, мөн яамны архивт хадгалагдаж байгаа 1980-2009 оны цалингийн цэсийг үндэслэн цалингийн тодорхойлолт гарган өгсөн.

Хоёр. Хууль, эрх зүйн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил:

Улсын Их Хурал, Засгийн газарт оруулах хууль, тогтоолын төсөл, бусад асуудалд сайдаас өгөх саналын төслийг боловсруулахад яамны газруудад тухай бүр мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллав.

Тайлант хугацаанд нийт 530 албан бичиг боловсруулж, хүргүүлснээс Улсын Их Хурал, Засгийн газарт оруулах, хууль, тогтоолын төсөл, бусад асуудалд сайдаас өгөх 388 саналыг боловсруулж, хүргүүлэв.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийг дагаж гарах Эрчим хүчний аудит хийх журам, эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага тэдгээрийг магадлан итгэмжлэх журам, эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах журам, Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг

хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө, тайлагнах журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийн ажлын хэсэгт ажилласан. Дээрх тогтоол Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан.

Захиргааны хэм хэмжээний актын сан бүрдүүлэх зорилгоор салбарт мөрдөгдөж байгаа нийт 19 захиргааны хэм хэмжээний актын 12-ыг нь яамны газруудаас гаргуулан авч яамны архивын нэгж болгон хүлээлгэн өгөв. Үлдсэн актуудыг Хууль зүй, дотоод хэргийн яамны архиваас гаргуулахаар албан бичгийг хүргүүлсний дагуу тус яамнаас хуулбарлан авсан.

Түүнчлэн бүртгэлтэй эдгээр 19 актыг хянан үзэж, дор дурдсан саналыг мөн яаманд хүргүүлсэн. Үүнд:

1. Түлш, эрчим хүчний сайдын 2005 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” /Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журам/ 29 дүгээр тушаал нь Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг байгуулах, түүний гишүүнийг томилох журам”-ыг Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоох болсонтой холбогдуулан Эрчим хүчний сайдын 2016 оны 33 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцсон. Үүнтэй холбогдуулан түүнийг улсын нэгдсэн бүртгэлээс хасах.

2. Түлш, эрчим хүчний сайдын 2004 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” /Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, шагнуулах хүний тодорхойлолтын загварыг хоёрдугаар хавсралтаар/ 24 дүгээр тушаал нь захиргааны хэм хэмжээний актад хамаарахгүй тул улсын нэгдсэн бүртгэлээс хасах.

3. Үйлдвэр, худалдааны сайдын 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 122 дугаар тушаалаар баталсан “Геологи, эрдэс баялгийн судалгааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх галын аюулгүй нэгдсэн дүрэм” нь эрчим хүчний салбарын үйл ажиллагаанд хамаарахгүй тул жагсаалтаас хасах.

Дээрх албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд тус салбарт Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний 16 акт мөрдөгдөж байна.

Сайдаас 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах Хамтран ажиллах гэрээний төсөлд яамны газрууд болон холбогдох аймаг, нийслэлийн саналыг авч, гэрээний төслийг эцэслэн боловсруулж, гэрээг байгуулав.

Аймаг, нийслэлийн Засаг даргатай 2016 онд байгуулсан гэрээний биелэлтийг аймаг, нийслэлээс гаргуулж авсан. Биелэлтийг нэгтгэж байна.

Яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөлд яамны газруудын саналуудыг тусган нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор батлуулав.

Уг тогтоолын хүрээнд яамны газруудын үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг нэгтгэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулав.

Тайлант хугацаанд сайдын 216, төрийн нарийн бичгийн даргын 339 тушаал батлагдан гарсан бөгөөд тухай бүр эрх зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлж ажиллав.

Яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 63 дугаар тушаалаар Эрчим хүчний яамны албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн баталж, уг журмын талаар болон яамны хэмжээнд нийтлэг мөрдөгддөг хууль тогтоомж, дүрэм, журмын талаар 10 дугаар сарын 14-нд нийт албан хаагчдад мэдээллийн цагийг зохион байгуулав.

Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 142 дугаар тушаалаар Эрчим хүчний яамны хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлав.

Түүнчлэн Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, батлуулав. Журмуудын хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллаж байна.

“Пума” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татсан иргэний хэрэгт Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ЭХЯ-ны ТЗУГ-ын хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Л.Мөнхжаргал, СБТГ-ын ахлах мэргэжилтэн Ё.Энхтуяа нарыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2015.12.24-ны өдрийн 261 дүгээр захирамжаар томилсон. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.03.10-ны өдрийн 101/ШШ2016/02239 дугаар шийдвэрээр нэхэмжлэгч “Пума” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан “Пума” ХХК-ийн нэхэмжлэлтэй дээрх иргэний хэргийг хэлэлцэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлүүлэв.

“Бадамлах Дөл” ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭХЯ-ны БХЗГ-ын даргад холбогдох хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орж ажиллав. Нийслэлийн захирааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.04.04-ний өдрийн 2777 дугаар захирамж, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.04.27-ны өдрийн 270 дугаар тогтоолоор нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд “Меговатт” ХХК-аас тус яаманд холбогдуулан “Гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийн үлдэгдэл болон баталгааны 255900 евроны хамт нийт 886970 еврог улсын тэмдэгтийн хураамж 9.952.405 төгрөгийн хамт гаргуулах тухай” шаардлага бүхий нэхэмжлэлийг хянан хэлэлцсэн шүүх хурал 09 дүгээр сарын 20-ны өдөр тус шүүхэд болсноос нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгуулж шийдвэрлүүлсэн.

Уг захирамжид нэхэмжлэгч талаас гомдол гаргасан бөгөөд гомдлыг хянан хэлэлцэх шүүх хурал 10 дугаар сарын 18-нд болсноос нэхэмжлэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгуулж, өмнөх шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн шийдвэр гаргуулав.

Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн С.Отгонбаярын нэхэмжлэлтэй хэрэгт Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, анхан шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгуулж шийдвэрлүүлэв.

Нийслэлийн ХУД-ийн иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэгч Я.Пүрэвжавын холбогдолтой иргэний хэрэгт оролцож байна.

Иргэн Ж.Мөнхбаатарын гаргасан захиргааны хэргийн гомдолд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна.

Яамны дэргэдэх Ёс зүйн хорооны ажлын 2016 оны төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав.

Мөн яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулав. Төлөвлөгөөний хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга Б.Баатарсайханыг урьж, төрийн албан хаагчийн мөрдөх ёс зүйн хэмжээний талаарх сургалтыг 2016 оны 11 дүгээр сарын 29-нд яамны нийт албан хаагчдыг оролцуулан зохион байгуулав. Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхээр бэлтгэж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны даргын 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 10 дугаар тушаалын дагуу эрчим хүчний салбарын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийг гаргуулан авах, зөвлөгөө, чиглэл өгөх зорилго бүхий ажлын хэсгээс салбарын байгууллагад ажиллах хуваарь, ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 93 дугаар тушаалын төслийг боловсруулж, батлуулан, хавсралтад нэр заагдсан нийт 19 байгууллагад ажлын хэсгийн талаар болон тушаалын талаар утсаар мэдэгдэн танилцуулж, холбогдох материалыг байгууллага бүрд факсаар хүргүүлэв.

2016 оны 01 дүгээр сард Авилгын эсрэг хуульд заасны дагуу ХАСХОМ-ийг хэрхэн бөглөх талаар АТГ-ын комиссар Б.Эрдэнэцэцгийг урьж яамны албан хаагчдад сургалт зохион байгуулав.

Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдуулан 04 дүгээр сарын 04-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар удирдуулсан хурлыг зохион байгуулж, тэмдэглэлийг хөтлөн баталгаажуулсан. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдуулан тухайн ажиллах байгууллагад тухай бүр мэдээллийг өгч ажиллав. Тус байгууллагаас дээрх хуваарийн дагуу ажиллаад ирүүлсэн авах арга хэмжээний саналыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг яамны газруудын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан боловсруулж, саналыг авч, танилцуулга бэлтгэн 05 дугаар сарын 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нарт танилцуулсан. Гаргасан саналыг тусгаж сайдын 05 дугаар сарын 16-ны өдрийн 79 дүгээр тушаалаар батлуулав. Мөн төлөвлөх боломжгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээний тайлбарыг газруудаас ирүүлсний дагуу нэгтгэн боловсруулж, түүнийг төлөвлөгөөний хамт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. Төлөвлөгөөний явцын тайланг 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар холбогдох газар, байгууллагуудаас авч нэгтгэн боловсруулж, тус газраас зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд танилцуулга бэлтгэж, хуралд оролцов. Түүнчлэн тайланг 06 дугаар сарын 20-ны байдлаар дахин нэгтгэн гаргаж, хүргүүлэв.

Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны даргын 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн заалтын биелэлтийг нэг бүрчлэн гаргаж, хүргүүлэв.

Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгуулагдсан хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой журам, зааврын төсөл боловсруулж, батлуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн 06 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралд сууж, холбогдох саналыг танилцуулсан.

Түүнчлэн энэ хүрээнд Хууль сахиулах ажиллагаанд тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх зааврын төслийн эхний хувилбарт санал боловсруулж, цахимаар хүргүүлэв.

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөл байгуулж, ажиллах журмыг баталсантай холбогдуулан тус яаманд салбар зөвлөлийг байгуулахаар Монгол Улсын шинжлэх ухааны академи, Эрчим хүчний сургууль, яамны холбогдох газраас төлөөллийн нэрийг авч, сайдын тушаалаар батлуулав.

Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсантай холбогдуулан тушаал, гишүүдийн мэдээллийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлд хүргүүлэв. Уг салбарын зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллахаар томилогдов.

Ажлын хэсгийн хүрээнд тус байгууллагаас ирүүлсэн албан бичгийн хариуг тухай бүр өгч ажиллав.

Захиргааны ерөнхий хууль шинээр батлагдаж 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөхтэй холбогдуулан тус хуулиар яам болон Эрчим хүчний хөгжлийн төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Диспетчерийн үндэсний төвийн нийт 50 гаруй албан хаагчдыг оролцуулав. Хичээлийг Хууль зүйн яамнаас 2 албан хаагч ирж заав.

Сайд, төрийн нарийн бичгийн даргын 2016 оны тушаалын биелэлтийг эхний хагас жилийн байдлаар газруудаас биелэлтийг авч нэгтгэн боловсруулж, яамны удирдлагад танилцуулав.

Төрийн захиргааны удирдлагын газрын 2016 оны төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, ХШҮДАГ-т хүргүүлэв.

Газрын албан хаагчдын гэрээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн авч удирдлагад хүргүүлэв.

Яамны шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулах хүрээнд салбарын 2016 оны шилдгийг шалгаруулах үйл ажиллагааг болон шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулав.

Гурав.Санхүүгийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил:

Эрчим хүчний сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах, улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан зохицуулахад бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хянан санхүүжүүлэх, яамны өдөр тутмын санхүүгийн гүйлгээг хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Эрчим хүчний сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийг боловсруулах, тэдгээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр ажиллалаа.

1. Сайдын багцын төсвийн төлөвлөлтийн талаар

1.1 2016 оны төсвийн тухай:

“Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль”-иар Эрчим хүчний сайдын багцыг **107.3** тэрбум төгрөгөөр баталсан бол төсвийн тодотголд тусгуулах саналаа боловсруулан Сангийн яаманд хүргүүлж 2016 оны 9 дүгээр сарын 9-нд батлагдсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-иар **126,7** тэрбум төгрөг болсон. Үүнд:

/тэрбум.төг/

№	Зардлын төрөл	2016 он	
		Батлагдсан	Тодотгол (9 сарын 9)
	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	107,326.4	157,818.0
1	Урсгал зардал	11,900.8	19,934.6
2	Хөрөнгийн зардал	69,823.3	121,076.0
	1. Улсын төсвөөр санхүүжих	29,850.7	3,935.8

	2. Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжих	39,972.6	36,409.5
	3. Векселиэр санхүүжих	-	80,730.7
3	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	25,602.4	16,807.4

Эрчим хүчний сайдын багцын урсгал зардал нь эрчим хүчний яамны зардал, тус салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр төслийн нэгжийн урсгал зардал, эрчим хүчний үйлдвэрүүдэд олгож буй алдагдлын татаас зэргээс бүрдэж байна.

/сая төгрөг/

№	Урсгал зардал	2016 онд Батлагдсан	2016 онд тодотгосон	Зардалд эзлэх хувь
	НИЙТ	11,900.8	19,934.6	100%
1	Эрчим хүчний яам	1,480.6	1,566.2	8%
2	Хөтөлбөр, төслийн дотоод зардал	1,570.3	1,518.4	7%
3	Татаас	8,850.0	16,850.0	85 %

“Монгол улсын 2016 оны төсвийн тухай” болон “Монгол улсын 2016 оны төсвийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиуд батлагдсантай холбогдуулан холбогдох журам, зааврын дагуу Эрчим хүчний сайдын багцын төсвийн багцын зарлагын сар, улирлын дэлгэрэнгүй хуваарийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 371 тоот тушаал, 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 319 дугаар тушаалуудад оруулж батлуулан хуваарийн дагуу санхүүжилтийг хийж ажилласан.

Төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Сайдын 2015 оны төсвийн багцын гүйцэтгэл, Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль, Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, өргө хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, өмнөх онуудын гүйцэтгэл, салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний хүрэх түвшингийн талаар үйлдвэр, компаниудаас ирүүлсэн зарим санал, тооцоо зэргийг харгалзан үзэж боловсруулан хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа Эрчим хүчний сайдын багцыг

2017 онд 724,5 тэрбум төгрөгөөр,

2018 онд 963,6 тэрбум төгрөгөөр,

2019 онд 805,2 тэрбум төгрөгөөр төсөвлөн Сангийн яаманд хүргүүлэн Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлсэн бөгөөд үүнтэй холбогдсон бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. Сайдын төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг

боловсруулахдаа төсвийн байгууллагын зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өсөхөд нөлөөлж байгаа дотоод, гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан үзэж, хэмнэлтийг аль болох урамшуулах, салбарт менежментийн шинэ хандлага, арга барил нэвтрүүлэх, ингэснээр үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлийг баримталсан болно.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан тухайн салбарт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын хэмжээг гаргаж Засгийн газрын 2016 оны 346 дугаар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хязгаарыг батлах тухай” тогтоолд эрчим хүчний сайдын багцын хязгаарыг хөрөнгө оруулалтад 48,3 тэрбум төгрөг, урсгал зардлыг 19,9 тэрбум төгрөгөөр тусгасан.

1.2 2017 оны төсвийн тухай:

Монгол Улсын төсвийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 346 дугаар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хязгаарыг батлах тухай” тогтоол, тэдгээртэй холбогдон гарсан журам, зааврыг баримтлан 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсөөллийг боловсруулан хуулийн хугацаанд 2016-08-12 өдрийн а/2104 тоотор Сангийн яаманд хүргүүлсэн болно. 2017 оны төсвийн төслөө Сангийн яам, Засгийн газар, УИХ-ын байнгын хороодоор хэлэлцүүлэхэд хамгаалаж “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль” УИХ-аар хэлэлцэгдэн 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль 2016 оны 11 дүгээр сарын 10 өдөр батлагдсан бөгөөд Эрчим хүчний сайдын 2017 оны төсвийг 111,439.7 сая төгрөгөөр батласан. Үүнд:

№	Зардлын төрөл	2017 он
	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	111,439.7
1	Урсгал зардал	19,854.6
2	Хөрөнгийн зардал	16,909.8
	2.1 Улсын төсвөөр санхүүжих	16,909.8
	2.2 Векселиэр санхүүжих	-
3	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	74,675.4
4.	Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалт	16,583.8

Эрчим хүчний сайдын урсгал зардал нь Эрчим хүчний яамны урсгал зардал, Эрчим хүчний үйлдвэрүүдэд олгох татаас, Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлаас бүтдэг.

№	Урсгал зардал	2017 онд батлагдсан
	НИЙТ	19,854.6
1	Эрчим хүчний яамны дотоод урсгал зардал	1,519.5
2	Төсөл, хөтөлбөрийн дотоод урсгал зардал	1,185.1
3	Татаас	17,150.0

Хөрөнгө оруулалтын зардалд 2017 онд шилжиж буй хөрөнгө оруулалтад 3 төсөл, арга хэмжээнд 11,909.8 сая төгрөг, Шинээр эхлэх 1 их засварт 5,000.0 сая төгрөг тусгагдсан.

1. Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл (төсөвт өртөг 23,7 тэрбум төгрөг, 2017 онд санхүүжигдэх 7,4 тэрбум төгрөг)
2. Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4-35 кВ-ын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын үргэлжлэл (төсөвт өртөг 17,0 тэрбум төгрөг, 2017 онд санхүүжигдэх 1,1 тэрбум төгрөг)
3. ХБНГУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн Монголын талын хөрөнгө (төсөвт өртөг 10,6 тэрбум төгрөг, 2017 онд санхүүжигдэх 3,5 тэрбум төгрөг)
4. Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл (төсөвт өртөг 6,3 тэрбум төгрөг, 2017 онд санхүүжигдэх 5,0 тэрбум төгрөг) уг ажлын хүрээнд хамгийн хүндрэлтэй байгаа “8д магистраль Тк-844-өөс Тк-860 хүртэл 2ф500мм-ийн голчтой суваггүй 3528м шугамыг 2ф600мм болгон өргөтгөх” ажил хийгдэнэ.

Төсвийн хуулийн 4 дүгээр хавсралтын “Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2017 онд санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ажил”-д тус салбарт хэрэгжиж буй болон хэрэгжээд дууссан 26 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 15,582.8 сая төгрөгийн санхүүжилт тусгагдсан байна.

2. Санхүүгийн нэгдсэн тайлан, бүртгэлийн талаар:

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 54 дүгээр зүйл, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан журам, маягтын дагуу эрхлэх асуудлынхаа хүрээний төсөвт байгууллага 1, төрийн өмчит компани, улсын үйлдвэрийн газар, хороо 25, төсөл хэрэгжүүлэгч нэгж, судалгааны багийн 15, нийт 41 санхүүгийн тайланг нэгтгэж, Сайдын багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн в/1008 тоотойр УАГ-т, 2016 оны 04 дүгээр сарын 22-ны в/1227 тоот албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлэн, Засгийн газрын тайланд нэгтгүүлсэн.

Төсвийн шууд захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тайлбар, тодруулгын хамт гаргаж, удирдлагад танилцуулан, баталгаажуулж, Үндэсний аудитын газарт 2016

Сар бүрийн 5-ны дотор нийгмийн даатгалын тайланг ndaatgal.mn сайтад цахим хэлбэрээр шивж, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулж ирлээ. 2016 онд нийгмийн даатгал шимтгэлд 402,4 сая төгрөг шилжүүлэн м⁰í àæèë-äüí /135 õ¿í/ íééäíèéí àààðàäèÛñ äýâðýðð ÿõíèé 11 ñàðüí àè-èèðèéä õèéæ ÍÄ-í ààéòàää-ààð ààðàèääàæóóèñáí.

2016 оны Төсвийн шууд захирагчийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай” хуулийн дагуу сар бүрийн 02-ны дотор тогтмол гаргаж баталгаажуулж ирлээ.

Худалдан авсан эд хөрөнгө, бараа материал шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлогод хүлээн авч картлан бүртгэн хөтөлж, холбогдох эзэмшигч бүрт хөрөнгийн картыг нээн бүртгэж, гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажилласан.

Санхүүгийн тайлангийн хугацаанд бэлэн мөнгөний гүйлгээг зохих журмын дагуу 1 ба 2 дугаар гарын үсгийн зөвшөөрлөөр Төрийн сангаас бэлэн мөнгөний зарлагын гүйлгээг хийж “Жижиг мөнгөн сан”-д орлого төвлөрүүлэх, гүйлгээг зохих журмын дагуу олгож бэлэн мөнгөний кассын орлого, зарлагын тайланг тогтоосон хугацаандаа гарган удирдлагуудад /нягтлан бодогч/ танилцуулан хянуулан тайлан тооцоог хийн ажиллаж байна.

Бэлэн мөнгөний үлдэгдлийг сар бүрийн эцэст хянаж бэлэн мөнгөний тооллогын акт үйлдэн баталгаажуулж ажилласан бөгөөд ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй болно.

3. Хөрөнгө оруулалт, урсгал зардлын санхүүжилт, төрийн сангийн үйл ажиллагааны талаар:

3.1 Хөрөнгө оруулалтын талаар:

“2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар эрчим хүчний сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 8 төсөл арга хэмжээнд 3935.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас ХБГ-ээр 3675.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй. Үүний 7 төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгсөн.

Улсын төсөв

/сая. төгрөг/

Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	Төлөвлөгөө	ХБГ	Биелэлт %
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	3,935.8	3,675.0	93.4
Цахилгаан дамжуулах шугам, дэд станцууд	1,935.8	1,675.0	86.5
Гадаадын зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр	2,000.0	2000.0	100.0

Хөгжлийн банкны эх үүсвэрээр 22 төсөл, арга хэмжээг 33.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсанаас ХБГ-ээр 32.5 тэрбум төгрөг буюу 97.4 хувийн санхүүжилт олгосон.

Хөгжлийн банк

/сая.төгрөг/

1.2 Ажил олгогчоос төлөх НДШимтгэл	115.22	115.22	115.22	-	100%
Тэтгэврийн даатгал	73.31	73.31	73.31	-	100%
Тэтгэмжийн даатгал	8.38	8.38	8.38	-	100%
Ажилгүйдлийн даатгал	2.09	2.09	2.09	-	100%
ҮОМШ өвчний даатгал	10.48	10.48	10.48	-	100%
ЭМД –байгууллага төлөх	20.96	20.96	20.96	-	100%
1.3 Тогтмол зардал	82.34	82.34	73.21	9.13	89%
Гэрэл, цахилгаан	41.51	41.51	46.28	-4.78	112%
Түлш, халаалт	34.53	34.53	21.26	13.27	70%
Цэвэр, бохир ус	6.30	6.30	5.66	0.63	95%
1.4 Хангамж, бараа материалын зардал	47.78	47.78	47.58	0.20	100%
Бичиг хэрэг	13.47	13.47	13.49	-0.02	100%
Тээвэр (шатахуун)	8.24	8.24	8.24	-	100%
Шуудан, холбоо	18.26	18.26	18.07	0.19	100%
Хог тээвэр, үйлчилгээ	1.62	1.62	1.62	-	100%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	6.18	6.18	6.15	0.03	100%
1.5 Эд хогшил, нормын хувцас	28.34	22.74	22.63	0.11	98%
Урсгал засвар	24.33	18.73	18.73	-	100%
Нормын хувцас, зөө/эдлэл	2.81	2.81	2.70	0.11	96%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1.20	1.20	1.20	-	100%
1.6 Томилолт зочны зардал	35.94	35.94	31.65	4.28	88%
Дотоод албан томилолт	35.94	35.94	31.65	4.28	88%

1.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр хураамж	105.9	95.90	88.81	7.09	90%
Газрын төлбөр	1.72	1.72	-	1.72	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх	10.00	10.00	8.88	1.12	68%
Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээ	10.00	10.00	9.60	0.40	96%
Зөвлөл, хороо комиссын гишүүдийн хөлс	10.00	7.19	4.73	2.46	66%
Эрдэм, шинжилгээ, судалгааны ажил	51.90	51.90	50.90	1.00	98%
Мэдээлэл технологийн үйлчилгээ	10.33	10.33	9.93	0.40	96%
Тээврийн хэрэгслийн татвар	4.76	4.76	4.76	-	100%
1.8 Бусад бараа үйлчилгээний зардал	1,400.93	1,167.91	1,153.85	14.06	98%
Сургалт семинарын зардал	1.41	0.70	0.56	0.14	80%
Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	8.85	-	-	-	-
Биеийн тамирын уралдаан тэмцээн	3.12	3.12	3.12	-	100%
Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал	1,387.55	1,164.09	1,150.17	13.92	98%
1.9 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	159.50	144.74	141.52	3.22	98%
1 удаагийн тэтгэмж, шагнал	38.00	29.00	27.70	1.30	96%
Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн хүмүүсийн тэтгэмж	23.05	17.29	15.37	1.92	89%

Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн тэтгэмж	98.45	98.45	98.45	-	100%
1.10 Засгийн газрын гадаад шилжүүлэг	4.00	4.00	3.11	0.89	78%
Олон улсын байгууллагын гишүүний татвар	4.00	4.00	3.11	0.89	78%

Эрчим хүчний сайдын багцын урсгал зардлын 80 гаруй хувийг эзэлдэг Дизель станц бүхий Говь-Алтай, Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэр, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний системд холбогдоогүй сумд, “ББЭХС” ТӨХК, АУЭХС ТӨХК, Даланзадгадын дулааны цахилгаан станц, Налайх, Багануурын дулааны станц болон Төрийн өмчит эрчим хүчний компаниудад “2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар эрчим хүчний алдагдлын татаасын санхүүжилтэд 16850.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 100 санхүүжилтийг олгож ажилласан.

/сая төгрөг/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	ХБГ	Биелэлт %
НИЙТ ТАТААС	16,850.0	16,850.0	100.0
Дизелийн станцын алдагдлын татаас	2,150.0	2,150.0	100.0
Цахилгаан дамжуулах системийн алдагдлын татаас	9,600.0	9,600.0	100.0
Дулааны станцын алдагдлын татаас	5,100.0	5,100.0	100.0

3.3 Төрийн сангийн талаар:

Төсвийн тухай хууль, ЗГ-ын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаал, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/а-9 тушаалаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанкинд нээх, хаах журам”, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаал баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”, “Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” зэрэг заавар журмыг мөрдөж ажилласан.

Сар бүр төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, Сайдын багцад хамаарагдах дансдууд болон төсөл хөтөлбөрүүдийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авч, онлайн тайлангийн дансны үлдэгдэл болох төсвийн хэлбэлзлийн тайлантай тулган шалгаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь нэгтгэн гаргаж, сар бүрийн 06-ны дотор Сангийн яаманд хэвлэмэл байдлаар хүргүүлж ажилласан. Сайдын багцын зарлагын өдөр тутмын гүйлгээний

баримтыг тухайн өдрийн нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган, мөнгөн дүнг нийлж архивын нэгжийг ажлын 3 хоногт багтаан меморалын баримт үйлдэж, архив үүсгэн ажиллаж байна. Жижиг мөнгөн сангийн гүйлгээг үндсэн баримтаар хянаж тулган шалгаж, гүйлгээг free balans программанд шивж оруулан мөн бэлэн мөнгөний дансны хуулгыг сар тутам хянаж тулган өдөр бүрийн гүйлгээний анхан шатны баримтыг тулган шалгаж, мемориал баримт бэлтгэн ажилласан. Сайдын багцын дансдуудын, дансны үлдэгдэл, гарын үсгийн баталгаа, жижиг мөнгөн санг хянаж тухайн байгууллагатай холбогдсон мэдээллийн баяжилтыг жил бүр, мөн хөдөлгөөн хийгдсэн тухай бүр шинэчлэн хяналт тавьсан.

Гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай, ханшийн эрсдэл багатай хийж гүйцэтгэх үүднээс онлайн программ хангамжийг ашиглан, Төрийн банк, Сангийн яам, Монгол банкаар дамжуулан хийж зарлага санхүүжилт нь цаг хугацаандаа хурдан шуурхай банк хооронд дамжигдаж байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд шивэгдсэн гүйлгээ банкны код болон гадаад, дотоод гүйлгээний төрлийг зөв шивсэн эсэхэд хяналт тавьж алдааг засах зэргээр ажилласан. 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс 2016 оны 12 дугаар сарын 27-ны байдлаар Эрчим хүчний сайдын багцад хамаарагдах 5 дансны нийт 1062 ширхэг буюу 179,183,637,748.⁷⁰ төгрөгийн зарлагын гүйлгээ банк хооронд дамжуулан хийгдсэн байна. Үүнд:

- Эрчим хүчний сайдын багцын урсгал 900030003 данснаас 19,811,879,690 төгрөгийн 715 зарлагын гүйлгээг,
- Эрчим хүчний сайдын багцын Хөрөнгө оруулалтын 900030305 данснаас 81,144,573,661 төгрөгийн 40 зарлагын гүйлгээг,
- Эрчим хүчний сайдын багцын барьцаа 900030402 данснаас 2,928,055,650 төгрөгийн 48 зарлагын гүйлгээг,
- Эрчим хүчний сайдын багцын нэмэлт сэнхүүжилтийн 900030403 данснаас 35,719,430,000 төгрөгийн 21 зарлагын гүйлгээг,
- Эрчим хүчний сайдын багцын Хөгжлийн банкны данснаас 900030600 данснаас 39,579,698,747.⁷⁰ төгрөгийн 238 зарлагын гүйлгээг тус тус банк хооронд дамжуулан хийгдэв.

Эрчим хүчний сайдын багцын хөрөнгө оруулалт болон барьцаа хөрөнгийн дансны санхүүжилтийн эрхийг онлайн программаар харж Сангийн яамны зарлагын хэлтэст цаг тухай бүрт санхүүжилтийг эрхийг нээлгэж ажиллаж байна.

4. Бусад үйл ажиллагааны талаар:

Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн бүр 2016 онд байгуулсан үр дүнгийн гэрээгээ хангалттай сайн биелүүлж газрын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100 хувийн биелэлттэй ажилласан байна.

Санхүүгийн хэлтсийн дотоод ажил үүргийн хуваарийн дагуу 7 хоногийн ажлын тайлан болон сарын ажлын тайланг ээлжлэн гаргаж, яамнаас зохиогдож байгаа олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцож ирлээ.

Шилэн дансны тухай хууль, МУ-ын ЗГ-ын 2014 оны 384 дүгээр тогтоолын дагуу Төрийн байгууллагын шилэн дансны мэдээллийн хүрээнд сарын бүрийн 8, 30-ны өдрийн дотор Shilendans.mn сайтын мэдээлэлд тогтмол байршуулж ажилласан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн гүйцэтгэлийг төсөл, арга хэмжээ тус бүрээр,
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн

аливаа шийдвэр, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтүүдийг,

- Эрчим хүчний яамны аппаратын 2015 оны жилийн эцсийн болон 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тус тус байршуулсан байна.

2016 онд тус яамны эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг 2 удаа хийж хөрөнгийн данс бүрээр үлдэгдлийг тоолж, эд хариуцагчийн картыг шинэчлэн баталгаажуулж, өрөө бүрийг бүрэн хаягжуулсан байна.

Эрхэлсэн ажлын чиглэлээр тус хэлтэс байгуулагдснаас/2016 ий 9 дүгээр сарын 1/ хойш 248 албан бичиг ирснийг тухай бүрд нь зохих журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэн удирдлагад танилцуулан хяналт тавин ажилласан бол 123 албан бичгийг боловсруулж явуулсан байна.

Дөрөв.Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр:

2016 онд шинээр байгуулагдсан Санамж бичгүүд:

1. “Монгол Улсын хий хангамжийн мастер төлөвлөгөө” боловсруулахад хамтран ажиллах санамж бичиг /2016.04.29/
2. “Нүүрснээс эрчим хүч гаргах болон нүүрс хийжүүлэн үйлдвэрлэх, эрчим хүч, хийг тээвэрлэн түгээх тогтолцоог хөгжүүлэх” санамж бичиг /2016.07.14/
3. “Эрчим хүчний салбар дахь хоёр орны хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай” санамж бичиг /2016.07.17/
4. “Монгол Улсад байгаль орчинд ээлтэй эрчим хүчний эко хотхон байгуулах туршилтын төсөл боловсруулах” санамж бичиг /2016.07.17/
5. “Өвөрхангай аймаг дахь Баянтээгийн нүүрсний ордын аман дээр байрлах нүүрсээр ажилладаг цахилгаан станцыг барих ТЭЗҮ боловсруулах” санамж бичиг /2016.07.18/

Эрчим хүчний сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад, дотоодын төлөөлөгчидтэй хийсэн нийт 82 уулзалтыг зохион байгуулсан.

Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай нийт 58 тушаалыг боловсруулж батлуулсан.

Гадаадад албан томилолтоор ажиллаж, оролцох албан тушаалтнуудын нийт 11 албан томилолтын төсвийг зохиож Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.

Төрийн бусад байгууллагуудаас ирүүлсэн нийт 92 албан бичгийг судлаж санал боловсруулж хүргүүлсэн.

2016 онд Эрчим хүчний яамны удирдлагуудын гадаадад, дотоодын төлөөлөгчидтэй хийсэн дараах уулзалтуудыг зохион байгуулсан:

1. Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын шугамаар хэрэгжиж буй Хоккайдо мужийн техник, технологийг Монгол улсад нутагшуулах төслийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.01.14/
2. 04 сарын 10-15-ны өдрүүдэд Пакистан улсын Исламабад хотноо зохион байгуулагдах Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын Эрчим хүчний

салбарын зохицуулах хорооны 21 дүгээр уулзалтад Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Э.Мөнхбилэг нар оролцов.

3. “Астана 2017” Дэлхийн Экспод бэлтгэх ажлын хэсгийн хуралд оролцож тулгамдаж буй асуудал, явцын талаар хэлэлцсэн.
4. Эрчим хүчний сайд Д.Зоригт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Чойрын орчимд 50 МВ-т хүчин чадалтай салхин цахилгаан станц байгуулах төслийг хэрэгжүүлж буй Айдинер Глобал ХХК-ийн толгой компани болон Айдинер Инсаат групп компанийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.03.02/
5. Эрчим хүчний сайд Д.Зоригт Дэлхийн банкны хэрэгжүүлж буй уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.03.02/
6. Эрчим хүчний сайд Д.Зоригт ОХУ-ын КРЕФИТ ХХК-ийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.03.02/
7. Айдинер Глобал ХХК-ийн толгой компани болох Айдинер Инсаат групп компанийн төлөөлөгчид Д.Зоригт сайдтай хийсэн уулзалт. /2016.03.02/
8. Эрчим хүчний сайд Д.Зоригт Казахстан улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд К.И.Кобландинтай хийсэн уулзалт. /2016.03.02/
9. Эрчим хүчний сайд Д.Зоригт чиглэл өгсөний дагуу ОХУ-ын КРЕФИТ ХХК-ийн төлөөлөгчид, ДЦС-3, ДЦС-4, ЦДҮС, УБЦТС, СХОГ-ын дарга, БХЗГ-ын дарга нарын хооронд мэдээлэл солилцох уулзалт. /2016.03.03/
10. Эрчим хүчний сайд Д.Зоригт БНХАУ-ын элчин сайд Шин Хайминтай хийсэн уулзалт. /2016.03.04/
11. Эрчим хүчний сайдтай ОХУ-ын Буриад улсын Сименс компанийн төлөөлөгчид 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ирж уулзсан бөгөөд сайдаас өгсөн үүргийн дагуу 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр дахин уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтаар Эрчим хүчний салбарт хамтран ажиллах боломж нөхцөлийн талаар талууд санал солилцсон.
12. Эрчим хүчний сайд Д.Зоригт БНСУ-ын Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд У Сунтай хийсэн уулзалт. /2016.03.07/
13. Эрчим хүчний сайд Д.Зоригт БНХАУ-ын Sinosure ХХК-ны төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.03.22/
14. Эрчим хүчний сайд Д.Зоригт Дэлхийн банкны Монгол Улсын бүс хариуцсан захирал Бэрт Хофмэнтэй Төрийн Ордонд хийсэн уулзалт. /2016.03.24/
15. Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж НАВЕСО компанийн төлөөлөгч Иван Николаевтай хийсэн уулзалт. /2016.03.28/
16. ХБНГУ-ын GIZ-д Аудитын шалгалт хийхээр ирсэн төлөөлөгчид ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогттой хийсэн уулзалт. /2016.03.31/
17. Сэргээгдэх эрчим хүчний долдугаар форумд эрчим хүчний сайд Д.Зоригт нээж үг хэлсэн. /2016.04.06/

18. Эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж дарга нар БНХАУ-ын Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ корпорацийн удирдлагуудтай хийсэн уулзалт. /2016.04.05/
19. Эрчим хүчний сайд Д.Зоригт ОХУ-аас Монгол Улсад Суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Азизовтой хийсэн уулзалт. /2016.04.06/
20. Эрчим хүчний сайд Д.Зоригт Өмнөговь аймагт Оюу Толгой уурхайг эрчим хүчээр хангах төсөл хэрэгжүүлж буй Юнайтэд Энержи Систем ХХК ний төлөөлөгчид болон төслийн гүйцэтгэлийг хариуцаж буй Канад улсын Хатч ХХК, БНХАУын Шанши Эрчим хүчний инженеринг ХХК-ний төлөөлөгч нартай хийсэн уулзалт. /2016.04.22/
21. Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын орлогч дарга Г.Энхтайван, Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга М.Ангараг нар ЖАЙКА болон ЕСБХБны хамтарсан төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.04.26/
22. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбаатар Франц Улсын Айрбус компанийн Зүүн Европ хариуцсан дэд Ерөнхийлөгч Jacques Garrigue-тэй хийсэн уулзалт/ 2016.04.28/
23. Төрийн нарийн бичгийн дарга Б.Намхайнямбуу Япон улсын Шизуока мужийн Гадаад харилцааны албаны дарга болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.06.08/
24. Эрчим хүчний сайд П.Ганхүү АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Женифер Зимдалтай хийсэн уулзалт болон Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Дэд ерөнхийлөгч доктор Ж.Пандиан тус банкны төлөөлөгчдийн хамт хийсэн уулзалтыг тус тус зохион байгуулж, холбогдох мэдээллийг хэвлэл мэдээлийн хэрэгслээр түгээсэн.2016 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Эрчим хүчний сайд П.Ганхүү Их Британы Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд хадагтай Катерина Арнолдийг хүлээн авч уулзан хоёр улсын хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт. /2016.08.11/
25. Эрчим хүчний сайд П.Ганхүү БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Шин Хайминийг хүлээн авч уулзаж хоёр улсын хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт. /2016.08.22/
26. Шивээ-Энержи төслийн хөрөнгө оруулагч болох БНХАУ-ын “Стейт Грийд” ТӨХК-ийн төлөөлөгчид албан ёсны айлчлалын хүрээнд Эрчим хүчний сайдтай 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдөр уулзаж хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт.
27. Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлагийн ахлах мэргэжилтэн Гурбуз Гонул, бүс нутаг хариуцсан мэргэжилтэн Ёонг Чен нартай 03 дугаар сарын 16-ны өдөр хийсэн уулзалт.
28. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг, Эрчим хүчний яамтай хамтран боловсруулсан “Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний салбарын бэлэн байдлын үнэлгээ” судалгааны тайланг хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгуулав.

29. Эрчим хүчний сайд Д.Зоригт БНХАУ-д “Дэлхийн эрчим хүчний холбоос” олон улсын хуралд 2016.03.29-04.02-ны өдрүүдэд оролцсонтой холбогдуулан ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийг ЗГ-ын хуралдаанд оруулж удирдамжийг МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгээр батлуулав.
30. “Астана экспо 2017” Олон улсын хуралдааныг зохион байгуулахад шаардлагатай 2016 оны төсвийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж албажуулав.
31. ТЗУГ-ын дарга М.Баярмагнай “Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга болон удирдах зөвлөлийн гишүүдийг хүлээн авч уулзсан уулзалт.
32. Сайд Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдыг хүлээн авч уулзсан уулзалт.
33. 2016.09.06. “Инвест Монголия” Чуулга уулзалтын “Дэд бүтцийн хөгжил” сэдэвт панельд Эрчим хүчний Дэд сайд Т. Гантулга оролцсон. Тус уулзалтын бэлтгэл ажил хангасан.
34. “Инвест Монголия” чуулга уулзалтын “Ногоон эрчим хүчний ирээдүй” сэдэвт панельд БТГ-ын дарга Д. Чимэддорж оролцсон. Тус уулзалтын бэлтгэл ажил хангасан.
35. Сайд Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч хадагтай Ломмэнийг хүлээн авч уулзаж хоёр байгууллагын хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт. /2016.09.08/.
36. Дэд сайд Белорусийн МАЗ компанийн суурин төлөөлөгчийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр МАЗ компанийн үйл ажиллагааны товч танилцуулга хийж, хамтран ажиллах хүсэлт тавьсан. Уулзалт зохион байгуулсан. /2016.09.12./
37. Дэд сайд “China Energy” ТӨХК-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр “China Energy” ТӨХК Монгол Улсад хөрөнгө оруулах хүсэлтээ илэрхийлсэн. Уулзалт зохион байгуулсан. /2016.09.12/
38. “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн шинээр томилогдож байгаа багийн ахлагч Юрий Мирошниченко, төслийн багийн ахлагч Хайри Ал Жамал нар төслийн хэрэгжилт, үйл явц, үр дүнгийн талаар Дэд Сайд Т.Гантулгатай хийсэн уулзалт. /2016.09.14/
39. Эрчим хүчний яамны Дэд сайд Т.Гантулга Хөх хотын “Паво” цахилгаан инженерийн дизайны зөвлөх компанийн Ерөнхий менежер Сүн Шаожүн болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.09.14/
40. ГХАХ-ийн дарга Р. Гантулга, ОХУ-ын Новосибирск хотод зохион байгуулагдах “Монголын өдрүүд-2016”-ын зохион байгуулагчдыг хүлээн авч уулзаж, тус арга хэмжээнд оролцох талаар санал солилцсон уулзалт. /2016.09.15/.
41. Дэд сайд “Энжи групп”-ын суурин төлөөлөгч болон Ази бүс хариуцсан Дэд ерөнхийлөгчийг хүлээн авч уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан уулзалт /2016.09.15/.
42. БТГ-ын дарга Д.Чимэддорж Европын Хөрөнгө Оруулалтын Банкны Бээжин дэх суурин төлөөлөгчийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр Сайншандын салхин паркттай холбоотой асуудлын талаар ярилцсан уулзалт /2016.09.19/
43. “Мишээл экспо”-ийн төлөөлөгч нар болон ОХУ-ын КОТЭС компанийн төлөөлөгчдийн ГХАХ-ийн дарга Р. Гантулга, ХОУХ-ийн дарга Б.Сугар болон холбогдох төлөөлөгчид хийсэн уулзалт /2016.09.21/

44. Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Дэд сайд Ким Хак До-гоор ахлуулсан айлчлалын багыг ТЗУГ-ын дарга хүлээн авч уулзсан уулзалт./2016.09.22/
45. Монгол улсад стандарчлалын төсөл хэрэгжүүлэгч РТВ институтын төлөөлөгчдийн БТГ-ын мэргэжилтэн Ж.Гэрэлтэй хамт хүлээн авч уулзаж, 10 сард зохион байгуулагдах семинар болон төслийн 2 дахь удаагийн уулзалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцсон.
46. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/, Бразил-Монголын анхдугаар бизнес уулзалтын дагуу хамтран ажиллах, эрчим хүчний чиглэлээр мэдээлэл авах зорилгоор ирсэн "Itarag" Парана мужийн Технологи, байгаль орчны хүрээлэнгийн захирал, Бразил-Монголын Худалдааны танхимын үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч Асеф Сайд-тай хийсэн уулзалт. /2016.09.22/
47. Мянганы сорилын сангийн 2-р компакт гэрээ байгуулах үндэсний ажлын албыг ТЗУГ-ын дарга М. Баярмагнай хүлээн авч уулзсан уулзалт /2016.09.28/
48. Ганхүү Европын Сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж цаашдаа ямар чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт. /2016.09.28/
49. Сайд П.Ганхүү ЖАЙКА-гийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, Цогтцэций станцын Санхүүгийн гэрээ байгуулагдсан явдалд баяр хүргээд цаашдаа эрчим хүчний салбарт хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцсан. /2016.09.28/
50. Бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Чимэддорж ЖАЙКА-гийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. /2016.09.30/
51. Дэд сайд Т.Гантулга ИБНИУлсын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан./2016.09.30/
52. Сайд П.Ганхүү Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны /ЕСБХБ/ Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Фил Беннет, Монгол дахь суурин төлөөлөгч Мэтью Ле Блан болон бусад төлөөлөгчидтэй эрчим хүчний салбарт үзүүлсэн дэмжлэг, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, сэргээгдэх эрчим хүчний талаар хийсэн уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөж газар хэлтсээс санал авч уулзалтыг бэлтгэв.
53. Дэд сайд Т.Гантулга Хятадын цахилгаан сүлжээний компани гүйцэтгэх захирал Жэн Ханвэй болон Эрчим хүчний экспортын Шивээ-Энержи төслийн багийхантай хийсэн уулзалт. /2016.10.03/
54. Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга М.Ангараг, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн М.Түмэнжаргал нар Дэхлийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, Дэлхийн банкны хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөрт ашиглах төслийн талаар санал солилцсон уулзалт. /2016.10.03/
55. Дулааны хэлтсийн дарга Т. Батдондог ЖАЙКА Хокайдогойн төлөөлөгчдийн хүлээн авч уулзаж, хөрсний дулаанаар хангасан хүлэмжийн төслийн явц, тулгарсан асуудлууд болон үр дүнгийн талаар санал солилцсон. /2016.10.04/
56. Сайд П.Ганхүү ОХУ-ын Крефит ХХК-ийн С.П.Думов, "Сервис Запад Энерго-монтаж" ХХК-ийн дэд захирал, "Дархантогтох" ХХК-ийн захирал нарын төлөөлөгчидтэй уулзсан уулзалтыг зохион байгуулав. /2016.10.11/

57. Эрчим хүчний сайд Казахстан улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд К.Кобландиныг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан. /2016.10.11/
58. Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга М.Ангараг Японы Олон Улсын Хамтын ажиллагааны банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, нарны цахилгаан станцын төслийн хэрэгжилтийн талаар санал солилцсон. 2016.10.13/
59. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан “Олон улсын санхүүгийн байгууллага”-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан./2016.10.18/
60. Дэд сайд Т.Гантулга Сайншандын салхин паркийн асуудлаар ХБНГУ-ын Ферростаал группын эзэн, гүйцэтгэгч зөвлөлийн гишүүн доктор Жон Бенжамин Шрейдөрийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.10.18/
61. Дэд сайд Т.Гантулга Сайншандын салхин паркийн асуудлаар ХБНГУ-ын “ENGIE” компанийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан. /2016.10.20/
62. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөрөнгө оруулалт, хөгжлийн яамны дэргэдэх “KAZNEX INVEST”, Үндэсний хөрөнгө оруулалтын агентлагийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан./2016.10.26/
63. Сайд П.Ганхүү “JIAYI Group”-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан. /2016.10.27/
64. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан NEDO төслийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.01/
65. Хөрөнгө оруулалт үйлчилгээний хэлтсийн дарга Б.Сугар Киргизстаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтаар төрийн үйлчилгээний нэгдсэн төвтэй хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон уулзалт.
66. Сайд П.Ганхүү Inner Mongolia Power Group-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.08/
67. Сайд П.Ганхүү АНУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Женифер Зимдал Галтыг төлөөлөгчдийн хамт хүлээн авч уулзсан уулзалт /2016.11.08/
68. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан ДЦС-5 төслийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.09/
69. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Чимэддорж Хүннү Ресурс компаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.09/
70. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Чимэддорж Дэлхийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.11/
71. Сайд П.Ганхүү Power China-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.14/
72. Дэд сайд Т.Гантулга State grid-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт./2016.11.15/

73. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.17/
74. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан Дэлхийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт./2016.11.14/
75. Сайд П.Ганхүү “Стейт Грид Ногоон эрчим хүч” ТӨК-ийн тэргүүн дэд захирал Ли Жие болон төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.18/
76. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан “Хэманн” компани, “Миреко” компани болон “Би Жи Паур” компанийн төлөөлөгчдийг тус тус хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.21/
77. Сайд П.Ганхүү “Gezhouba” группын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.22/
78. Сайд П.Ганхүү Марубины төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалт. /2016.11.24/
79. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Чимэддорж “Инвест Монголиа Токио” чуулган нь 2016 оны 12 дугаар сарын 7-8-ний өдрүүдэд зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан Фронтир ҮЦК ХХК-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтыг зохион байгуулсан
80. Сайд П.Ганхүү Euros Goldstone Group –ийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.12.05/
81. АСЕМ-ийн цогцолборт зохион байгуулагдсан Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны 20 дугаар хуралдааны Шадар сайдын зангиагүй уулзалтад Дэд сайд оролцсон ба Эгийн голийн төслийн танилцуулга хийгдсэн. Протокол бэлтгэл хангасан.
82. Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан “NEDO”-ийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт. /2016.12.19/

Дараах тушаалуудыг батлуулсан:

1. Энэтхэг улсаас олгох 1 тэрбум ам. долларын хөнгөлөлттэй зээлийн шугамын талаар Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж Энэтхэг улсын Шинэ Дели хотод томилолтоор ажиллах тушаалыг 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдөр гаргуулав.
2. Дэд сайд Сингапур улсад Эрчим хүчний долоо хоногийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Эрчим хүчний форум”-д оролцох тухай Сайдын тушаал гаргасан.
3. “Монгол-Хятад-Солонгос-Япон цахилгаан сүлжээний нэгдсэн холболт төсөл”-ийн ажлын хэсгийн 3 дугаар уулзалтын тушаал/ 2016.09.12-13/
4. “БНХАУ-ын тав дахь удаагийн Ази-Европын үзэсгэлэн экспо – Техник технологийн хамтын ажиллагааны бизнес форум”-д оролцох тушаал /2016.09.20-23/
5. “Аж үйлдвэр, байгууламж дахь эрчим хүчний үр ашиг” сэдэвт олон улсын сургалт семинар /2016.09.26-10.10/
6. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар 26 тушаалыг батлуулсан.
7. БНСУ-д зохион байгуулагдах “Эрчим хүчний ухаалаг сүлжээ экспо”-д С.Цэрэнжамц даргыг оролцуулах тухай албан томилолтын тушаал батлуулсан.

8. “Эрэлт талын эрчим хүчний үр ашиг” сэдэвт хурал, семинарт оролцох тушаал.
9. “Олон улсын цахилгаан техникийн хорооны 80 дахь удаагийн ерөнхий чуулган” оролцох тушаал.
10. БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан “2016 оны Монгол Улсыг дэмжих бодлого болон төслийн удирдагчийн семинар”-т оролцох тушаал
11. УИХ-ын даргын БНХАУ-д 2016 оны 10 дугаар сарын 13-19-нд хийсэн албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Эрчим хүчний сайд орж, тус улсад ажилласан.
12. Сэргээгдэх эрчим хүч, мэргэжилтэн сургах 4 дүгээр ээлжийн сургалт
13. “Great Tumen Initiative (Их Түмэн Санаачилга) ТУЗ-ийн хурал болон Зүүн хойд азийн эрчим хүчний форум”-д оролцох тушаал
14. “Сингапур Улсын эрчим хүчний 7 хоног арга хэмжээ”-нд оролцох тушаал
15. “Далайд гарцгүй орнуудад бүтээлч түншлэлийг хөгжүүлэх замаар бүх нийтийг тогтвортой эрчим хүчээр хангах нь” сэдэвт өндөр түвшний уулзалтад оролцох тушаал
16. “Төв азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага” (CAREC)-ын Эрчим хүчний хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцох тушаал
17. Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний харилцан холболт, хамтын ажиллагааны форум – 2016 (Northeast Asian Energy Interconnection Forum) оролцох тушаал
18. “Эрчим хүчний ирээдүй” – Ази номхон дайлан орнуудын дээд хэмжээний уулзалт (Future of Energy APAC Summmit) оролцох тушаал
19. “Нэг бүс нэг зам” дагуух нутгуудын эрчим хүчний салбарын нарийвчилсан сургалтад оролцох тушаал.
20. Сэргээгдэх эрчим хүчний сургалтад оролцох тушаал.
21. Монгол-Хятад-Солонгос-Япон цахилгаан сүлжээний нэгдсэн холболт төслийн ажлын хэсгийн 4 дүгээр уулзалтад оролцох тушаал.
22. ДЦС-4 ТӨХК-ийн зуухны үнс үнэлгээний төхөөрөмжийн ажлын хүрээнд Mitsubishi Hitachi, Power systems компанийн туршлага судлах тушаал.
23. Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC) оролцох тушаал.
24. Монгол-Германы хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрт оролцох тушаал.
25. Эрчим хүчний Харт 27 дахь удаагийн хурал, Эрчим хүчний сайд нарын уулзалтад оролцох тушаал.
26. “Тавантолгойн цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажиллах тушаал.
27. Сэргээгдэх эрчим хүчний хамрах хүрээг нэмэгдүүлэх дэд хорооны уулзалтад оролцох тушаал.
28. Байгаль орчны байнгын хяналтын системийг (CEMS) ашиглах семинарт оролцох тушаал.
29. Монгол-Германы ЗГ-ийн комиссийн уулзалт, хурал, “Эрчим хүчний долоо хоног”, УИХ-ын даргын айлчлалд ажиллах тушаал.

30. УИХ-ын даргын айлчлалд ажиллах тушаал.
31. “4 дэх Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдлын форум” оролцох тушаал.
32. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн дугаар 50 тушаалыг батлуулсан.
33. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дугаар 40 тушаалыг батлуулсан.
34. БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 10 дугаар сарын 20-21-ний хооронд зохион байгуулагдах ГТІ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон Зүүн хойд азийн эрчим хүчний форумд оролцох бүрэлдэхүүний У.Мэргэнбаяр гэснийг И.Лувсанцэрэн гэж өөрчлөх тухай тушаалыг боловсруулж гаргасан.
35. БНХАУ-ын Бээжин хотноо 2016 оны 10 дугаар сарын 13-15-ний өдрүүдэд зохион байгуулагдах “2016 Бүс болон Зам” чуулга уулзалтад тус яамны төлөөлөлийг оролцуулах тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг гаргасан.
36. БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 10 дугаар сарын 20-21-ний хооронд зохион байгуулагдах ГТІ-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон Зүүн хойд азийн эрчим хүчний форумд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Чимэддорж, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ийн захирал С.Бүрэнтогтох, Сайдын орон тооны бус зөвлөх У.Мэргэнбаяр нарын гадаад томилолтын тушаалын төслийг боловсруулав.
37. “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ийн удирдлага өөрчлөгдсөнтэй холбогдуулан БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 10 дугаар сарын 20-21-ний хооронд зохион байгуулагдах ГТІ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон Зүүн хойд азийн эрчим хүчний форумд оролцох бүрэлдэхүүний С.Бүрэнтогтох-ыг Ч. Саранжав гэж өөрчлөх тухай тушаалыг боловсруулж гаргасан.
38. БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 10 дугаар сарын 20-21-ний хооронд “Зүүн Хойд Азийн Эрчим хүчний форум”-ын хүрээнд байгуулагдсан Экспертүүдийн ажлын хэсгийн хуралд Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Ерэн-Өлзийг зохион байгуулагч талын зардлаар оролцуулах тухай тушаалыг боловсруулж гаргасан.
39. Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын Исламабад хотноо 2016 оны 10 дугаар сарын 21-26-ны хооронд зохион байгуулагдах Төв Азийн Бүсийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллага / CAREC /-ын Эрчим хүчний хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Сугар, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б. Ерэн-Өлзий нарыг тус тус зохион байгуулагч талын зардлаар оролцуулах тухай тушаалыг боловсруулж гаргасан.
40. Эрчим хүчний сайдын БНХАУ-ын Бээжин хотноо 2016 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний харилцан холболт, хамтын ажиллагааны форум 2016”-д оролцох албан тушаалтнуудын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 51 тушаалыг батлуулсан.
41. БНХАУ-ын Бээжин хотноо 2016 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний харилцан холболт, хамтын ажиллагааны форум

2016"-д оролцох албан тушаалтнуудын албан томилолтын төсвийг зохиож, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.

42. Төрийн нарийн бичгийн даргын АНУ-ын Вашингтон хотноо 2016 оны 12 дугаар сарын 05-11-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Уур амьсгалын өөрчлөлт” хуралд оролцох албан тушаалтны Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 113 дугаар тушаалыг батлуулсан.
43. Төрийн нарийн бичгийн даргын БНСУ-ын Сөүл хотноо 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдах “4 дэх Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдлын форум”-д оролцох албан тушаалтны Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 114 дүгээр тушаалыг батлуулсан.
44. Төрийн нарийн бичгийн даргын ХБНГУ-ын Тройздорф хотноо 2017 оны 1 дүгээр сарын 15-22-ны өдрүүдэд Кинетикийн цахилгаан станцын үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжүүдтэй танилцах, эрчим хүчний салбарт усны түлхэх хүчийг ашиглан цахилгаан эрчим хүч гаргах дэвшилтэт шинэ технологийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахад оролцох албан тушаалтны Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 145 дугаар тушаалыг батлуулсан.
45. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 21 дүгээр тушаал.
46. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 50 дугаар тушаал.
47. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 40 дугаар тушаал.
48. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дугаар 51 тушаал: БНХАУ-ын Бээжин хотноо 2016 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний харилцан холболт, хамтын ажиллагааны форум 2016”.
49. Төрийн нарийн бичгийн даргын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 78 дугаар тушаал: БНСУ-ын Гуанжу хотноо 2016 оны 11 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Монгол-Хятад-Солонгос-Япон цахилгаан сүлжээний нэгдсэн холболт төсөл”-ийн ажлын хэсгийн 4 дүгээр уулзалт.
50. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 67 дугаар тушаал. БНХАУ-д 2016 оны 11 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр ажиллах ажлын хэсэг.
51. Эрчим хүчний сайдын Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 71 дүгээр тушаал.
52. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 77 дугаар тушаал. Япон улсын Токио хотноо 2016 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах “27 дахь удаагийн Эрчим хүчний Харт болон яамдуудын уулзалт”

53. Эрчим хүчний сайдын Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 100 дугаар тушаал.ХБНГУ-ын Берлин хотноо 2016 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Монгол-Германы хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээр”
